



Нүүдэллэх эрхийг баталгаажуулах нь:

Малчид болон нүүдэлчдийн нүүдэллэх,
газар ашиглах эрхийн эрх зүйн баталгаа



Supports the



INTERNATIONAL YEAR OF
RANGELANDS AND
PASTORALISTS
2026

ТАЛАРХАЛ	2
ГОЛ ҮР ДҮН	3
ЗӨВЛӨМЖ	5
1. Танилцуулга	6
2. Арга зүй	7
3. Газар ашиглах тогтолцоо: Газар ашиглах эрхийн эрх зүйн зураглал	8
4. Нүүдэллэх эрх	10
5. Газар ашиглах болон мал аж ахуй эрхлэх эрх	13
6. Малчид болон нүүдэлчдийн эрхийн хэрэгжилт	19
7. Нүүдэллэх, газар ашиглах эрхийг хэрэгжүүлэх уламжлалт тогтолцоо	24
8. Зөвлөмж	28

КЕЙС СУДАЛГАА

АЗИ	Татварын дарамтын эсрэг отрын малчдын тэмцэл, Балба улс	30
	Уул уурхайд шахагдан бэлчээрээ алдсан нь: Малчин эмэгтэйн газрын эрхийн төлөөх тэмцэл, Монгол улс	35
АФРИК	Бажада дахь бэлчээрийн бүсэд бэлчээр ашиглах олон нийтийн менежмент, уламжлалт механизмууд, Нигери улс, Матанкара орон нутгийн захиргаа	40
	Нүүдэллэх баталгааг хангах нь: Малчин эмэгтэйчүүдийн инноваци ба газрын засаглал, Танзани улс	44
	Малчдын нүүдэллэх, газар ашиглах, эзэмших эрхэд тулгамдаж буй асуудал, Кени улс	49
ЛАТИН АМЕРИК	Бэлчээрийн хуваагдал ба мал аж ахуйн тогтворгүй байдал: Айлью Кари Бажагийн кейс, Болива улс	54
	Гварани олон нийтийн усны нөөц, бэлчээрийн засаглал дахь жендэрийн ялгаа, Болива улс	59
	Паскогийн хөдөө, орон нутгийн засаглал: Малчин эмэгтэйчүүдийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээл, Перу улс	63

Талархал

Зохиогчид тайланд дурдагдаж буй судалгаа мэдээлэл, дүн шинжилгээнд хувь нэмрээ оруулсан дараах хувь хүн, байгууллагуудад талархлаа илэрхийлж байна.

Энэхүү тайлан нь Эрх болон нөөцийн санаачилгын (RRI) түншүүд, эвслийн гишүүд, Андын нурууны уугуул иргэдийн байгууллагуудын зохицуулах хороо (CAOI), Уугуул иргэдийн амьжиргааг дэмжих түншүүд (ILEPA), Майнойто бэлчээр эрхлэгчдийн нэгдсэн хөгжлийн байгууллага (MPIDO), Хил хязгааргүй алхам ТББ, хамтран ажиллагсад, бие даасан зөвлөхүүд, үндэсний шинжээчид болон RRI-ийн Хэрэг эрхлэх газрын ажилтнууд зэрэг олон хувь хүн, байгууллагын хамтын ажиллагааны үр дүн юм.

Мөн эрх эзэмшигчдийн төлөөлөл, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудын олон талт хамтын ажиллагаагүйгээр тайлангийн үр дүнг төсөөлөх аргагүй.

Мэдээлэл дүн шинжилгээ, тайлбар жишээ, кэйс судалгаа бүхий уг тайланг Изабел Давила Перейра, Стэнли Кимарен Оле Риамит, Кенейа Паркире, Луис Виттор, Арминда Веласко Торрез, Лурдес Байгорриа Гузман, Энн Саманте, доктор Амаду Чарифи Рабиоу, Др. Эпифания Нгови, Нима Секи, Дил Раж Ханал, Анила Онта, Пабиханг Рай, Нима лам, Намсрайн Баярсайхан, Доктор Ариэлл Ахерн, Жеремиа Гилберт болон нэрээ нууцлахыг хүссэн бусад хүмүүс хамтран боловсрууллаа. Кейс судалгааны зохиогчдыг харгалзах хэсэг бүрд дурдсан болно. Түүнчлэн, Ален Фрешетт тайланг хянан тохиолдуулж, техникийн зөвлөгөө өгч, Николь Харрис эх бэлтгэлийг гүйцэтгэж, Лукас Вассон, Кэти Константин, Тесса Мартин нар харилцаа холбооны дэмжлэг үзүүлэв.

Хамтран ажиллагсдын нэр дутуу оруулсан бол энэ нь санамсаргүй алдаа бөгөөд уг алдааг зохиогчид хариуцна.



ГОЛ ҮР ДҮН

1. Судалгаанд хамрагдсан бүх улсад малчид болон нүүдэлчдийн суурь эрх болох нүүдэллэх эрхийг баталгаажуулаагүй байна. Зөвхөн Нигери улс л нүүдэллэх болон оторлох бол малчдын суурь эрх хэмээн онцгойлон хуулиар хүлээн зөвшөөрчээ.

2. Газар ашиглах эрх зүйн зохицуулалт нь газар ашиглалтыг бодитоор хамгаалахгүй байна. Судалгаанд хамрагдсан долоон улс бүгд бэлчээр ашиглах эрхийг ямар нэг байдлаар хуульчилсан ч бусад салбарын бэлчээр ашиглах халдлагаас малчид, нүүдэлчдийг бүрэн хамгаалж чадахгүй байна.

3. Долоон улс бүгд малчид болон нүүдэлчдийн газар ашиглах эрхийг баталгаажуулсан эрх зүйн тогтолцоотой. Гэвч эдгээр тогтолцоо нь малчдын эрхийг тэгш, цогц байдлаар хамгаалж чадахгүй буюу ихэнх улс орнууд бэлчээрийн газар ашиглах эрхийг суурин иргэншил эсвэл бүтээмжид суурилсан өнцгөөс харж, малчдын уян хатан болоод хамтын амьжиргааны онцлогийг орхигдуулсан байна. Ганц онцгой тохиолдол болох Нигер улс бэлчээрийн бие даасан хуульдаа бэлчээр болон отрыг бэлчээр ашиглах тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэмээн тодорхойлжээ. Долоон улс бүгд Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцыг (CEDAW) соёрхон баталсан ч тэдний аль нь ч эмэгтэйчүүдийн нүүдэллэх эрхийг баталгаажуулсан тусгайлсан хууль эрх зүйн хамгаалалт байхгүй байна. Зөвхөн Кени, Боливи улсуудад л эмэгтэйчүүдийн газар, байгалийн баялаг ашиглах эрхийг зарим байдлаар хуульчилжээ.

4. Нүүдэллэх эрхэд тулгарч буй саад бэрхшээл нь улс орон бүрийн онцлогоос хамаарсан бүтцийн шинжтэй, экосистемийн бүхий л талбарыг хамарсан өргөн хүрээний асуудал болж байгаа ба уг нөхцөл байдал улам дордсоор байна. Судалгаанд хамрагдсан долоон улсын нүүдэл хөдөлгөөнд газар тариалангийн тэлэлт, олборлох үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжил, тусгай хамгаалалтад авсан байгалийн цогцолбор газар болон түүний тэлэлт, зөрчил мөргөлдөөнөөс үүдэлтэй

газар нутгаа алдах явдал, мөн өсөн нэмэгдэж буй нүүрс төрөгч, ногоон төслүүд хамгийн их саад учруулж байна. Үүнээс болж эмэгтэйчүүд хүйсээс шалтгаалсан олон давхар саад бэрхшээлтэй нүүр тулж байна.

5. Нигерээс бусад бүх улсад малчдын газрын эрхийг бүртгэх, эрхийн бичиг/гэрчилгээ олгох, эсвэл хоршооны гишүүнчлэлтэй болгох зэрэг хууль ёсны эзэмшил олгох үйл явц олон шат дамжлагатай байна.

Тодруулж хэлбэл, бүх орны малчид мөнгө, цаг хугацаа, захиргааны хүчин чадлаас үүдэлтэй зардал гаргах шаардлагатай болж байна.

6. Ихэнх малчдын хувьд газар ашиглах уламжлалт зохицуулалт нь засаглалын үндсэн суурь хэвээр байна. Гэвч судалгаанд хамрагдсан долоон улсын хоёрт уг уламжлалт тогтолцоог хуулиар хамгаалаагүй байна.

Энэ байдал нь ялангуяа малчид, тэр дундаа малчин эмэгтэйчүүд уг тогтолцоонд хамгийн их хохирч бас хамгаалалтгүй үлдэхэд хүргэжээ. Зарим улс орнууд үндсэн хууль болон бусад хуулиудаараа жендэрийн тэгш байдлыг зохицуулж байгаа ч, малчин, нүүдэлчин эмэгтэйчүүдийн асуудлыг зохицуулсан тусгайлсан хамгаалалт ховор байна. Судалгаанд хамрагдсан бүх улсад эмэгтэйчүүдийг бүрэн хамгаалах эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь жендэрийн хэвшмэл ойлголтоос үүдэлтэй эрхийн зөрчлөөс эмэгтэйчүүдийг хамгаалж чадахгүй орхигдуулжээ.

7. Улс орнууд малчдын амьжиргааг дэмжих бодлоготой ч бодит хэрэгжилт хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдсан улс орон бүрд малчдад чиглэсэн хамгийн багадаа нэг төрийн байгууллага, хөтөлбөр, төсөв байгаа хэдий ч тэдний ихэнх нь суурин амьдралын хэв маяг, газар тариалан эсвэл малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд анхаарч, бодлого болон практик дээрх хэрэгжилтийн зөрүү хол хэвээр байна.

ЗӨВЛӨМЖ

- Малчид болон нүүдэлчдийн шилжилт хөдөлгөөнийг, тэр дундаа хил дамнасан нүүдлийг тэдний суурь эрх болгон хуульчлах. Хил дамнасан шилжилт хөдөлгөөний тогтолцоог сайжруулж, хуулиар хамгаалах. Засгийн газрууд бүс нутгийн болон хоёр талт хил дамнасан нүүдэл зохицуулах гэрээ хэлэлцээрийг соёрхон баталж, дотоодын хууль тогтоомжид тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай.
- Малчдын нүүдлийн орон зай, усны эх үүсвэр, улирлын шинжтэй бэлчээрийн газар, нүүдэл хөдөлгөөний хил хязгаарыг хуульчлан тогтоож, хамгаалах
- Газар ашиглах уламжлалт засаглалын тогтолцоог хүлээн зөвшөөрч, хуулиар хамгаалах. Малчдын ашигладаг уламжлалт газар ашиглах гэрээ хэлэлцээрийг албан ёсоор хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх, түүнд чиглэсэн тусгайлсан эрх зүйн механизм бүрдүүлэх. Малчид, нүүдэлчдэд захиргааны хэт их дарамт учруулахгүй байхад анхаарч, тэдний оролцоогүйгээр уламжлалт тогтолцоог хэрэгжүүлэхгүй байх
- Малчин эмэгтэйчүүдийн шилжилт хөдөлгөөн, газар ашиглах эрх, засаглалын оролцоог баталгаажуулсан тусгайлсан хууль тогтоомжтой болох
- Малчид, нүүдэлчдийн эрхийг шууд зөрчиж буй төсөл хөтөлбөрүүдийн зөвшөөрлийг нэн даруй цуцлах
- Малчид, нүүдэлчдийн хараат бусаар, урьдчилан мэдээлсний үндсэн дээр зөвшөөрөл авах эрхийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх
- Малчид, нүүдэлчид газрын эрхээ баталгаажуулахтай холбоотой санхүү, бүртгэл, албажуулалтын дарамт, шаардлагуудыг багасгаж шинэчлэх
- Уур амьсгалын санхүүжилт, байгаль хамгаалал, "ногоон хөгжил"-ийн тогтолцоог хүний эрхэд суурилсан хандлагад нийцүүлэх
- Малчид, нүүдэлчдийн онцлогт тохирсон дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх. Малчид, тэр дундаа эмэгтэйчүүд, залуучуудын оролцоотойгоор аливаа шийдлийг боловсруулах.
- Уламжлалт болон албан ёсны засаглал дахь эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх. Эмэгтэйчүүдийн оролцооны квот тогтоох, тэдний оролцоог хангасан сайн туршлагыг баримтжуулах замаар өргөн хүрээний эрх зүйн шинэчлэл хийх

Нүүдэллэх эрхийг баталгаажуулах нь: Малчид болон нүүдэлчдийн нүүдэллэх, газар ашиглах эрхийн эрх зүйн баталгаа

Кени, Нигер, Танзани, Монгол, Балба, Боливи, Перу улсуудын харьцуулсан дүн шинжилгээ

1. Танилцуулга

Дэлхий дахинд хагас тэрбум малчид амьдардаг бөгөөд тэдний 1.3 тэрбум орчим нь бэлчээрийн мал аж ахуйгаас үр шим хүртэж амьдардаг гэсэн тооцоолол бий. Түүнчлэн, бэлчээрийн газар нь дэлхийн хуурай газрын хамгийн их хэсгийг эзэлдэг газар ашиглалтын төрөл юм. Мал аж ахуйн салбар нь хүн амьдардаг тивийн 100 гаруй улс орны иргэдийн амьжиргааг залгуулдаг ч хүн төрөлхтөн мал аж ахуй болон бэлчээр нутгийн ач холбогдлыг түүхэндээ дутуу үнэлж, хангалттай хүлээн зөвшөөрөхгүй ирсэн билээ.

Малчид болон нүүдэлчид¹ нь уламжлалт мэдлэг, байгаль орчинд дасан зохицох туршлагаараа дамжуулан Африк, Ази, Латин Америкийн бэлчээрийн экосистемийг хэдэн мянган жилийн турш тогтвортой хадгалж, тэтгэж ирсэн билээ. Малчдын нүүдэлчин амьжиргааны хэв маяг нь нүүдэл хөдөлгөөнийг нийгмийн зохион байгуулалтын гол цөм гэж үздэг түүхэн уламжлал, баялаг зан заншлын тогтолцоонд тулгуурладаг. Харамсалтай нь тэдний нүүдэллэх амьдралын хэв маягт газар тариалан, байгаль хамгаалах бодлогын тэлэлт, газар хувьчлал, ялгаварлан гадуурхсан бодлого, газар ашиглалтын давхцал, газрын зориулалт өөрчлөх, шийдвэр гаргах үйл явцаас гадуурхахаас үүдэлтэй аюул занал улам нэмэгдэж байна. Малчдад тулгарч буй эдгээр асуудал улам хурцдаж байгаа нь малчдын эрхийг хамгаалах хууль эрх зүйн зохицуулалт сул, төрөөс хууль ёсны газар эзэмшил, ашиглалтыг зохицуулахдаа нүүдэлчдийн амьжиргааны онцлог² бүрэн нийцүүлээгүй зэрэг тэднийг ялгаварлан гадуурхаж ирсэн урт удаан түүхтэй салшгүй холбоотой.

2026 оныг **"Олон улсын бэлчээр ба малчдын жил"** (ОУБМЖ) болгон тунхагласан нь малчид болон нүүдэлчдийн газар эзэмшлийн эрхийн өнөөгийн байдлын талаар нотолгоо мэдээлэл цуглуулах, мөн тэдний газар эзэмшлийн баталгаа, нүүдлийн амьжиргааг баталгаажуулах нөлөөллийн ажлаа эрчимжүүлэх чухал боломж болж байна. "Газар эзэмших баталгаа" гэх нэр томъёог газар өмчлөлийн тогтсон хил хязгаар гэж тайлбарлаж болох ч уг тайлбар нь нүүдлийн мал аж ахуйн онцлогт төдийлөн нийцдэггүй. Учир нь газар эзэмших (хамтын эзэмшил байсан ч) гэсэн ойлголт нь малчдын ертөнцийг үзэх үзэл, уламжлалд нь байдаггүй. Улс орнуудын засгийн газрын хэрэгжүүлж буй газар эзэмшлийн баталгаа нь ихэнхдээ хувьчлалын нэг хэлбэр болж хувирсан. Үүний улмаас газар нутгийг уян хатан, уламжлалт хэлбэрээр ашиглаж ирсэн малчид хязгаарлагдмал газар нутаг ашиглахад

Энэхүү товхимол, холбогдох арга зүй, кэйс судалгаануудад "малчид" гэх өргөн хүрээний утга санааг агуулсан тодорхойлолт ашиглаж байгаа бөгөөд уг тодорхойлолтод нүүдэлчин, хагас нүүдэлчин, бэлчээрийн малчид, мал аж ахуй эрхлэгчид, түүнчлэн сайн дураараа өөрсдийгөө тусгаарлан анхдагч харилцаа холбоонд амьдарч буй уугуул иргэдийг хамруулан ойлгоно.

Энэхүү тайланд дурдагдаж байгаа "газар эзэмших баталгаа" (tenure security) гэдэг ойлголт нь өмчлөл, суурин иргэншил эсвэл хувийн өмчийн загварыг илэрхийлээгүй болно. Бэлчээрийн мал аж ахуйн тогтолцооны өвөрмөц бодит байдлыг тусган шинэчилсэн ЭНС-ийн "Эрхийн багц" тогтолцоонд тулгуурлан, газар ашиглах баталгааг малчдын нүүдэл хөдөлгөөн, бэлчээрийн газар нутгийг дундаа ашиглах боломж, хамтын засаглал болон нөөцийг харилцан ашиглах эрхийн хүчин төгөлдөр байдал, хэрэгжих чадвар гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл, малчид улирлын чанартай чөлөөтэй нүүдэллэх, ус болон хөрсийг уламжлалт болон зөвшилцлийн гэрээнд үндэслэн өөрсдийн шийдвэр гаргах засаглалаар дамжуулан хамтран ашиглах явдал бөгөөд тодорхой газар нутгийн хил хязгаарт албадан бүртгүүлэхээс ангид байх эрх юм.

хүрч, улмаар дундын нөөц хуваагдан, бэлчээрийн доройтолд хүргэж байна. Энэхүү тайлангаар дамжуулан бид малчид, нүүдэлчдэд зориулсан хүний эрхэд суурилсан, бэлчээрийн тогтолцооны өвөрмөц байдал, уламжлалт амьжиргааны онцлогийг тусгасан эзэмшлийн баталгааны тухай өгүүлнэ.

Тайланд Африк, Ази болон Латин Америкийн долоон улсын малчид, нүүдэлчид болон эмэгтэйчүүдийн нүүдэл хөдөлгөөн хийх, газар ашиглах эрх, түүнд тулгарч буй саад бэрхшээл, хэрэгжилтийн асуудлыг судалсан үр дүнг товч танилцуулав. Мөн малчдын бодит амьдралын нөхцөл байдлыг илэрхийлсэн найман кэйс судалгааг багтаалаа. Эдгээр кэйс судалгаануудад малчид, нүүдэлчдэд тулгарч буй сорилт бэрхшээл болох хүний эрхийн зөрчлүүд, түүнийг даван туулах стратеги, энэ нөхцөл байдал дахь эмэгтэйчүүдийн эрхийн асуудлуудыг шигтгэн орууллаа.

2. Арга зүй

Эрх болон нөөцийн санаачилга (ЭНС) байгууллага нь хүний эрхийн нөхцөл байдлыг салбар хоорондын уялдаа холбоо, байгаль орчны экосистемтэй хослуулан судалсаар ирсэн. Уг хүчин чармайлтын хүрээнд малчид, нүүдэлчдийн нүүдэл хөдөлгөөн, газар эзэмших эрхийн баталгаа, түүнчлэн эдгээр бүлэг дэх эмэгтэйчүүдийн эрхийг үнэлэх цогц арга зүйг³ боловсруулах зорилгоор өргөн хүрээний зөвлөлдөх уулзалт, түншлэлийг зохион байгууллаа. Уг зөвлөлдөх үйл явцад эрх эзэмшигч бүлгүүд, салбарын экспертүүдээс гадна тухайн олон нийтийн дундах эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах талуудыг идэвхтэй оролцуулсан болно.


боловсруулах зорилгоор эрх эзэмшигч бүлгүүд, салбарын шинжээчидтэй өргөн хүрээний зөвлөлдөх уулзалт хийж, хамтран ажиллав. Судалгааны арга зүй нь судалгаанд хамрагдсан улс орнуудын малчид, нүүдэлчдийн одоогийн эзэмшлийн тогтолцоог тодорхойлж буй хүчин төгөлдөр хууль тогтоомж, дүрэм журам, бодлогын баримт бичгүүдэд голлон төвлөрсөн болно. Улмаар дээрх эзэмшлийн тогтолцооны зохистой байдлыг тухайн орны онцлог нөхцөл болон холбогдох хуулиудын бодит хэрэгжилттэй харьцуулан үнэлэв. Эцэст нь, үр дүнгийн бодит бөгөөд найдвартай байдлыг хангах үүднээс мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг тухайн улс орны дотоодын шинжээчид дагнан гүйцэтгэж, дүн шинжилгээний нэгдсэн зарчмыг чанд баримтлан ажиллалаа.


Тайланд малчид болон нүүдэлчдийн эрхийг хууль тогтоомжид хэрхэн баталгаажуулсан байдалд хийсэн дүн шинжилгээ хийж: Боливи, Кени, Монгол, Балба, Нигер, Перу, Танзани гэсэн долоон улсын кэйс судалгааны үр дүнг оруулсан. Малчдын эрхийг тухайн орны хууль тогтоомжийн үүднээс судалсан ч тэдний олон нийтэд түшиглсэн-эрх нь заяагдмал шинжтэй байдаг тул төрөөс түүнийг үгүйсгэх боломжгүй гэдгийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Малчдын нүүдэл хөдөлгөөн, амьжиргаагаа хэрхэн зохион байгуулж амьдардаг онцлогийг тусгах үүднээс хууль эрх зүйн зохицуулалтад хийсэн албан ёсны шинжилгээг тухайн нөхцөл байдал, хэрэгжилтийн бодит үр дүнтэй уялдуулан авч үзлээ. Малчдын эрх, засаглалын тогтолцоо нь энд судалж буй эрх зүйн хүрээнээс ч өмнө бие даан оршиж байсан гэдгийг дурдах шаардлагатай. Тус судалгаа нь өнөөгийн бодит нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор бэлчээрийн малчдын уламжлалт эрх, амьжиргаанд тулгарч буй гол саад бэрхшээлийг тодорхойлох, түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ, хууль эрх зүйн шинэчлэл болон зорилтот арга хэмжээг санал болгохыг зорив.

3. Газар ашиглах тогтолцоо: Газар ашиглах эрхийн эрх зүйн зураглал


Малчдыг бие даасан эрх эзэмшигч болохыг нь хүлээн зөвшөөрч, суурь эрхийг нь дээдэлсэн дотоодын эрх зүйн тогтолцоо нь "Олон улсын бэлчээр болон малчдын жил-2026"-ийн гол зорилтууд болох малчид, тэдний тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, дэмжлэг үзүүлэхэд чухал үүрэгтэй билээ⁴.

Туршилтын судалгаанд хамрагдсан долоон улсад малчдыг бие даасан эрх эзэмшигч гэдгийг дараах гурван байдлаар хүлээн зөвшөөрч байна:

 **Боливи, Кени, Балба, Перу, Танзани** улсуудад малчдыг уугуул иргэд эсвэл тухайн орон нутгийн олон нийтийн хамтын эрх бүхий газар эзэмшлийн тогтолцоонд хамруулдаг. Эдгээр орнуудад тухайн орон нутгийн иргэд/олон нийтийн гишүүн байх нь малчид, нүүдэлчдийн эрхийг хүлээн зөвшөөрөх хууль эрх зүйн үндэс болж байна. Дээрх улс орнуудад газар эзэмших хамтын эрхийг тодорхой хэмжээнд хуульчилсан ч эрхэд суурилсан хандлага гэхээс илүүтэй мал аж ахуйг бүтээмжийн өнцгөөс харж, тэдний газар ашиглах эрхийг хязгаарлагдмал байдлаар зохицуулжээ. (Хүснэгт 1 ба 4-ийг үзнэ үү).

 **Нигер** улс малчдын газар эзэмшлийн эрхийг эрх зүйн хүрээнд тусгайлан хүлээн зөвшөөрдөг. Нигер нь Хөдөөгийн институтийн тогтолцоо (93-015 тоот тогтоол), Бэлчээрийн мал аж ахуйн тогтоол (2010-029 тоот тогтоол) бүхий Африк тив дэх хамгийн цогц мал аж ахуйн эрх зүйн орчныг бүрдүүлсэн улс юм. Дээрх тогтоолууд нь малчдын нүүдэллэх эрхийг хуулиар хүлээн зөвшөөрч, бэлчээр ашиглах харилцааг зохицуулдаг. Мөн газрын маргаан шийдвэрлэх, малчдын нүүдлийн орон зайг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий төвлөрлийг сааруулсан засаглалын тусдаа институт ажилладаг.

Нигер улсад бэлчээрийн мал аж ахуйн тухай хууль батлагдсан нь малчдын эрэлт шаардлагын үр дүн байсан ба уг хуулийн төслийг малчдын төлөөлөл, орон нутгийн удирдлагын оролцоотойгоор боловсруулжээ. Малчдын эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын хэрэгцээг тодорхойлох зорилгоор улс даяар 100 гаруй зөвлөлдөх хэлэлцүүлэг зохион байгуулсан.

 **Монгол улсын** хууль тогтоомжид "бүх газар нутаг, тэр дундаа малчдын ашиглах бэлчээрийн газар төрийн эрх мэдэлд байна" гэж заасан. Хуулиар газрыг зургаан үндсэн ангилалд хуваадаг ба бэлчээр нь тэдний нэг болох "хөдөө аж ахуйн газар"-ын ангилалд багтдаг. Монгол улс нь өргөн уудам бэлчээрийн газар нутагтай тул малчид уламжлалт нүүдэллэх хэв маягаа хадгалсаар ирсэн. Гэвч газар ашиглах энэ уламжлалт хэв маягийг дотоодын хууль тогтоомжид тусгайлан зааж, хамгаалаагүй байна. Тус улсын эрх зүйн тогтолцоо нь малчдын нүүдэл хөдөлгөөнийг дэмжих, "эрхэд суурилсан" хандлагыг баримтлаагүй, харин мал аж ахуйн бүтээмж, газар зохион байгуулалтын тогтолцоонд голчлон анхаарсан шинжтэй байна. Монгол улсын Газрын тухай хуулийн 9.1-д "Монгол Улсын хилийн доторх бүх газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл сан байна" гэсэн нь газар эзэмших, ашиглах, өөрчлөх зохион байгуулах бүх эрхийг төрд төвлөрүүлсэн зохицуулалт юм.

Хүнэсгт 1. Малчид газар ашиглах эрхээ хэрэгжүүлж буй эзэмшлийн тогтолцоо

	Улс	Газар эзэмших тогтолцооны төрөл	Газар эзэмших тогтолцооны нэр	Хамгааллын түвшин
АФРИК	Кени ⁷	Хамтарсан газар эзэмших тогтолцоо	Бүртгэлтэй болон бүртгэлгүй олон нийтийн газар	Үндсэн хуулиараа хамтын өмчлөлийг бүртгэлтэй болон бүртгэлгүй олон нийтийн эрхийг хүлээн зөвшөөрсөн. Гэвч бусад хуулиуд нь суурьшлын бүс, онцгой хил хязгаар бүхий газар ашиглалтыг урьтал болгодог.
	Нигер	Малчдад тусгайлсан тогтолцоо	Малчдын олон нийт	Эрхэд суурилсан хууль эрх зүйн хүрээ
	Танзани	Хамтарсан газар эзэмших тогтолцоо	Тосгоны газар	Эрх зүйн тогтолцоо нь газар ашиглахыг нэр төдий хүлээн зөвшөөрдөг ч малчдыг суурьшлын бүс рүү шахсан, газрыг тодорхой хил хязгаартай ашиглахыг албадсан эрх зүйн орчин үйлчилдэг. Малчид тосгоны эдэлбэр газарт газар ашиглах эрхтэй ч энэ нь хязгаарлагдмал, бүртгэлжсэн, төлөвлөлтөд орж, “Газар эзэмшлийн уламжлалт эрхийн” гэрчилгээгээр баталгаажсан байдаг.
АЗИ	Монгол	Малчдад тусгайлсан тогтолцоо	Төрийн газрын нэгдмэл сан	Малчдад бэлчээр ашиглах эрхийг зөвшөөрсөн бөгөөд зарим зохицуулалт нь уг ашиглалтыг тодорхой хэмжээнд хамгаалдаг. Төр нь газрын асуудлаар төвлөрсөн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг ч эрхэд суурилсан хамгаалалт байхгүй.
	Балба	Малчдад тусгайлсан тогтолцоо	Малчдын эрх	Уламжлалт хэрэглээ, хамтын эзэмшлийн эрх, хязгаарлагдмал хэм хэмжээ бүхий хувийн газар эзэмших эрхийг хуульчилсан.
ЛАТИН АМЕРИК	Боливи	Хамтарсан газар эзэмших тогтолцоо	Уугуул, язгуур, тариачны нутаг дэвсгэр	Үндсэн хуулиар хамтын эзэмшлийг хүлээн зөвшөөрч, хамгаалдаг.
			Нийтийн эзэмшил	
	Перу	Хамтарсан газар эзэмших тогтолцоо	Төрөлх олон нийт	Үндсэн хуулиар хамтын эзэмшлийг хүлээн зөвшөөрч, хамгаалдаг.
Язгуур олон нийт			Үндсэн хуулиар хамтын эзэмшлийг хүлээн зөвшөөрч, хамгаалдаг.	
Өөрсдийгөө сайн дураараа тусгаарласан уугуул иргэд			Үндсэн хуулиар хамтын эзэмшлийг хүлээн зөвшөөрч, хамгаалдаг.	

4. Нүүдэллэх эрх

4.1 Олон нийтийн нүүдэллэх эрх

Нүүдэл, отор, хамтын засаглал нь бэлчээр эрхлэгчдийн суурь эрх билээ⁵. Эдгээр нь малчид, нүүдэлчдийн амьжиргааны гол эх үүсвэр тул үүнийг хүлээн зөвшөөрөх нь тэдний нэр төр, эзэмшлийн аюулгүй байдлын баталгааг хангах чухал нөхцөл болдог. Малчдын эрхийг хамгаалснаар дэлхийн өнцөг булан бүрд тархан амьдарч буй малчин иргэдийн амьжиргааг баталгаажуулаад зогсохгүй, хүн төрөлхтөн байгаль эхдээ ээлтэй, орон нутгийн онцлогт тохирсон тогтвортой хөгжлийн шийдлүүдийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. Бас уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй газрын доройтол, цөлжилтийн эрсдэлийг бууруулахад эдгээр эрх зүйн баталгаа чухал ач холбогдолтой⁶.

Гэвч малчдын нүүдэл хөдөлгөөн, бэлчээр ашиглалт нь газар бэлчээрийг доройтуулж улмаар газрыг тогтвортой, үр ашигтай ашиглахад сөрөг нөлөө үзүүлдэг гэх бодлого, эрх зүйн өрөөсгөл үзэл баримтлал урт хугацаанд амь бөхтэй оршиж ирсэн. Энэ үзэл санаа нь бэлчээрийн хуваагдал, экосистемийн доройтлыг даамжруулж, уламжлалт мал аж ахуйг хууль бусад тооцох, албадан суурьшихыг дэмжсэн туйлширсан бодлого гарах хөрс суурь болж буйг тэмдэглэх хэрэгтэй. Харамсалтай нь ийм төрлийн бодит бус, өрөөсгөл хандлага дэлхийн өнцөг булан бүрд байсаар байгааг тус судалгааны үр дүн тодорхой харуулж байна. Бидний дүн шинжилгээ хийсэн эрх зүйн баримт бичгүүдийн ихэнх нь малчид, нүүдэлчдийн нүүдэл хөдөлгөөн, газрыг уян хатан зохион байгуулан ашиглах суурь эрхийг хуулиар хүлээн зөвшөөрөөгүй байна. Үүнээс болж малчдын газар эзэмшлийн аюулгүй байдлыг улам дордуулдаг хууль эрх зүйн ноцтой цоорхойнууд шийдэгдэхгүй хэвээр үлджээ. **Харин Нигер улс мал аж ахуйг хамгаалах бие даасан эрх зүйн зохицуулалтаараа дамжуулан нүүдэл, отор хийх үйл явцыг малчдын амьжиргааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг хэмээн албан ёсоор хуульчилсан нь судалгаанд хамрагдсан бусад орноос ялгарах дэвшилтэт жишээ болж байна.**

Хүснэгт 2. Малчдын нүүдэллэх эрхийг суурь эрх хэмээн хүлээн зөвшөөрөх нь

<p>● Ялгаварлан гадуурхсан бодлого: Хууль, бодлого нь суурьшлын амьдрал руу малчдыг түлхдэг.</p>	<p>● Малчдын нүүдэллэх эрхийг тодорхой хуульчлаагүй ч бусад хууль тогтоомж нь уг эрхийг баталгаажуулах эсвэл үгүйсгэх суурь болох магадлал бүхий улс орнууд.</p>	<p>● Малчдын нүүдэллэх эрхийг суурь эрх гэж хүлээн зөвшөөрсөн.</p>
Танзани	Кени Балба Монгол	Перу Боливи Нигер

Малчдын нүүдэллэх эрх нь уламжлалт, эсвэл албан ёсоор хуульчилснаас үл хамаарч судалгаанд хамрагдсан долоон улсын малчдад газар тариалангийн талбай болон олборлох үйлдвэрлэлийн (уул уурхай) тэлэлт, тусгай хамгаалалттай газар нутгийн хязгаарлалт, дэд бүтцийн хуваагдал, нүүрстөрөгч болон ногоон хөгжлийн төслүүд нэмэгдэж байгаа зэрэг олон хүндрэл бэрхшээл тулгарч байна (**Хүснэгт 6 ба 8**), Хуулиар хамгаалсан нүүдлийн орон зай байхгүй, уламжлалт болон хил дамнасан нүүдлийн орон зайг харилцан ашиглах зохицуулалт муу, төрийн дэмжлэг сул зэрэг нь эрх зүйн

Малчин эмэгтэйчүүдийн зөвлөлийн
үүсгэн байгуулагчдын зураг.
Зураг: Малчин эмэгтэйчүүдийн
зөвлөл



хүрээнд ч, бодит амьдрал дээр ч малчдад аюул учруулж байна. Малчид, нүүдэлчид өөрсдийн уламжлалт нутаг дэвсгэртээ нэвтрэхийн тулд асар их саад бэрхшээл, хүний эрхийн зөрчилтэй нүүр тулж, газар ашиглах эрхийн талаар "тохиролцох" шаардлагатай болж байна.

4.2 Малчин эмэгтэйчүүдийн нүүдэллэх эрх

Судалгаанд хамрагдсан долоон улс бүгд Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)-д нэгдэн орсон. Тус конвенцод нэгдэн орсон улс орнууд нь уугуул болон хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн эсрэг чиглэсэн хууль эрх зүйн аливаа саад бэрхшээл, тэр дундаа газар өмчлөх, ашиглах эрхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах үүрэгтэй. Гэвч мал аж ахуйн салбарт конвенцоор хүлээсэн үүргээ улс орнууд хэрэгжүүлэхгүй байна. **Тухайлбал, судалгаанд хамрагдсан улс орнуудын нэг нь ч малчин эмэгтэйчүүдийн нүүдэллэх эрхийг тусгайлан хуульчлаагүй бөгөөд хэд хэдэн улс оронд газрыг хамтран эзэмшихэд эмэгтэйчүүд тэгш эрхтэй оролцох боломж хязгаарлагдмал хэвээр байна.** Нүүдэллэх бол малчдын суурь эрх гэж үздэг Нигер улсад эмэгтэйчүүд тухайн олон нийтийнхээ нэг гишүүн тул тэгш эрх эдлэх боломжтой мэт харагддаг. Гэвч уг хуульд малчин эмэгтэйчүүдийн бие даасан эрх, олон нийтийн албан ёсны гишүүнчлэлийг тусгайлан хуульчлаагүй орхигдуулжээ. Тиймээс эмэгтэйчүүд өөрсдийн жам ёсны эрх ашгаа хамгаалах, байр сууриа баталгаажуулах хүндхэн ачааг үүрсэн хэвээр байна.

Энэ бол анхаарал татахуйц, нийтлэг ажиглагдаж буй эрхийн хэрэгжилтийн асар том зөрүү. Малчин болон нүүдэлчин эмэгтэйчүүд нүүдэллэх явцдаа эрэгтэйчүүдийн адил бүтцийн олон саад бэрхшээлтэй нүүр тулдаг ч түүн дээр нэмээд хүйсээс хамааралтай давхар бэрхшээлүүд үүсдэг. Тэнцвэргүй бас хөлсгүй асаргааны үүрэг хариуцлага, эцгийн эрхт ёсыг шүтсэн нийгмийн бүтэц, эмэгтэйчүүдийн нүүдэл хийхэд тавигдах уламжлалт хязгаарлалтууд, нүүдэллэх үеийн аюулгүй байдал алдагдах, олон нийтийн засаглалын тогтолцоонд бие даасан хуулийн статусгүй байх зэрэг нь дээрх давхар бэрхшээлийн жишээнүүд юма ([Хүснэгт 6](#) ба [8](#)).

4.3 Хил дамнан нүүдэллэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудал

Ихэнх малчид, нүүдэлчдийн амьдарч ирсэн уламжлалт нутаг дэвсгэр, нүүдлийн орон зай нь улсын хил, засаг захиргааны хуваарилалт бий болохоос ч өмнө үүссэн бөгөөд тэдний газар ашиглалт, нүүдэл нь улирал, цаг агаар, цаг хугацаанаас хамаарч хувьсан өөрчлөгддөг онцлогтой. Хилийн зурвасаас болж амьжиргаа, сайн сайхан байдал нь хуваагдалд орсон малчид, нүүдэлчдийн хувьд хил дамнан нүүдэл нь соёл, эдийн засгийн чухал харилцаа нь болж байдаг. Малчдын хувьд хил дамнан нүүдэл

бол хуурай газрыг тогтвортой ашиглах гол стратеги нь юм. Тэд улирлын чанартай байгалийн баялаг хүртэх, малын худалдаа хийх замаар уур амьсгалын өөрчлөлтөд нийгэм-экологийн тэсвэртэй байдлаа хадгалдаг⁸. Үүнийг үл харгалзан, судалгаанд хамрагдсан долоон улсын ердөө гурав нь хил дамнасан шилжилт хөдөлгөөнийг хуулиар зохицуулж, үлдсэн дөрөв нь малчдын нүүдэл хөдөлгөөнийг уур амьсгалын дасан зохицол, ган зудын менежмент, улирлын өөрчлөлт, яаралтай үед бэлчээр ашиглах хэрэгцээгээр хязгаарлан үзэж байна.

Хүснэгт 3. Хил дамнасан нүүдэл ба нүүдэл хөдөлгөөн нь уур амьсгалын өөрчлөлтөд дасах зохицох стратеги болох нь

Улс	Хил дамнасан нүүдлийг хүлээн зөвшөөрсөн/хамгаалсан байдал	Нүүдэл хөдөлгөөнийг уур амьсгалын дасан зохицох стратегитай холбосон эсэх
Кени	Отор нүүдлийн протоколд (2020) нэгдэн орсон. Хил дамнасан нүүдлийг амьжиргаагаа залгуулах уур амьсгалын дасан зохицох стратеги гэж хүлээн зөвшөөрдөг.	Тийм
Нигер	Нигери, Чад, Буркина Фасо улсуудтай отор нүүдлийн чиглэлээр хоёр талт хэлэлцээр байгуулсан.	Тийм
Танзани	Хоёр талт хэлэлцээр байхгүй. Малын эрүүл ахуйн хууль нь Кени, Уганда руу чиглэсэн нүүдлийг хязгаарладаг.	Бэлчээрийн мал аж ахуйг ерөнхийд нь хөдөө аж ахуйн ангилалд багтаасан. Нүүдлийг уур амьсгалын дасан зохицох стратеги гэж төдийлөн үздэггүй.
Монгол	Албан ёсны боомтуудаас гадуур ОХУ, БНХАУ руу хил давахыг зөвшөөрдөггүй. Хилийн зурваст мал маллах, оршин суухыг хориглодог.	Дасан зохицох хөтөлбөрүүд байгаа боловч энэ нь малчдын нүүдэллэх эрхтэй шууд холбогдоогүй. Зарим бодлогын арга хэмжээ нь шинжлэх ухааны үндэслэлгүйгээр малын тоо цөөлөхийг уриалдаг.
Балба	Хятад улстай хил дамнасан бэлчээр ашиглалтын гэрээтэй. Хил орчмын малчид хил нэвтэрч, байгалийн баялаг ашиглах хууль ёсны эрхтэй ⁸ .	Тийм. Гэвч КОВИД-19с хойш хилийн хязгаарлалт, мал эмнэлгийн шаардлагаас болж бодит байдал дээр нүүдэл хийхэд хүндрэлтэй болсон.
Боливи	Хуулиар хил дамнасан амьдралын хэв маягийг хамгаалдаг ч одоогоор хоёр талт хэлэлцээр хараахан байгуулаагүй байна.	Тийм
Перу⁹	Хууль тогтоомж болон хоёр талт гэрээ хэлэлцээр байхгүй.	Уламжлалт мэдлэгийг уур амьсгалын дасан зохицох арга гэж ерөнхийд нь хүлээн зөвшөөрдөг ч малчид эсвэл нүүдэлтэй тусгайлан холбож үздэггүй.

5. Газар ашиглах, мал аж ахуй эрхлэх эрх

Малчдын “газар ашиглах эрх” нь судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд хамгийн түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн эрх буюу газар-суурьтай хууль эрх зүйн тогтолцооны хамгийн суурь элемент юм. **Гэвч газар ашиглах ерөнхий эрхийг эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөх нь эрхэд суурилсан байдлаар эсвэл бодит агуулгын хүрээнд газар ашиглах боломжийг бүрэн баталгаажуулдаггүй гэдгийг хэлэх хэрэгтэй.** Малчдын эрх, амьжиргаа нь тэдний мал сүргээ дагаж нүүдэллэх чадвартай салшгүй холбоотой байдаг. Төрөөс мал эмнэлгийн эрүүл ахуйн шаардлага тавих замаар мал сүрэг болоод малчдын амьжиргааг хамгаалдаг ч ийм нэрийдлээр малын нүүдэл хөдөлгөөнд хязгаарлалт тавих нь оновчгүй юм. Ийм төрлийн хязгаарлалт нь малчдын амьжиргааг боомилоод зогсохгүй, тэдний нүүдэл хөдөлгөөнийг хууль бусад тооцож, нүүдэллэх эрхэд нь ноцтой саад учруулж болзошгүй байна. Малчид болон хууль боловсруулагчдын эрх мэдэл тэнцвэргүй байгаа нь малын шилжилт хөдөлгөөнд дур мэдэн хязгаарлалт тогтоох, цаашлаад хүн төрөлхтөн, байгаль экологийн тогтолцоонд хортой үр дагавар авчирдаг гэдгийг мартаж болохгүй.

ЭНС-ийн уг судалгаанд ашиглаж буй “газар ашиглах эрх” гэдэг нь малчид болон нүүдэлчид амьжиргаа, эдийн засаг, соёлын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор бэлчээр, малын нүүдлийн орон зай, отор нүүдлийн маршрут, усны эх үүсвэр, ой мод болон тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх, тэдгээрийг ашиглах, дамжин өнгөрөх хууль ёсны болон уламжлалаар хүлээн зөвшөөрөгдсөн эрх гэж ойлгоно. Мал аж ахуйн салбарт “газар ашиглах эрх” нь мөн чанартаа хөдөлгөөнт шинжтэй байдаг буюу улирлын чанартай, харилцан ашиглах нөхцөлтэй, гэрээ хэлэлцээрээр тогтсон эсвэл дундын байж болох бөгөөд нүүдэллэх эрхийн салшгүй хэсэг байдаг.

Хүснэгт 4-д газар ашиглах эрх ямар хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, мөн мал аж ахуй эрхлэх эрх зүйн тогтолцооны олон хэлбэрийг улс орон бүрээр харьцуулан харууллаа.

Хүснэгт 4. Газар ашиглах эрхийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал

Улс	Газар ашиглах эрхийн баталгаажсан байдал	Эрхийн цар хүрээ газар нутаг нь тодорхойлсон байдал	Мал аж ахуй эрхлэхтэй холбоотой ялгаатай зохицуулалт
Кени	<ul style="list-style-type: none"> Хамтын эзэмшил, бэлчээр хамтаар ашиглах тогтолцоо Орон нутгийн байгаль хамгааллын зохицуулалт: Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний дагуу бэлчээрийг сэлгэж ашиглах хяналтын хэлбэр Тусгай хамгаалалттай газар нутаг, ус, бэлчээр, хужирт нэвтрэх уян хатан, хэлэлцээрт суурилсан хил дамнасан зохицуулалт 	Хамтын эзэмшлийн газар нутаг нь улсын нийт нутаг дэвсгэрийн дор хаяж 65 хувийг эзэлдэг боловч албан ёсны бүртгэлжүүлэлт удаашралтай байгаагаас малчдын нарийвчилсан мэдээлэл байхгүй.	Тийм—хүн нэвтрэхийг зөвшөөрдөг ч байгаль хамгааллын бүс, үндэсний паркуудад мал оруулахыг хатуу хязгаарладаг эсвэл хориглодог.
Нигер	<ul style="list-style-type: none"> Мал аж ахуйн бүс нутагт буюу “төрийн (нийтийн) эзэмшилд” хамаарах газар нутагт малчид газар, бэлчээрийн нөөц баялаг (бэлчээр, усны цэг, амрах талбай)-г хамтран ашиглах эрхтэй. Газар тариалангийн нутаг дэвсгэрийг хувийн эсвэл уламжлалын дагуу ашиглаж буй газар гэж ангилдаг. Эдгээр нутаг дэвсгэрт малчдын нэвтрэх эрхийг отор нүүдлийн орон зай, зурвас газар, үлдэгдэл бэлчээрийн талбай, усны эх үүсвэрийг хүлээн зөвшөөрөх замаар хуульчлан баталгаажуулдаг. Энэ зохицуулалтыг газар өмчлөгчид, мөн тариалан эрхлэгчид заавал мөрдөгдөнө. 	Бэлчээрийн мал аж ахуйн тухай 2010–029 тоот тогтоолоор Үндэсний хэрэг эрхлэх газар бэлчээрийн нэгдсэн бүртгэл, тооллого хийхийг заасан. Мөн 1993 оноос хойш газар ашиглалтыг зурагжуулах, ангилах зорилго бүхий “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г шаардан мөрдүүлж байгаа. Зарим бүс нутагт бэлчээрийн талбайн хэсэгчилсэн бүртгэл хийсэн ч үндэсний хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөг эцэслэн боловсруулаагүй ¹⁰ .	Тийм- Хөдөө аж ахуйн хуульд хүний хэрэглээний усыг нэн тэргүүний эрэмбэтэй байхаар тогтоож, үүнийг нийтийн эрх зүйн хүрээнд зохицуулдаг (48 дугаар зүйл) бол, малын уух усыг бэлчээрийн эрх зүйн хязгаарлалт, мал аж ахуйн тусгайлсан хууль тогтоомжид хамаарах асуудал хэмээн тусад нь зохицуулдаг.

<p>Танзани</p>	<ul style="list-style-type: none"> ● Тосгон дундын газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлт (ТДГЗБНТ) нь бэлчээрийн малчдын хамтын бэлчээрийн талбай, малын нүүдлийн орон зай, улирлын шинжтэй байгалийн баялгийг тосгоны эдэлбэр газар гэж албан ёсоор баталгаажуулдаг¹¹. ● ТДГЗБНТ нь суурьшмал амьдралын хэв маягийг тулгадаг, малчдын отор нүүдлийг засаг захиргааны хяналт бүхий нөхцөлт газар ашиглалт хэмээн үздэг эрх зүйн тогтолцоотой.¹². ● Танзанийн кэйс судалгаанаас "Ужама олон нийтийн нөөцийн баг" жишээг олж үзнэ үү. 	<p>Танзани улсад малчдын хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий газар нутгийн цар хүрээ маргаантай хэвээр байна.</p>	<p>Тийм— ТДГЗБНТ нь бэлчээрийн тусгайлсан талбай, малын нүүдлийн орон зайг хүний хэрэглээний бүсээс зааглан тогтоодог боловч бодит байдал дээр уг зааг ялгааг мөрдүүлэх хэрэгжилт сул. Түүнчлэн, малын шилжилт хөдөлгөөнийг байгаль хамгааллын болон газар ашиглалтын бодлогоор улам хязгаарлах болсон. Эдгээр хязгаарлалт нь хүний шилжилт хөдөлгөөнд ижил тэгш үйлчилдэггүй.</p>
<p>Монгол</p>	<ul style="list-style-type: none"> ● Газрын тухай хуульд бэлчээр ашиглах эрхийг зөвшөөрдөг ● Бэлчээрийг хувийн өмчид шилжүүлэхгүй байх зарчимтай. ● Өвөлжөө, хаваржааны газрыг эзэмших эрх: Малчид өвөлжөө, хаваржааны газрыг 15-аас 60 жилийн хугацаатайгаар эзэмших гэрчилгээ авах боломжтой ба хугацааг нэг удаа 40 хүртэл жилээр сунгаж болно. ● Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас гаргасан дүрэм журмын дагуу ойн сан, тусгай хамгаалалттай газарт нэвтрэх зохицуулалттай ● Уул уурхай, бизнесийн зориулалт бүхий үйлдвэрлэлийн газар, газар тариалан, суурин газарт мал маллахыг хориглодог. 	<p>Монгол Улсын¹³ хэмжээнд ойролцоогоор 196,000 малчин өрх байдаг бөгөөд нийт 150 сая га газар нутгийн 72 хувийг мал аж ахуйн зориулалтаар ашиглаж байна¹⁴.</p>	<p>Тийм—хэдийгээр хүн, мал хамт нүүдэллэдэг ч малын нүүдэл хөдөлгөөнийг хязгаарласан заалтууд хорио цээрийн бүс (Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17.3), тариалангийн талбайн ойролцоо (Тариалангийн тухай хуулийн 24.1.1), уул уурхай, үйлдвэрлэлийн бүсүүдэд үйлчилдэг. Мал эмнэлэг, малын бүртгэлийг малын нүүдэл хөдөлгөөний үед шаарддаг.</p>
<p>Балба</p>	<ul style="list-style-type: none"> ● Хувийн өмчийн эдэлбэр газрууд ● Улсын болон орон нутгийн хамтын ойн сан бүхий газарт бэлчээр ашиглах, улирлын чанартай үйл ажиллагаа явуулах уламжлалт газар ашиглах эрх ● Газар ашиглах эрх нээлттэй ч зөвхөн орон нутгийн захиргаанаас зохицуулдаг. ● Малчид уулын бүсийн үндэсний парк, тэдгээрийн ойролцоо, мөн байгаль 	<p>Балба улсын нийт нутаг дэвсгэрийн 22 гаруй хувь нь "Бэлчээрийн бүс" гэсэн ангилалд хамаардаг.</p>	<p>Тийм—малчид улсын болон орон нутгийн ойг уламжлалт байдлаар хамтран ашиглах эрхтэй ч, үндэсний парк, байгаль хамгааллын бүс, дундын бүсэд мал бэлчээх асуудлыг хатуу хязгаарладаг журамтай. Мөн дээрх бүс нутагт суурьших, түр хугацаагаар буудаллахыг хориглодог бөгөөд байгаль хамгааллын бүс нутгийг тэлж байгаа нь нүүдэлчин уугуул иргэдийг албадан нүүлгэхэд хүргэж байна¹⁵.</p>

<p>Боливи</p>	<ul style="list-style-type: none"> ● Мал аж ахуй эрхлэгчийн хувиар газар ашиглах эрх нь нийгмийн үүрэг эсвэл нийгэм-эдийн засгийн үүрэг биелүүлэх нөхцөлтэйгөөр хэрэгждэг. ● Уугуул иргэд, тариачдын үйлдвэрлэлийн зориулалттай талбай, нийгэм, оюун санаа, соёлын орон зай бүхий нутаг дэвсгэр ашиглах эрх баталгаажсан. ● Төрийн сангийн (нийтийн) газарт: (i) Уламжлалт журмаар зохицуулагдсан газрыг тариаланчид, уугуул иргэд, Афро-Боливичуудад үнэ төлбөргүй олгодог. (ii) Дунд болон томоохон мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд зах зээлийн үнээр, харин хувь хүмүүст хөнгөлөлттэй үнээр төлбөртэй олгоно. ● Хувийн өмчийн газарт гуравдагч этгээд мал тууж нэвтрэхийг хатуу хориглодог¹⁶. 	<p>Олон нийтийн хэрэгцээнд хүлээн зөвшөөрөгдсөн 34.6 сая га газрын ойролцоогоор 12 сая га талбайг бэлчээр, мал аж ахуйн үйл ажиллагаанд зориулдаг.</p>	<p>Тийм—хүний газар ашиглах эрхийг оршин суух байдал болон "нийгмийн чиг үүрэг" гэсэн шалгуураар баталгаажуулдаг бол, мал аж ахуй эрхлэх эрхийг техникийн шалгууруудаар буюу малын тоог (нэг үхэрт 5 га талбай) харгалзан, бүртгэлийн шошго үндэслэж олгодог.</p>
<p>Перу</p>	<ul style="list-style-type: none"> ● Тариачид, уугуул иргэдэд газрыг хамтран ашиглахыг зөвшөөрч, тэдэнд газар ашиглалтын харилцааг бие даан зохицуулах эрх олгодог. ● Нийтийн (төрийн) эдэлбэр газарт: Газар дутагдалтай тариачдад зэргэлдээх төрийн мэдэлд буцаан авсан газрыг тэргүүн ээлжид шүүхийн шийдвэрээр олгохоос гадна, хэрэв тухайн газрыг худалдах тохиолдолд худалдан авах давуу эрхийг өгнө. Харин газар дутагдалтай уугуул иргэдийн хэрэгцээг хангах нэмэлт газрыг шүүхийн шийдвэрээр олгоно. ● Хувийн өмчийн газарт мал аж ахуйн зориулалтаар нэвтрэх тохиолдолд газар өмчлөгчтэй заавал зөвшилцөж, тохиролцсон байхыг шаардана. 	<p>Бэлчээрийн бүс нутгаар ангилсан нарийвчилсан задаргаа байхгүй. Нийт 7,282 тариачин иргэд (Андын нуруу, эргийн бүс болон Амазоны сав газрын иргэд) байгаагаас 5,297 нь өмчлөх эрхийн гэрчилгээтэй бөгөөд нийт 24,735,043 га талбайг эзэмшиж байна.</p> <p>Амазоны бүс нутагт 3,003 уугуул иргэд 18,590,565 га талбайг хууль ёсоор эзэмшиж байгаагаас 2,286 нь өмчлөх эрхийн гэрчилгээгээ авч, газар нутгаа тэлж, хил заагаа тогтоолгосон.</p> <p>Уугуул иргэд болон/эсвэл газар нутагт зориулсан найман газартай. Үүнээс сайн дураараа тусгаарлагдаж, анхны харилцаа холбоонд байдаг уугуул иргэдэд зориулсан нийт 4,631,452.80 га талбай байдаг нь нийт нутаг дэвсгэрийн ойролцоогоор 3.6 хувь юм.</p>	<p>Үгүй—эрх зүйн тогтолцоонд хүн, малын ашиглах эрхийг ялгаатай байхаар заасан тусдаа дүрэм журам байхгүй. Олон нийтийн чуулган нь гишүүн бүрийн малын тооны дээд хязгаарыг зохицуулдаг (24656 дугаар хуулийн 13 дугаар зүйл) ч олон нийтийн нэгдсэн газрын засаглалын механизмаар дамжиж хэрэгждэг.</p>


5.1 Хамтын ашиглалт эсвэл онцгой эзэмшлийн тогтолцоо?


Малчид, нүүдэлчдийн хувьд газар эзэмшлийн баталгаатай байдал гэдэг нь газрыг уян хатан ашиглах тогтолцоотой байхыг хэлдэг. Газрыг онцгойлон эзэмших эсвэл хамтран ашиглах эрхийг уян хатан шийдвэрлээгүйгээс болж малчид газар нутаг, бэлчээрээ алдах, улмаар албадан суурьшлын бүсэд амьдрахад хүрч байна. Энэ нь малчид, нүүдэлчдийн амьжиргаа, уламжлалт амьдралын хэв маягт онцгой дарамт учруулахаас гадна уламжлан ирсэн эрхээ эдэлснийхээ төлөө хууль зөрчигч болгох тохиолдол ч гарч байна. Цаашлаад малчид, нүүдэлчдийн байгаль хамгаалал, уламжлалт мэдлэгтэй холбоотой үе дамжин өвлөгдөж ирсэн мэдлэгийн систем устаж алга болгоход ойрхон байна.


“Албан ёсны газар эзэмшлийн тогтолцоо нь малчдын эрхийг, ялангуяа тэдний газрыг уян хатан, олон чиг үүрэгтэйгээр, улирлын шинжтэй ашиглах үйл явцыг дэмжсэн эрхүүдийг хүлээн зөвшөөрөх тал дээр үндсэндээ бүтэлгүйтэж иржээ.”¹⁷

— Малчид ба газрын эрхийн асуудлаарх ОУБМЖ-ийн ажлын хэсэг

Судалгаанд хамрагдсан улс орнуудад газрын эрхтэй холбоотой олон төрлийн институтийн зохицуулалт байгааг судалгааны үр дүр харуулж байна. Тухайлбал, Нигер улсын эрх зүйн орчин нь бэлчээрийн малчид уламжлалт газар нутгаа тэргүүн ээлжид ашиглах эрхийг хүлээн зөвшөөрөхийн сацуу бусад малчдад эдгээр орон зай нээлттэй, дундаа ашиглах боломжийг хэвээр хадгалдаг¹⁸. Нигер улс Хөдөө орон нутгийн хуулиараа бэлчээрийн газрыг хувьд авахыг хориглож, харин малын нүүдэл хөдөлгөөнийг хадгалж үлдэх зорилгоор газрыг хамтдаа ашиглах боломжтой байхаар зохицуулсан (5 дугаар зүйл). Перу болон Кени улсуудад малчдын эрхийг олон нийтэд чиглэсэн илүү өргөн хүрээний хуулиудаар зохицуулдаг. Энэ хоёр улсад газар ашиглах эрх зөвхөн тогтоосон газар нутаг, нутаг дэвсгэрээр хязгаарлагддаг тул малын нүүдэл хөдөлгөөнийг бодитоор хумьж байна. Харин үлдсэн улс орнуудын хувьд (Боливи, Монгол, Балба, Танзани) газар нутгийн бүсчлэл, ангиллаас хамаарч газар ашиглах эрх ялгаатай байдлаар хэрэгжиж байна¹⁹:

 **Боливи улс:** Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд малчид, нүүдэлчдэд тусгайлан заасан бүс нутаг ашиглах онцгой эрх олгодог бөгөөд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн зөвшилцлийн гэрээ эсвэл уламжлалт эрхийн үндсэн дээр хамтын болон нийтийн эдэлбэр газрыг ашиглах боломжтой²⁰. Мөн өөрсдийн ашиглаж буй газар нутгаа хамтаар болон дангаар ашиглах газар хэмээн бүртгүүлэх, дотоод дүрэм журмаа батлах, дундаа ашиглах талбайг тогтоох, мал дамжин өнгөрөх зам үүсгэх зэрэг дотоодын асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрхтэй.

 **Балба улс:** Малчид толгод болон уулархаг дүүргүүдэд тогтоосон дээд хязгаар (8.75 акр буюу 3.54 га хүртэл)-с хэтрэхгүй хувийн өмчийн газар эзэмшиж, түүндээ онцгой эрх эдлэх боломжтой. Малчид өвлийн саруудад, мөн нүүдэллэх богино хугацаандаа голчлон тосгоныхоо ойролцоох дундын бэлчээр эсвэл өөрсдийн хувийн газраа ашигладаг. Тэд жил бүр наймаас олон сарыг уулархаг бүсэд өнгөрүүлдэг бөгөөд тусгай хамгаалалттай газар нутаг (үндэсний парк, орчны бүс, байгаль хамгааллын бүс) болон орон нутгийн хамтын ойн сан бүхий газруудыг хамтран ашиглах эрхтэй байдаг.

 **Танзани улс:** Тухайн газар нутгийн эрх зүйн ангилал, түүнд хамаарах газар зохион байгуулалтын төлөвлөлтөөс хамаарч малчдын газар ашиглах эрхийг зохицуулдаг. Газрын тухай хууль, Тосгоны газрын тухай хуулийн дагуу газрыг

ерөнхий зориулалттай газар, тосгоны газар, эсвэл тусгай хэрэгцээний/нөөц газар гэж ангилах бөгөөд ангилал бүр нь нэвтрэх, ашиглах, хяналт тавих ялгаатай дүрэм журам бүхий газар эзэмшил, менежментийн бие даасан тогтолцоотой. Албан ёсоор хил заагийг нь тогтоож, бүртгэсэн тосгоны газрыг хувь хүн эсвэл олон нийт (малчид, иргэд) онцгой эрхтэйгээр хууль ёсоор баталгаажуулан авч болно. Танзани улсын хууль тогтоомж нь тосгоны газар ашиглалтын төлөвлөлт, тосгон хоорондын зохицуулалтын механизмаар дамжуулан хуулийн хүрээнд хамтын ашиглалтын эрхээр газрыг ашигладаг. Тус улсад 2007 онд батлагдсан "Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн тухай хууль"-р үндэсний, дүүргийн, тосгоны түвшинд төлөвлөлтийн байгууллагуудыг байгуулж, газар ашиглалтын төлөвлөгөө, түүний дотор тосгоны газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах, батлах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Тосгоны газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагалдах журмууд нь хөрш зэргэлдээ тосгод хооронд бэлчээрийн газар болон байгалийн нөөцийг хамтран ашиглах боломжийг олгосон хамтарсан төлөвлөлтийн гэрээ байгуулах зохицуулалттай. Үндэсний парк, ойн нөөц газар, ан амьтны нөөц газар зэрэг тусгай хэрэгцээний/нөөц газарт нэвтрэхийг Танзани улсын байгаль орчныг хамгаалах салбарын хууль тогтоомжоор эрс хязгаарласан эсвэл бүрмөсөн хориглосон байдаг. Зэрлэг амьтдыг хамгаалах тухай хуулиар (2009) зэрлэг амьтдыг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавьж, зэрлэг амьтдын менежментийн бүс, ан амьтны нөөц газар, хяналтын бүсүүдийг байгуулахаар хуульчилсан бөгөөд эдгээр бүсэд мал бэлчээх болон малын нүүдэл хөдөлгөөн хийхийг хориглодог. Энэ зохицуулалт нь малчдыг түүхэн хугацаанд ашиглаж ирсэн бэлчээрийн нутгаас нь шахан гаргах, зарим тохиолдолд албадан нүүлгэхэд хүргэж байна.



Монгол улс: Нэгдмэл газар нутгийн бодлоготой учир малчдын бэлчээр ашиглах эрхийг тусгайлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт харьцангуй сул бөгөөд газрын үндсэн эрх мэдэл төрд байдаг. Малчид уламжлал, зан заншлаа хадгалах, мөн харилцан зөвшилцөх замаар нийтийн эзэмшлийн бэлчээрийг ашиглах боломжтой. Монгол улсын хуулиар хот суурины зориулалт бүхий газрыг хувь хүнд өмчлүүлэхийг зөвшөөрдөг бөгөөд мөн малчдын өвөлжөө, хаваржааны газарт эзэмших эрхийн гэрчилгээ (15–60 жилийн хугацаатай) олгох боломжтой. Гэвч бодит амьдрал дээр олон малчид албан ёсны гэрчилгээ гэхээсээ илүүтэй уламжлалт эзэмшил буюу эцэг эхээс үе дамжин уламжлагдан ирсэн газар нутагтаа урт хугацаанд нутаглаж ирсэн. Эзэмших эрхийн гэрчилгээгээр баталгаажсан газар нь нүүдлийн мал аж ахуйд шаардлагатай орон зайн хэрэгцээг хангаж чаддаггүй. Тиймээс зэргэлдээх газар нутагт байгаа бусад малчин өрхүүдтэй харилцан тохиролцож, нэгнийгээ дэмжих замаар малынхаа бэлчээр, нүүдлийг зохицуулдаг. Харин орон нутгийн удирдлагууд зөвхөн малын нягтаршил ихтэй бүс нутаг эсвэл тусгай тохиолдолд үе үе хөндлөнгөөс оролцох нь бий. Хууль эрх зүйн хувьд бэлчээр нь төрийн өмчид хамаарах боловч малчдын нэвтрэх, ашиглах эрхийг бүрэн зохицуулаагүй, албан ёсны хууль тогтоомжид бүрэн тусгаагүй уламжлалт "дундын бүс" байдлаар ашиглагдаж байна. Малчдын өвөлжөөний газар эзэмших гэрчилгээ болон Засгийн газраас бэлчээрийн газарт олгосон уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцалын талаарх статистик мэдээлэл одоогоор байхгүй байна. Холбогдох захиргааны байгууллагууд ийм төрлийн мэдээллийг бүртгэж, хадгалдаггүй. Малчид өвөлжөө, хаваржааны газартаа эзэмшлийн гэрчилгээтэй байсан ч эцсийн өмчлөгч нь төр байх тул газрын хэвлийн баялаг болон бусад нөөцийг ашиглах давуу эрхтэй. Энэ байдлаас болж бэлчээр ашиглах гэрчилгээ байсан ч малчид бэлчээрээ алддаг буюу газар эзэмших гэрчилгээ нь бүрэн хамгаалалт болж чаддаггүй. Хэдийгээр "Малчны тухай хууль" батлагдсан ч малчдын газрын эрх эсвэл тэдний нүүдэл хийх эрхийг тусгайлан зохицуулсан заалт байхгүй.

Хэдийгээр газрыг онцгойлон эзэмших эрх нь аж үйлдвэрийн газар тариалангийн тэлэлт, уул уурхайн төслийн халдлагаас тодорхой хэмжээний хамгаалалт болдог ч хатуу тогтоосон хил хязгаар нь бэлчээрийн малчдыг албадан суурьшуулахад хүргэж, дундын бэлчээрийн талбайд ирэх гаднын дарамт шахалтын өмнө малчид хүчин мөхөстөхөд хүрч байна. Малчид уламжлалт нүүдэллэх эрхээ эдлэхийн тулд төлбөр хураамж төлөх, шүүхэд хандах зэрэг журамласан шаардлагын дарамтад (Жишээ нь: [Балба улсын кэйсийг үзэх](#)). өртсөн хэвээр байна. Монгол улсын хувьд малчид уламжлалт тогтолцооны дагуу харилцан зөвшилцөж газрыг хамтран ашиглах боломжтой байгаа ч үүнийг албан ёсоор хуульчлаагүй тул уул уурхайн төсөл зэрэг газар ашиглалтын давхцалаас болж, малчид төрийн шийдвэрийг дагахаас өөр аргагүй хүрч байна ([Монголын кэйсийг үзэх](#)). **Эдгээр холимог дүр зураг нь нүүдлийн амьдралын хэв маягт үл нийцэх өмчийн хатуу хил хязгаар тулгахгүйгээр, бэлчээр ашиглалтын уян хатан, зөвшилцөлд суурилсан шинж чанарыг багтааж чадах эрх зүйн орчин үгүйлэгдэж буйг тодорхой харуулж байна.**

5.2 Эмэгтэйчүүдийн өмчлөх, газар эзэмших эрх

Малчин, нүүдэлчин эмэгтэйчүүдийн эрхийг бүрэн хамгаалахын тулд дараах хоёр шалгуурыг заавал хангах шаардлагатай байдаг. Нэгдүгээрт, тухайн улсын нийт эмэгтэйчүүдийн (түүний дотор малчин болон нүүдэлчин эмэгтэйчүүдийн) эрх үндсэн хууль эсвэл бүх хууль тогтоомжийн заалтуудаар баталгаажсан байх ёстой. Хоёрдугаарт, малчин эмэгтэйчүүдийн эрхийг хувь хүнийх нь хувиар болон хамтын зохион байгуулалттай олон нийтийн гишүүний хувиар авч үзсэн тусгайлсан хамгаалалтуудтай байх шаардлагатай²¹. Энэ агуулгын хүрээнд Хүснэгт 5-аар судалгаанд хамрагдсан улс орнууд эдгээр хоёр шалгуурыг хэрхэн хангаж байгааг харьцуулан харуулав.

Хүснэгт 5. Эмэгтэйчүүдийн өмчийн бүх эрх ба малчин эмэгтэйчүүдийн олон нийтийн эрх

Хоёр шалгуур хоёулаа хангагдсан	Зөвхөн өмчийн бүх эрхийг хамгаалсан	Зөвхөн олон нийтийн-тусгайлсан хамгаалалттай	Эрх зүйн хамгаалалтгүй
<p>● Эмэгтэйчүүдийн өмчийн бүх эрх, малчин эмэгтэйчүүдийн хамтын газар (бэлчээр) ашиглах эрхийг хоёуланг нь тусгайлан хамгаалсан хуулийн зохицуулалттай.</p>	<p>● Үндсэн хууль эсвэл бусад хуульд эмэгтэйчүүдийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг ерөнхий байдлаар хүлээн зөвшөөрсөн, эсвэл тэдний өмч хөрөнгө эзэмших, нэвтрэх эрхэд сөрөг нөлөө үзүүлэхүйц уламжлалт зан үйл, арга барилыг хориглосон заалт тусгагдсан.</p>	<p>● Малчин эмэгтэйчүүдийн хамтын газар, нутаг дэвсгэр эсвэл байгалийн нөөц баялагт нэвтрэх, ашиглах эрхийг тусгайлан хүлээн зөвшөөрсөн.</p>	<p>● Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан эсвэл малчдад чиглэсэн орон нутгийн тусгайлсан ямар нэгэн эрх зүйн хамгаалалт байхгүй.</p>
<p>Боливи Кени Балба</p>	<p>Нигер Монгол Танзани</p>		<p>Перу</p>

Боливи улсын Газар шинэчлэлийн үндэсний албаны тухай хууль²², Кени улсын 2016 оны Хамтын газрын тухай хууль нь Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцтой (CEDAW) нийцсэн. Мөн газар эзэмших эрх дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах заалтуудыг тусгасан тул энэхүү судалгаанд оролцсон орнууд дундаа сайн туршлага болж байна. Кени улс эмэгтэйчүүдийн газрын эрхийг хамгаалсан

харьцангуй бат бөх албан ёсны эрх зүйн орчныг бүрдүүлжээ. Уламжлалт газар эзэмших эрхийг үнэлэх, тогтооход эмэгтэйчүүдэд эрх тэгш хандах ёстой бөгөөд (14 дүгээр хэсэг) хамтын газрын бүх төрлийн хэлцэл, үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох тодорхой эрхийг хуульчилсан байдаг (30 дугаар зүйлийн 3 дахь хэсэг). Гэвч газар ашиглах, шийдвэр гаргах эрхийг өрхийн тэргүүн (эрэгтэй хүн)-д хамааралтай болгож, эмэгтэйчүүдийг доогуур тавьдаг зан заншил, эмэгтэйчүүдийн оролцоог гадуурхдаг орон нутгийн засаглалын практик нь мал аж ахуйн бүхий л салбарт түгээмэл хэвээр байна. Дээрх байдал амьдрал дээр хуулиар олгогдсон хамгаалалтыг үгүйсгэж, хуулиас дээгүүр үйлчлэх явдал элбэг байна (жишээг Танзани, Нигер, Кени, Боливи улсын кэйс судалгаанаас үзнэ үү). Монгол улсын тухайд малчдын өвөлжөө, хаваржааны газрыг малчин эмэгтэйчүүдийн нэр дээр бүртгэдэггүй. Зөвхөн өрхийн тэргүүний нэр дээр бүртгэдэг ба малчин өрхийн хэд нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байдаг талаар тодорхой статистик мэдээлэл байхгүй.

6. Малчид болон нүүдэлчдийн эрхийн хэрэгжилт

6.1 Гол саад бэрхшээлүүд

Судалгаанд хамрагдсан долоон улсад эрх зүйн орчин нь ямар байхаас үл хамаарч малын нүүдэл хөдөлгөөн, бэлчээрт нэвтрэх эрхэд бүтцийн шинжтэй саад бэрхшээл олон байгааг баримтууд харуулж байна. Тухайлбал, Нигер улсад эрх зүйн харьцангуй сайн орчин бүрдсэн ч газар тариалангийн талбай малын нүүдлийн зурвас руу тэлж, хил орчмын бүс нутаг дахь тогтворгүй байдал үүссэн нь уламжлалт отор нүүдлийн орон зайг улам хумьж байна. Хүснэгт 6-д мал аж ахуй болон нүүдлийн амьдралын хэв маягийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүдийг улс орноор нь ангилж харуулав.

Хүснэгт 6. Малчдад тулгарч буй саад бэрхшээлүүд

Эрхээ эдлэхэд тулгарч буй бэрхшээлүүд	КЕНИ	ТАНЗАНИ	НИГЕР	БАЛБА	МОНГОЛ	БОЛИВИ	ПЕРУ	Улсын тоо
Олборлох үйлдвэрлэл (уул уурхай, нүүрс төрөгч)			●	●	●	●	●	5
Газар тариалангийн тэлэлт / Газар ашиглалтын хэлбэрийг өөрчлөх	●	●	●	●	●	●	●	7
Тусгай хамгаалалттай газар нутаг / Зэрлэг амьтдын нүүдлийн орон зай	●	●		●			●	4
Дэд бүтцийн төслүүд (Авто зам, хотжилтын тэлэлт)	●	●	●	●	●	●	●	7
Нүүрстөрөгчийн төслүүд (Карбон кредит, ойн төслүүд)	●	●	●			●		4
Газар эзэмшлийн баталгаагүй байдал / Эрх зүйн хамгаалалт дутмаг байх	●	●	●	●	●			5
Цаг уурын өөрчлөлт / Байгаль орчны доройтол			●	●	●			3
Мөргөлдөөн ба аюулгүй байдал алдагдах	●	●	●					3
Сэргээгдэх (Ногоон) эрчим хүчний төслүүд	●	●	●		●	●	●	6
Гэмт хэрэгтэн болгож харах / Гадуурхалт	●	●						2
Албадан суурьшуулалт / Хил хязгаарыг хатуу тогтоох	●	●						2
Улс бүрд тулгамдаж буй саад бэрхшээл	9	9	8	6	6	5	5	

6.2 Малчдын амьжиргааны дэд бүтцийг дэмжих нь

Дээрх бэрхшээлүүдийг даван туулахын тул малын нүүдэл хөдөлгөөн, бэлчээр ашиглах эрхийг шийдвэрлэх хууль эрх зүй, бодлого санхүүжилтийн тодорхой хүчин чармайлт гаргах; малын усан хангамжийн эх үүсвэр, мал эмнэлгийн үйлчилгээ, тууврын зам, малын нүүдлийн орон зай гэх мэт тусгай дэмжлэгийн механизмуудыг бий болгох замаар шийдвэрлэх шаардлагатай. Хүснэгт 7-д улс орон бүр бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч малчдын амьжиргааг дэмжих чиглэлээр ямар агентлаг, институт, тусгайлсан хөтөлбөр, төсөв зарцуулж байгааг харуулав. Хэдийгээр дэмжлэг үзүүлэх хандлага нэмэгдэж байгаа ч ихэнх улс орнууд хүний эрхэд суурилсан хандлагаар бус зөвхөн малын ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэхэд төвлөрдөг нь хүснэгтээс харагдана.

Хүснэгт 7. Малчдад үзүүлэх бодлого болон засгийн газрын дэмжлэгийн түвшин (Улс орнуудаар)

Улс орон	Засгийн газрын институт	Тусгайлан гаргасан хөтөлбөр	Хуваарилсан төсөв
Боливи	● Хөдөөгийн хөгжил, газрын яам: Хөдөө аж ахуйн салбарын ерөнхий чиг үүргийнхээ хүрээнд мал аж ахуйн (нүүдлийн) асуудлыг шууд бусаар хариуцдаг.	● Эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, 2021–2025 болон Эх орончдын хөтөлбөр, 2025: Малчдын асуудлыг шууд бусаар тусгасан.	● 2024 оны төсөв: Хөдөө аж ахуйн хөгжил, мал аж ахуйн салбарт 1.597 тэрбум боливиано (ойролцоогоор 228 сая ам.доллар) хуваарилсан ч энэ нь малчдад зориулсан тусгайлсан санхүүжилт биш.
Кени	● Гангийн менежментийн газар: Кенийн мал аж ахуйн маркетинг, борлуулалтын зөвлөл; Нүүдэлчдийн боловсролын үндэсний зөвлөл; Ган болон гамшгийн эрсдэлийн үеийн үндэсний нөөц сан.	● Хуурай болон хагас хуурай бүс нутгийн стратегиуд: Үндэстний цөөнх болон уугуул иргэдийн талаарх үндэсний бодлого (2025) – малчдад зориулсан тусгайлсан заалтуудтай.	● Мужийн уур амьсгалын сангийн 30 хувийг орон нутгийн иргэд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход нь туслахаар хуваарилсан.
Монгол	● Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам: Хөдөө аж ахуйн салбарын бодлого зохицуулалтын чиг үүргийнхээ хүрээнд хариуцдаг.	● Эдийн засгийн хөгжлийн төслүүд: "Цагаан алт" ноолуурын хөтөлбөр, "Шинэ хоршоо" хөдөлгөөн зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг ч эдгээр нь малчдын нүүдлийн хэв маяг, малын нүүдэл хөдөлгөөнийг дэмжихээс илүүтэй мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.	● "Цагаан алт" хөтөлбөр: 2028 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ойролцоогоор 700 сая ам ²³ . доллар зарцуулахаар төлөвлөсөн. Үүнээс яг малчдад зориулагдсан тусгайлсан хуваарилалт нь нээлттэй бус байдаг ба малчдаас хоршоо, бүлэг байгуулахыг шаарддаг. ● Орон нутгийн төсөв: Малчдад олгох татаас, ус хамгаалал (худаг гаргах), бэлчээрийн арчилгаа болон малын тууврын замыг засаж сайжруулахад зориулж орон нутгийн захиргааны төсвөөс жил бүр санхүүжилт хуваарилдаг.
Балба	● Орон нутгийн захиргаа: Мал аж ахуйн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх Үндсэн хуулийн онцгой эрх мэдлийг хэрэгжүүлдэг (Үндсэн хуулийн 8 дугаар хавсралт).	● Аймгийн түвшний зохицуулалт: Багмати, Карнали зэрэг аймгуудад мал аж ахуйг дэмжих тусгайлсан журмууд үйлчилдэг. Үүний хүрээнд нэг малчин олон нийтэд жилд 7,500 хүртэлх ам.доллар-ын татаас олгодог.	● Орон нутгийн төсөв: Малчдад олгох татаас, ус хамгаалах (худаг гаргах), бэлчээрийн арчилгаа, малын тууврын замыг засаж сайжруулахад зориулж орон нутгийн захиргааны төсвөөс жил бүр санхүүжилт хуваарилдаг.

Нигер	● Хөдөө орон нутгийн хуулийн байнгын нарийн бичгийн даргын газар (үндэсний, бүсийн түвшинд); Отор нүүдлийн үндэсний хороо.	● Мал аж ахуйн хөгжлийн үндэсний стратеги (2013–2035); Сахелийн бүс нутгийн мал аж ахуйг дэмжих төсөл	● Бэлчээрийн дэд бүтцэд зориулсан улсын төсөв байдаг ч ерөнхийдөө хангалтгүй байдаг.
Перу	● Хөдөө аж ахуйн хөгжил, усалгааны яам, Соёлын яам/ Соёл хоорондын харилцааны дэд яам.	● Сиерра Азул (Хөх уул) хөтөлбөр: Бэлчээрийн усалгаа, ус хуримтлуулах (бороо, цасны усыг уламжлалт аргаар нөөцлөх) хөтөлбөр; Мал аж ахуйн хөгжлийн үндэсний төлөвлөгөө 2017–2027.	● "Сиерра Азул" хөтөлбөрийн хүрээнд 2025 онд ойролцоогоор 20 сая ам.доллар төсөвлөсөн боловч энэ нь малчдад зориулагдсан тусгайлсан санхүүжилт биш.
Танзани	● Мал аж ахуй, загасны аж ахуйн яам: ерөнхий мандатынхаа хүрээнд малчдын асуудлыг шууд бусаар хариуцдаг.	● Дэд бүтцийн төслүүд: Бэлчээрийн бүс нутаг дахь дэд бүтцийн төслүүдийг хөгжлийн түншүүд (Олон улсын мал аж ахуйн судалгааны хүрээлэн, ТББ-ууд)-тэй хамтран хэрэгжүүлдэг; Тус яамнаас боловсруулсан "Танзани улсын мал аж ахуйн мастер төлөвлөгөө" ²⁴ нь зөвхөн малын ашиг шим, бүтээмжид зориулагдсан бөгөөд малчдын эрхийг орхигдуулсан.	● 2025–2026 оны төсөв: Мал аж ахуй, загасны аж ахуйн яамны төсвийн илтгэлд малын зах зээл болон сүү цуглуулах дэд бүтэц хөгжүүлэх асуудлыг тусгасан.

Судалгаанд хамрагдсан долоон улс орны хувьд малын нүүдэл хөдөлгөөнийг дэмжсэн төрийн дэмжлэгийн ямар нэгэн хэлбэр байдаг ч хэрэгжилт сул байна. Тухайлбал, Танзани улсад төрөөс дэмжсэн хөтөлбөр, төсөв байдаг ч голчлон суурин мал аж ахуйн менежментийн загварт чиглэжээ. Монгол улс 2024 онд батлагдсан “Малчны тухай хууль”-г орон нутгийн иргэд, малчдын оролцоо, зөвшилцөлгүйгээр баталсан. Түүний уршгаар малчид газраа хууль ёсоор эзэмшихэд олон шат дамжлага бүхий хатуу шаардлага, бүртгэлийн тогтолцоо бий болж, нүүдлийн амьдралын хэв маягаас хамааралтай малчдад улам хүндрэл учруулж байна. Энэ хуульд малчдын газрын эрх болон тэдний нүүдэл хийх эрхийг тусгасан заалт байхгүй. Кени улсад уламжлалт мал аж ахуйн институтыг урт хугацаанд гадуурхаж, орхигдуулж ирсэн нь сайтар боловсруулсан төрийн хөтөлбөрүүдийг үнэгүйдүүлж, үр дүнгүй болгох үндсэн шалтгаан болж байна.

6.3 Газар эзэмших эрхийг албажуулахтай холбоотой шаардлагууд

Судалгаанд хамрагдсан долоон улсад малчид өөрсдийн газар болон бэлчээр ашиглах эрхээ хууль ёсоор хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулахын тулд бүртгэлд хамрагдах, гэрчилгээ авах, эсвэл өмчлөх эрхийн баримт бичиг бүрдүүлэх зэрэг олон төрлийн захиргааны шаардлагыг биелүүлэх ёстой болдог.

Боливи улсад газар өмчлүүлэх үйл явц нь хугацаа шаардсан, хөрөнгө үрсэн ажил болдог. Кени улсад Хамтын газрын тухай хуулиар (2016) газрын эрхийг баталгаажуулахын тулд эхлээд олон нийтээрээ бүртгүүлэхийг шаарддаг. Газрыг өөрийн эзэмшилд бүртгүүлэх хуулийн зохицуулалттай ч хамтын газар бүртгүүлэх үйл явц нь хугацаа, хөрөнгө мөнгө шаардагддаг тул малчдын ихэнх нь албан ёсны өмчлөлийн гэрчилгээгүй хэвээр байна. Перу улсад Тариачдын болон Уугуул иргэдийн газар ашиглах эрхийг хуулиар хүлээн зөвшөөрөхийн тулд газар өмчлүүлэх үйл явцыг нотариатаар баталгаажуулсан

хурлын тогтоол, талбайн хил хязгаарыг тогтоосон баримт, хил заагийн тохиролцоо, төрийн байгууллагуудын бүртгэл зэрэг олон шат дамжлага бүхий захиргааны процесс шаардагддаг. Бүртгэлийн хураамжаас чөлөөлөх боломж байдаг ч малчид энэ бүх үйл явцын турш мэргэжлийн хүмүүсийн туслалцаа авсан төлбөр, нотариат, бусад холбогдон гарах томоохон зардлуудыг өөрсдөө төлдөг. Танзани улсад Тосгоны газар зохион байгуулалтын хамтарсан төлөвлөгөөнд бүртгүүлж, газрын эзэмшлээ албажуулахын тулд малчид эхлээд тосгондоо бүртгүүлэх, хил заагийн хэмжилт хийлгэх, газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, тосгоны хурал болон дүүргийн удирдлагуудаар хоёулангаар нь батлуулах шаардлагатай болдог. Дээрх үйл явц нь асар их шаардлага өндөртэйн дээр гаднаас техникийн туслалцаа, санхүүгийн дэмжлэг байхгүйгээр зөвшөөрөл авахад бэрхшээлтэй. Улмаар газрын эрхээ албажуулах үйл явц тэгш бус байгаагаас гадна, голдуу хөгжлийн түншүүд болон ТББ-уудын идэвхтэй үйл ажиллагааны хүрээнд л хэрэгжих боломжтойг харуулж байна.

Монгол, Балба улсуудын хувьд малчид уламжлалт эрхээ эдлэх, амьжиргаагаа авч явахад нь албан ёсны ямар нэгэн хязгаарлалт, саад бэрхшээл тулгардаггүй ч төрийн үйлчилгээнд хамрагдах эсвэл газар эзэмших эрхээ баталгаажуулахыг хүсвэл үлэмж хэмжээний шалгуур хангах хэрэгтэй болдог. Жишээ нь, Монгол улсад бүртгэл хийлгэх, захиргааны зөвшөөрөл авах, хоршооны гишүүн болох зэрэг шаардлага багтдаг бол Балба улсад орон нутгийн захиргааны журмуудыг дагах шаардлагатай болдог. Монголд өвөлжөө, хаваржааны газар эзэмших гэрчилгээ авахын тулд сумаас зөвшөөрсөн захирамж гарах ёстой. Харин Балба улсад Ойн хамтын санг эзэмшдэг олон нийтийн бүлгүүд бэлчээрийн талбайд нэвтэрсний төлөө малчдаас төлбөр хураамж шаарддаг нь тэдэнд санхүүгийн асар их дарамт учруулдаг байна. Тус зохицуулалт нь отор нүүдлээр голчлон амьдардаг, нийгмийн хамгийн эмзэг бөгөөд ядуу малчин өрхүүдэд хамгийн хүнд тусдаг.

Бусад орнуудаас ялгаатай нь, Нигер улс газрын гэрчилгээ олгохдоо малчдын бэлчээрт нэвтрэх эрхийг хувь хүний газар бүртгэл шаардахгүйгээр хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ малын нүүдлийн орон зай зааглах, маргаан шийдвэрлэхэд захиргааны журмууд үйлчилдэг.

Бүх л нөхцөлд, газрыг уян хатан, нүүдлийн байдлаар ашиглаж ирсэн малчид газраа албан ёсны болгож авахын тулд олон шат дамжлага бүхий захиргааны шаардлага, мөнгө санхүүгийн дарамтад орж, мөн системийн шинжтэй гадуурхалд өртөж байна.

Таллежунг дүүрэг дэх сарлаг болон хайнагийн бэлчээр. Гэрэл зургийг: Сураж Ожа



6.4 Малчин эмэгтэйчүүдэд тулгарч буй саад бэрхшээлүүд

Дээр дурдсан саад бэрхшээлээс гадна малчин эмэгтэйчүүдэд малын нүүдэл хөдөлгөөнд оролцох, газар болон бэлчээрээ ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд улам хүнд, хавсарсан саад бэрхшээлүүд тулгардаг. Хуулийн хамгаалалт сул, ялгаварлан гадуурхсан уламжлалт зан заншил, гэрийн ажлын тэнцвэргүй ачаалал зэрэг олон асуудал харилцан огтлолцсоны улмаас эмэгтэйчүүд газар нутгаа алдах, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж байна. Тиймээс эмэгтэйчүүд эрхээ хамгаалж чадахгүй байна. Хүснэгт 8-д малчин болон нүүдэлчин эмэгтэйчүүдийн амьжиргаанд тулгарч буй жендэрээс үүдэлтэй саад бэрхшээлийг улс бүрээр харьцуулан харуулав.

Хүснэгт 8. Малчин болон нүүдэлчин эмэгтэйчүүдэд тулгарч буй жендэрээс үүдэлтэй саад бэрхшээлүүд

Малчин эмэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээлүүд	КЕНИ	ТАНЗАНИ	НИГЕР	БАЛБА	МОНГОЛ	БОЛИВИ	ПЕРУ	Улсын тоо
Гэрийн ажил / асаргааны ачаалал нэмэгдэх (Хүүхэд, өндөр настныг асрах, гэр цэвэрлэх г.м)	●	●	●	●	●	●	●	7
Ус болон байгалийн баялгийн хүртээмж хумигдах	●	●	●	●		●	●	6
Олборлох үйлдвэрлэл (Уул уурхайн бохирдол, албадан нүүлгэлт)			●	●	●	●	●	5
Жендэрт суурилсан хүчирхийлэл, аюулгүй байдлын эрсдэл нэмэгдэх	●	●	●		●		●	5
Суурин хэв маягт шилжих / Уламжлалт газар нутагтаа амьдрах эрхээ алдах	●	●	●	●		●	●	6
Шийдвэр гаргах түвшин, засаглалын үйл ажиллагаанаас гадуурхагдах		●	●	●	●			4
Дэд бүтцийн хязгаарлалууд (Авто зам, далан усыг хааж нутаг дэвсгэрийг хуваах)		●		●		●	●	4
Орлого / мал аж ахуй эрхлэхэд тавьдаг тэнцвэргүй хяналт	●	●	●	●				4
Улс бүрд тулгамдаж буй саад бэрхшээл	5	7	7	7	4	5	6	

Эмэгтэйчүүд жендэрээс үүдэлтэй саад бэрхшээлтэй нүүр тулж, эрх зүйн хувьд хангалттай хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхгүй хэвээр байна. Гэтэл улс орнууд малчин эмэгтэйчүүдийн эрх, аюулгүй байдлыг хангах тусгайлсан хөтөлбөр, бодлого хэрэгжүүлэхгүй байна. Судалгаанд хамрагдсан долоон улсад бэлчээрийн дэд бүтцийн төлөвлөлт, засгийн газрын хөтөлбөр, төсөв нь эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээг үндсэндээ орхигдуулж иржээ. Бодлогын энэ хоосон орон зай нь эмэгтэйчүүдэд тулгардаг саад бэрхшээлийг улам даамжруулж байна. Отор нүүдлийн зурвас газарт аюулгүй усны эх үүсвэр, амралтын бүс болон хүртээмжтэй төрийн үйлчилгээ байхгүй тохиолдолд нүүдлийн явцад гардаг эдийн засгийн зардал, аюулгүй байдлын эрсдэлүүд малчин эмэгтэйчүүдийн нуруун дээр илүү хүнд ачаа болж буудаг. Эмэгтэйчүүд отор нүүдлийн урт, хүнд нөхцөлд ч ус бэлтгэх, мал маллах, гэр ахуйн ажлаа амжуулах зэрэг гэр бүлийн асрамжийн үндсэн үүргийг давхар гүйцэтгэсээр байдаг тул ийнхүү давхар хүнд ачаа болж байгаа билээ.

Малчин эмэгтэйчүүдийн хэрэгцээг олон нийтийн түвшинд анхаарч үзэж буй нотолгоо Боливи, Балба, Перу улсуудын кэйс дээр гарсан. Гэвч эдгээр жишээ нь эмэгтэйчүүдийг хуулийн хүрээнд бодитойгоор хамгаалж буй системийн шинжтэй арга хэмжээ биш, нэг удаагийн шинжтэй тохиолдлууд юм. Боливи улсын ТББ-ууд Андын өндөрлөг

бүсэд жендэрийн тэгш байдлын хангах зорилтын хүрээнд борооны ус хуримтлуулах төслүүдийг хэрэгжүүлжээ. Балба улсад сүүлийн жилүүдэд, орон нутгийн засаг захиргаанаас охид, эмэгтэйчүүдийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгууд, ойн хамтын сангийн нутаг дэвсгэр дээрх малчдын нүүдлийн зурвас дагуу ундны усны цэг, ариун цэврийн байгууламж, аюулгүй байдлын мэдээллийн самбаруудыг байршуулж эхэлжээ. Албан ёсны малын нүүдлийн зурвасгүй Перу улсад зарим тариачид үндэсний бодлогод өөрчлөлт орохыг хүлээхгүйгээр, эмэгтэйчүүдийг хамгаалсан тусгайлсан заалтуудыг өөрсдийн дотоод дүрэм журамдаа тусгаж байна. Тухайлбал, жирэмсэн эмэгтэйчүүдийг заавал биелүүлэх албадан хөдөлмөрөөс чөлөөлөх, малчин эмэгтэйчүүдэд зориулсан ус хуримтлуулах дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх зэрэг зохицуулалтуудыг хийжээ.

7. Нүүдэллэх, газар ашиглах эрхээ эдлэх уламжлал шийдвэр гаргалт

Газар, ус, бэлчээрийн нөөц ашиглах, нүүдэл хөдөлгөөн хийх, шийдвэр гаргах үйл явцаа удирдан чиглүүлэх дотоодын дүрэм журам, хэм хэмжээ болсон уламжлалт зохицуулалт нь малчдын хувьд газар эзэмших баталгааны амин чухал хэсэг нь болдог. Малчид, нүүдэлчид уламжлалт байдлаар шийдвэр гаргах үйл явц, тэдгээрийн бичмэл хуультай холбогдох хамаарал нь судалгаанд хамрагдсан долоон улсын хэмжээнд эрс ялгаатай байна. Тодруулбал, төрөөс малчдын уламжлалыг тогтолцоог хүлээн зөвшөөрч, хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэхээс авхуулаад хуулийн дагуу албадан хэрэгжүүлэх боломжгүй аман зохицуулалтуудаараа улс орнууд ялгарч байна. Хүснэгт 9-д малчин, нүүдэлчид уламжлалт засаглалаа хэрэгжүүлж буй хэлбэр, түүнийг төрөөс хуулиар хүлээн зөвшөөрдөг эсэх талаарх дэлгэрэнгүй дүр зургийг харуулав.

Хүснэгт 9. Уламжлалт зохицуулалтын төлөв байдал (Улс орнуудаар)

Улс	Уламжлалт зохицуулалтын төлөв байдал	Тэмдэглэл
Боливи	Уламжлалт зохицуулалтыг төрөөс хүлээн зөвшөөрдөг.	Олон нийтийн дотоод зохицуулалт: олон нийт, тэдгээрийн уламжлалт удирдлагын байгууллагууд болох айллу, маркас, суюу нь үндсэн дүрэм, өөрсдийн дотоод журмаар удирддаг. Нийтийн эзэмшлийг хамтран ашиглах: олон нийт өөрсдийн газар нутгийн хил хязгаар, дундын ашиглалтын бүсээ төрөөс баталгаажуулсан нийтийн бүртгэлд албан ёсоор баримтжуулах замаар газар ашиглах зөвшилцөлд хүрдэг. Уламжлалт хэм хэмжээний хүрээнд эвлэрлийн болон зөвшилцлийн гэрээг албан ёсоор соёрхон баталж, хуулийн дагуу биелүүлдэг.
Кени	Уламжлалт зохицуулалтыг төрөөс хүлээн зөвшөөрдөг.	<i>Хамтын газрын тухай хууль (2016)</i> нь хамтын газрын менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан уламжлалт засаглалын дүрмүүдийг хуульчилсан эрх зүйн тогтолцоотой. Малчид хоорондын бэлчээр харилцан ашиглах уламжлалт гэрээ хэлцлүүд байдаг ч ихэвчлэн аман хэлбэрээр байдаг. Байгаль хамгааллын тусгай бүсүүдэд суурилсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь газар ашиглах уламжлалт шийдвэр гаргалттай уялдахыг хичээдэг ч түүнийг албажуулах үйл явц амьдрал дээр маш хоцрогдолтой.

Монгол	Уламжлалт зохицуулалтын талаарх ойлголт, мэдлэгтэй ч хууль эрх зүйн баталгаа байхгүй	Бэлчээр ашиглалтыг амьдрал дээр нутгийн ахмад малчдын харилцан зөвшилцлөөр баталгаажсан аман хэлэлцээрээр зохицуулдаг бөгөөд хөрш саахалтын хамтын үүрэг хариуцлагыг гол зарчмаа болгодог. Малчдын дунд бэлчээр ашиглалтаа бичгээр гэрээлж баталгаажуулах практик улам бүр нэмэгдэж байгаа ч энэ нь албан ёсны эрх зүйн статусгүй (шүүх, захиргааны өмнө хүчин төгөлдөр бус).
Балба	Уламжлалт зохицуулалтын талаарх ойлголт, мэдлэгтэй ч хууль эрх зүйн баталгаа байхгүй.	Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэхийн тулд холбогдох удирдах албан тушаалтнаас бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай. Тусгай хамгаалалттай газар нутгаас гаднах бүсэд малчид болон ойн хамтын сангийн бүлгүүдийн хэлэлцээр бараг бүхэлдээ аман хэлбэртэй, баримтжуулаагүй байдаг. Хамтын сангийн зарим бүлгүүдээс бэлчээрийн хураамж авсан төлбөрийн баримт өгдөг нь энд ашигладаг цорын ганц бичмэл баримт юм.
Нигер	Уламжлалт зохицуулалтыг төрөөс хүлээн зөвшөөрдөг.	Нигер улсын “Хөдөө орон нутгийн тухай хууль” нь газар тариалан болон бэлчээрийн газрыг уламжлалт байдлаар удирдан зохион байгуулах эрхийг албан ёсоор орон нутгийн ахлагч нарт олгодог. Малчид, бусад газар ашиглагчдын хоорондын харилцаа, үйл ажиллагааг орон нутгийн институтээр дамжуулан зохицуулдаг.
Перу	Уламжлалт зохицуулалтыг төрөөс хүлээн зөвшөөрдөг.	Олон нийтийн дотоод дүрэм нь тариачид, уугуул иргэдийн дотоод засаглалын хууль ёсны баримт бичиг юм. Түүнчлэн ган гачигтай улиралд усыг түр хугацаанд ашиглах талаар олон нийт хоорондын аман хэлэлцээрүүд байдаг. Үүний баримтжуулсан кейс нь Бадопампа дахь Жарапампа, Пукаяку хамт олны дундаа ашигладаг усан сангийн хамтрал юм.
Танзани	Уламжлалт зохицуулалтыг төрөөс хүлээн зөвшөөрдөг.	Тосгоны газар зохион байгуулалтын хамтарсан төлөвлөгөө нь бэлчээрийн бүс нутаг болон малын нүүдлийн зурвасууд түүнчлэн, олон нийт дотооддоо газар ашиглалтын хэлэлцээрийг хийх албан ёсны хууль эрх зүйн үндэс болдог.

Монгол, Балба улсуудад амьдрал дээр өргөн хэрэглэгддэг ч хуульчлаагүй, албан бус зохицуулалтыг голчлон ашиглаж байна. Монгол улсад малчид бэлчээр ашиглалтыг уламжлалт байдлаар улирлын чанартай харилцан ашиглах зохицуулалт болон орон нутгийн хурлын шийдвэрээр зохицуулж байгаа ч энэ нь хуульчлагдаагүй. Тиймээс уул уурхайн тэлэлт, газар ашиглалтын зорилгыг өөрчлөх үед малчид газраа алдаж, шахагдах эрсдэлд ордог. **Хуулиар хүлээн зөвшөөрөөгүй газар ашиглах уламжлалт зохицуулалт нь эрх мэдэл илүү оролцогчдын эрх ашиг хөндөгдөх үед албадан хэрэгжих эрх зүйн чадамжгүй болдог учир хуулиар хүлээн зөвшөөрсөн эсэх нь маш чухал юм.**

7.1 Уламжлалт эрх зүйн хүрээн дэх эмэгтэйчүүдийн эрх

“Бид уламжлалт туршлагыг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүлээн зөвшөөрүүлэх нөлөөллийн ажил хийхийн зэрэгцээ, түүнийг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлэх стратеги гарган ажиллах ёстой. Үүнийг хийх үр дүнтэй аргын нэг бол уламжлалт институтүүд доторх эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлж, тэднийг дуу хоолойг дэмжих замаар олон нийтийнхээ дунд бүрэн эрхт гишүүн хэмээн хүлээн зөвшөөрүүлэх явдал билээ.”²⁵

— Соланж Бандиаки-Бажи, ЭНС байгууллагын ерөнхийлөгч бөгөөд зохицуулагч

Судалгаанд хамрагдсан долоон улс газрын засаглал дахь жендэрийн ялгаварлан гадуурхалтыг эрх зүйн тогтолцоондоо хориглосон ч малчин эмэгтэйчүүдийг хамгаалах тусгайлсан зохицуулалт дутмаг хэвээр байна (Хүснэгт 5). Бичмэл хууль, олон нийтийн уламжлалт туршлага болон эмэгтэйчүүдийн газар эзэмших эрхийн хэрэгжилт хоорондын хамаарал нь салбар дундын нарийн төвөгтэй, зангилаа асуудал байдаг. Энэ ээдрээтэй байдал нь тухайн олон нийтийн язгуур соёл, эрх зүйн олон ургалч үзэл, шашны нөлөө, нөхцөл байдлаас хамаарах жендэрийн үнэт зүйлийн өвөрмөц онцлогоос үүдэлтэй. Хууль эрх зүйн хамгаалалт хангалтгүй байгаа нь нэг талаас хууль тогтоомжид эмэгтэйчүүдийн газар эзэмших эрх, жендэрийн тэгш байдлын баталгааг бүрэн тусгаж чадаагүйтэй холбоотой байж болох юм. Нөгөө талаас, байгалийн нөөцийг ашиглах шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн бодит, үр дүнтэй оролцоог системтэйгээр хязгаарлаж ирсэн малчдын уламжлалт зохицуулалттай хавсарснаар эмэгтэйчүүдэд ирэх сөрөг нөлөөллийг улам хурцатгаж байна.


Хүснэгт 10. Уламжлалт эрх зүйн хүрээн дэх эмэгтэйчүүдийн эрхийн төлөв: хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн практик жишээнүүд


Улс	Төлөв	Ерөнхий хамгаалалт	Олон нийтийн дотоод дүрэм журам ба хэрэгжилт хоорондын зөрүү
Боливи	● Хамгаалсан хууль тогтоомжтой. Эерэг болон гадуурхасан олон нийтийн дүрэм журам	Үндсэн хуульд (402.2-р заалт) газар ашиглах, эзэмших, өвлөх эмэгтэйчүүдийн эрхэд учруулж буй аливаа алагчлалыг арилгахыг төрд үүрэг болгосон.	Зарим олон нийтийн (айллу, марка, суюу) дотоод дүрэмд эмэгтэйчүүдийг үндэсний хууль тогтоомжтой нийцүүлэн, эрэгтэйчүүдтэй адил тэгш эрхтэй гэж тусгасан. Жишээ нь: "Айлли Оригинарио Хуанкане"-ийн дүрэмд (2019) эмэгтэйчүүдийг алагчлахгүйгээр гишүүнээр элсүүлэхийг заасан. Гэвч бодит амьдрал дээр зарим олон нийт Үндсэн хуульд тусгагдсан уламжлалын хүрээнд эмэгтэйчүүдэд хэт тэнцвэргүй эдийн засгийн дарамт үзүүлж замаар эрх мэдлийг нь сулруулж, хараат байдалд байлгахад нөлөөлж байна.
Кени	● Жендэрийн мэдрэмжтэй олон нийтийн дүрэм журам байхгүй.	Газар ашиглалтын бодлогодоо (2017) бэлчээрийн бүс нутаг дахь эмэгтэйчүүдийн эрхийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, хамгаалахыг, түүнчлэн газрын засаглалд (шийдвэр гаргах түвшинд) эмэгтэйчүүдийн хувь тэнцүүлсэн төлөөлөл хангах зохицуулалттай.	Хуулиар хүлээсэн үүрэгтэй ч, бодит амьдрал дээр газрын болон нүүдэллэх засаглалаас эмэгтэйчүүдийг гадуурхах явдал малчин институтуудад олон байна.


<p>Монгол</p>	<p>● Хуулийн хүрээнд хамгаалсан, олон нийтийн дотоод дүрэм журамд эерэг зохицуулалт бий.</p>	<p>Үндсэн хуульд (16.11 дүгээр зүйл) эрэгтэй, эмэгтэй хүмүүс улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй байхыг хуульчилсан. Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар (2011, 9.2 заалт) газар болон үл хөдлөх хөрөнгийг адил тэгш эзэмших эрхтэй гэж заасан.</p>	<p>Уламжлалт хэм хэмжээнд мал аж ахуй эрхлэх, өрхийн шийдвэр гаргах, гэр бүлийн өмч өвлөхөд эмэгтэйчүүдийн үүрэг, оролцоог хүлээн зөвшөөрдөг. Эмэгтэйчүүд усан хангамж, нүүдэл суудал, бууцны байршлыг тогтоох шийдвэр гаргалтад оролцдог. Мөн сумын түвшинд эмэгтэйчүүдийн холбоо, зөвлөлүүд ажилладаг.</p>
<p>Балба</p>	<p>● Хуулийн хүрээнд хамгаалсан ч олон нийтийн дотоод дүрэм журамд ялгаварласан зохицуулалт бий.</p>	<p>Ойн тухай хууль (2019, 22-р заалт), Ойн журам (2022, 42(8)-р дүрэм)-р Ой ашиглагчдын олон нийтийн гүйцэтгэх хороонд эмэгтэйчүүдийн оролцоог тэгш хангах үүрэгтэй. Түүнчлэн мал аж ахуйн хоршоодын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангахыг шаарддаг.</p>	<p>Гималайн ууланд амьдардаг уугуул олон нийт дунд эмэгтэйчүүд нийгмийн өндөр хүндэтгэл хүлээдэг. Гэвч тэд бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой шийдвэр гаргалтад оролцож чадахгүй гадуурхагдсан хэвээр байна. Эмэгтэйчүүдийн оролцоо институтчилэгдсэн байдлаар бус, ихэнхдээ албан бус байдлаар хэрэгжиж байна.</p>
<p>Нигер</p>	<p>● Жендэрийн мэдрэмжтэй олон нийтийн дүрэм журам байхгүй.</p>	<p>Хөдөө орон нутгийн хуульд байгалийн баялагт хүйсээр ялгаварлан гадуурхахыг нэр төдий хориглодог.</p>	<p>Бодит байдал дээр уламжлалт засаглалын хүрээнд эмэгтэйчүүдийг ялгаварладаг. Эмэгтэйчүүд бэлчээрийн менежментийн хороо, усны хороо, орон нутгийн газрын комисс зэрэг бэлчээрийн нөөцийг удирдах уламжлалт засаглалын үйл ажиллагаанд туйлын ховор оролцдог. Отор нүүдлийн зурвас, ус эзэмших уламжлалт эрхийг голчлон өрхийн тэргүүн эрэгтэйчүүд, омгийн ахлагч нар эзэмшдэг.</p>
<p>Перу</p>	<p>● Эерэг болон ялгаварлан гадуурхсан олон нийтийн дүрмүүд зэрэгцэн оршдог, бас газар эзэмших эрхийг баталгаажуулсан хуулийн хамгаалалт байхгүй.</p>	<p>Үндсэн хуулиар ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг ерөнхий байдлаар баталгаажуулдаг ч, Перу улс эмэгтэйчүүдийн өмчлөх эрхийг хууль тогтоомждоо тусгайлан тусгаагүй.</p>	<p>Түүхэндээ, өнөөдөр ч орон нутгийн дүрэм журамд эрэгтэй хүйсийг заасан ерөнхий нэр томъёог нийтлэг ашигладаг. Ингэснээр газар, бэлчээр, ус болон дундын нөөцийг ашиглах, эзэмших боломжоос эмэгтэйчүүдийг орхигдуулж байна. Тэгш оролцоог хангасан дүрэм журам нь тогтсон стандарт гэхээсээ илүүтэй онцгой тохиолдлын шинжтэй байдаг.</p>
<p>Танзани</p>	<p>● Жендэрийн мэдрэмжтэй олон нийтийн дүрэм журам байхгүй.</p>	<p>Газрын тухай хуулийн №4 (1999), Тосгоны газрын тухай хуулийн №5 (1999)-р эмэгтэйчүүдийн газар эзэмших тэгш эрхийг баталгаажуулж, аливаа ялгаварлан гадуурхах практик, үйлдлийг хориглосон. Тосгоны зөвлөлүүд газрын засаглалыг хэрэгжүүлэх, удирдах үйл ажиллагаандаа алагчлах үзэл гаргахгүй байх үүрэгтэй.</p>	<p>Орон нутгийн уламжлалын хууль (GN №436, 1963) нь эрэгтэй залгамжлагчдад давуу эрх олгож, бэлэвсэн эхнэрүүдэд зөвхөн тодорхой нөхцөлтэйгөөр газар ашиглах эрх олгодог. Гэрлэлт, өв залгамжлалын хуулиудыг газрын тухай хуультай нийцүүлэн шинэчилж байгаагүй нь бүтцийн хувьд ноцтой зөрчилдөөнийг үүсгэсэн. Тухайлбал: Газрын хууль нь жендэрийн тэгш байдлыг баталгаажуулдаг ч гэр бүл, өв залгамжлалын эмэгтэйчүүдийг ялгаварлах асуудал байсаар байна.</p>

8. ЗӨВЛӨМЖ


1. Малчдын нүүдэллэх эрхийг тэдний суурь эрх гэж хуулиар онцгойлон баталгаажуулах

 Засгийн газрууд малчдын нүүдэллэх эрхийг суурь эрхийн хэмээн тусгайлсан хуулиар хамгаалж, хэрэгжилтийг албажуулах, одоогийн эрх зүйн хэрэгжилтийг сайжруулах


 Засгийн газрууд улс дамнасан отор нүүдэлд зориулсан аюулгүй зурвас, хамгаалалтыг бий болгох дипломат болон олон улсын эрх зүйн тусгайлсан хүчин чармайлт гаргах шаардлагатай. Мөн бүс нутаг, эсвэл улс дамнасан бодлогын хүрээг үндэсний хууль эрхзүйн тогтолцоонд тусгаж, дотоодын хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах

 Малчдын эрхийг уугуул иргэд, эсвэл олон нийтийн газар ашиглалт/ эзэмшлээс илүү өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, тэдний нүүдэллэх эрхийг ерөнхий байдлаар бус нэр заан, тусгайлан хуульчилж баталгаажуулах

2. Отор нүүдлийн орон зай, усны эх үүсвэр, хужиртай газар, улирлын чанартай бэлчээрийн газрыг хууль эрх зүйн хүрээнд албажуулах, хамгаалалтад авах

 Засгийн газрууд малчидтай түншлэх замаар бэлчээрийн бүс нутаг, газрын бүртгэл зохион байгуулж эцэслэх, улмаар эдгээрийг хуульчилсан газрыг албаны төлөвлөгөөндөө тусгах шаардлагатай. Ингэхдээ уламжлалт засаглалын тогтолцоотой уялдуулахын зэрэгцээ, олборлох салбар (уул уурхай), газар тариалан, байгаль хамгаалах шалтгаанаар бэлчээрийн газарт халдах, түрж орохоос хамгаалах зохицуулалт хийх

3. Бэлчээр ашиглалтын уламжлалт зохицуулалтуудыг албажуулж, эрх зүйн хамгаалалтад авах

 Малчдын өөрсдийнх нь удирдлага, манлайлалгүйгээр уламжлалт засаглалын тогтолцоог төр авах, эсвэл малчдад ахадсан нүсэр захиргааны бүтэц, хүнд суртал тулгалгүйгээр тэдний уламжлалт газрын засаглалыг хуулиар хүлээн зөвшөөрч, хамгаалах

4. Малчин эмэгтэйчүүдийн нүүдэл, газар ашиглалт, засаглал дахь оролцоог хамгаалсан, тэдний онцлогт тохирсон тусгайлсан хууль тогтоомж батлах. Үүгээр дамжуулж эмэгтэйчүүдийн нүүдэллэх, олон нийт болон холбогдох засаглалын байгууллагад тэгш гишүүнчлэлтэй оролцох эрхүүдийг баталгаажуулах. Эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, бодит хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөсөн отор нүүдлийн зурвас зам, аюулгүй усны цэг, ариун цэврийн байгууламж, эрүүл мэндийн үйлчилгээнд саадгүй нэвтрэх эрхийг хангах

5. Байгалийн нөөцийн олборлолт, байгаль хамгаалал, уур амьсгалын санхүүжилтийн бодлогын хүрээг малчдын эрхтэй уялдуулах. Ногоон болон нүүрстөрөгчийн төслүүд, тусгай хамгаалалттай газар нутгийн тэлэлт, эрчим хүчний төсөл, уул уурхай болон олборлох үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь малчдын отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хамгийн ноцтой заналхийлэл учруулж байгааг анхаарах



Засгийн газрууд болон хөгжлийн түншүүд аливаа төсөл хэрэгжүүлэхийн өмнө малчдын эрхэд үзүүлэх нөлөөллийг үнэлгээг заавал хийлгэхийг шаардах. Бэлчээрийн бүс нутагт хэрэгжих төслүүдийн зөвшөөрлийг сайн дураар, урьдчилан мэдээлэл авсны үндсэн дээр орон нутгийн иргэдээс авахыг үүрэгжүүлэх, энэ үйл явцад эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцогч, шийдвэр гаргагч болох боломжоор хангах



Засгийн газрууд нь малчид, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид нүүдэлчдийн эрхийг шууд зөрчсөн аливаа уул уурхайн хайгуул хийх, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, нүүрстөрөгчийн төслийн гэрээ байгуулах буюу зөвшөөрөх, эсвэл бусад холбогдох дэд бүтэц, хөгжлийн төслүүдийн үйл ажиллагааг нэн даруй зогсоох. Ялангуяа эдгээр төслүүд нь малчид, нүүдэлчдийн түр болон байнгын суурьшил, бэлчээрийн газартай давхцаж байгаа бол үйл ажиллагааг шууд хориглох, зогсоох

1. Энэхүү судалгаа болон Эрх, нөөцийн санаачилга (ЭНС) байгууллагын малчид, нүүдэлчдийн асуудлыг судлах арга зүйд энэ хуудсанд хэрэглэж буй дэлгэрэнгүй тодорхойлолтыг ашиглана. Судалгаанд хамрагдсан долоон улсын үнэлгээнд уг тодорхойлолтод дурдсан бүх олон нийтийн бүрэн багтаагаагүй байж болох ч, энэ арга зүйг цаашид бусад улс орон, экосистем, малчид, нүүдэлчдийг нэмж хамруулах замаар судалгаа өргөжүүлэх боломжтой хэлбэрээр боловсрууллаа. Уг үнэлгээнд багтсан цорын ганц нүүдэлчин Уугуул иргэд нь Боливи, Перу улсуудад амьдардаг өөрсдийгөө сайн дураараа тусгаарлагдсан уугуул иргэд, нүүдэлчид юм.

2. Кали Цай, Х.Ф. 2024. A/79/160: Уугуул иргэдийн эрхийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн тайлан: Нүүдэлчин уугуул иргэд. НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын алба, Женевийн салбар. Цахим хаяг: <https://docs.un.org/en/A/79/160>.

3. Тус судалгааны арга зүйн бүрэн эх, шалгуур үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг цахимаар авч үзэх боломжтой бөгөөд энэ арга зүйг цаашид практик үйл ажиллагаа болон малчид, нүүдэлчдийн олон нийттэй хамтран ажиллах явцад улам боловсронгуй болгох "тасралтгүй хөгжих арга зүйн хүрээ" гэж ойлговол зохиолтой. Түүнчлэн өөр бус нутаг, нөхцөл байдал дахь олон нийтийн газрын эзэмшлийн олон янзын эрх, бодит байдлыг илүү оновчтой тусгах үүднээс уг арга зүйг уян хатан байдлаар нутагшуулан ашиглав. Улс орнуудын өгөгдлийг файл хэлбэрээр хүсэлт итгээн авах боломжтой.

4. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц (UNCCD). 2024. Бэлчээр ба бэлчээрийн мал аж ахуйн асуудлаарх Дэлхийн газрын төлөв байдлын сэдэвчилсэн тайлан. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц, Бонн, вий, 8. Цахим хаяг: <https://www.unccd.int/sites/default/files/2024-05/GLO%20rangelands%20full.pdf>.

5. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц. 2024.

6. Олон улсын бэлчээр ба малчдын жил (ОУБМЖ). 2024. Бэлчээрийн мал аж ахуй ба газрын асуудлаарх ОУБМЖ-ийн Ажлын хэсэг: Үзэл баримтлалын тэмдэглэл. Ажлын хэсгийн үзэл баримтлалын тэмдэглэл, 2024 оны 2 дугаар сарын 21. Цахим хаяг: https://iyrp.info/sites/default/files/Concept%20note%20WG%20pastoralism%20%26%20land%2021_02_24.pdf.

7. Хил хязгаарын зарим асуудлаар тохиролцоонд хүрсэн хэдий ч Кени улс нь Маасай олон нийт амьдардаг, уламжлалт нүүдэл хийдэг Танзани улстай малчдын улс дамнасан хөдөлгөөнийг хөнгөвчлөх тусгайлан хэлэлцээр байдаггүй. Түүнчлэн Кени улсын нэгдэн орсон хэлэлцээрүүдийн хэрэгжилт амьдрал дээр маш хангалтгүй хэвээр байна. Аюулгүй байдлын хяналтыг хэт чангаруулах (хилийг цэрэгжүүлэх), аливаа дүрэм журмыг иргэдэд өөрсдийн үзэмжээрээ тулгаж, дотоодын эрх зүйн дэмжлэг, зохицуулалт дутагдаж байгаа нь хамгаалалтын механизм сулруулж байна. Хилийн бүс нутгуудад аюулгүй байдал алдагдсан, бүс нутгийн болон олон улсад хүлээсэн үүрэг амлалтын хэрэгжилт сул, түүнийг зохицуулалт болон таниулах ажиллагаа дутмаг, мөн бүс нутгийн хууль тогтоомж, бодлогууд хоорондоо зөрчилдсөн, уялдуулаагүй зэрэг сорилтууд байсаар байна.

8. Гаутам, Ананда. 2025. "Төвөдийн худалдаа зогсож, орлого буурсан нь сарлагийн малчдыг сүйрлийн ирмэгт хүргэлээ." Катманда Пост, 3 дугаар сарын 25. Цахим хаяг: <https://kathmandupost.com/province-no-1/2025/03/25/halted-tibet-trade-and-dwindling-income-push-yak-herders-to-the-brink>; Сингх, Басант Пратап. 2026. "Хятад улс хил дамнасан бэлчээрийн хөдөлгөөнийг чангатгаснаар мал аж ахуй хямралд орлоо." Катманда Пост, 2 дугаар сарын 3. Цахим хаяг: <https://kathmandupost.com/sudurpashchim-province/2026/02/03/livestock-farming-in-crisis-as-china-tightens-cross-border-grazing>.

9. Перу улсын хууль тогтоомжид хил дамнасан амьдралын хэв маягийг хамгаалсан цорын ганц зохицуулалт нь зөвхөн "өөрсдийгөө сайн дураараа тусгаарлагдсан Уугуул иргэд"-д л хамаардаг. 008-2007-МС тоот тогтоолоор тэдний уламжлалт нутаг дэвсгэр улсын хил дамнаж болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд холбогдох хоёр талт хэлэлцээрийг байгуулах үүргийг Соёлын яам болон Гадаад харилцааны яаманд хариуцуулсан байдаг.

10. Ганье, Мари. 2022. "Нигер: Нөхцөл байдал ба газрын засаглал." Газрын Порталын Сан, Энскеде. Цахим хаяг: https://landportal.org/book/narratives/2022/Нигер_улс.

11. Сулле (2021), UCRT (2024) -с дэлгэрүүлж үзнэ үү.

12. Танзани улсын газар, мал аж ахуй, байгаль хамгааллын хууль тогтоомжид бэлчээрийн нүүдэл шилжилт хөдөлгөөнийг малчдын суурь эрх гэж хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд зарим тохиолдолд үүнийг хязгаарлах, улмаар эрүүгийн хэрэгт тооцох ч явдал гардаг. Энэ нь мал аж ахуйг хоцрогдсон, "орчин үеийн шинэчлэл" шаардлагатай салбар гэж үздэг улс төрийн урт хугацааны хэвшмэл ойлголттой холбоотой бөгөөд суурин амьдралын хэв маяг, байгаль хамгааллыг туйлшруулсан хандлагыг улам гааруулж байна. Тус улсын Тосгоны газрын тухай хууль (1999) болон Газар ашиглалтын төлөвлөлтийн тухай хуулиар (2007) бэлчээрийн бүс, малын зурвас зам, дундын нөөцийг төлөвлөх, удирдах

замаар бэлчээрийн мал аж ахуйг хууль ёсоор эрхлэхийг зөвшөөрдөг боловч зөвхөн тосгон, дүүргээс тогтоосон хатуу хил хязгаарын хүрээнд, захиргааны зөвшөөрлөөр хэрэгжихээр хязгаарлагджээ. Тодруулбал, нүүдэллэх эрхийг малчдын уламжлалт амьжиргааны баталгаа гэж үзэхээс илүүтэй газар ашиглалтын "нөхцөлт үр дагавар" төдийнхөөр хүлээн авч байна. Газрын тухай хууль (1999) нь газрын байршлыг хэмжиж баталгаажуулсан, хатуу тогтоосон өмчлөл, эзэмшлийн эрхийг илүүд үзсэнээрээ энэхүү өрөөсгөл хандлагыг улам гүнзгийрүүлж, улирлын чанартай болон алсын отор нүүдлийг эрх зүйн ямар ч хамгаалалтгүй орхижээ. Түүнчлэн, бэлчээрийн газар, малын тэжээлийн нөөцийн тухай хуулиар (2010) мал бэлчээрлэх, нүүдэллэх үйл явцыг тусгай зөвшөөрөл, тогтоосон чиглэл, хатуу шаардлагуудаар нарийвчлан зохицуулсан байдаг. Энэ нь малчдын нүүдлийг байгаль, нийгмийн харилцан шүтлцээт стратеги гэж ойлгохоос илүүтэй хяналт зохицуулалт шаардсан байгаль орчны эрсдэлт "асуудал" мэтээр тодорхойлоход хүргэж байна.

13. Монгол улсын Үндэсний статистикийн хороо (ҮЦХ). 2025. Мал сүргийн статистик: 2024 оны 1-12 дугаар сар. Монгол улсын Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар. Цахим хаяг: https://downloads.1212.mn/L1w4s_EFj0rb5K-PjdqG-Ml32-0z_2eJb-CaGto_.pdf.

14. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (НҮБХХААБ). 2021. Монгол улс дахь бэлчээрийн мал аж ахуй: Үйлдвэрлэл ба байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтын тэнцвэр. НҮБХХААБ, Ром. Цахим хаяг: <https://openknowledge.fao.org/server/api/core/bitstreams/66984f04-a8fb-46ee-8155-0944f82b2b38/content>.

15. Кали Цай, Х.Ф. 2024.

16. Түрээсийн болон ургац хуваах гэрээг жижиг, дунд хэмжээний болон арилжааны зориулалттай хувийн өмчийн газарт байгуулахыг зөвшөөрдөг бөгөөд харин хамтын болон уугуул иргэдийн дундын газарт байгуулахыг шууд хориглоно. Уг гэрээг заавал бичгээр үйлдэж, Газрын шинэчлэлийн үндэсний байгууллагад бүртгүүлсэн байх шаардлагатай. Түүнчлэн гэрээний хугацаа гурван жилээс, гэрээгээр ашиглуулах талбайн хэмжээ нь тухайн газар эзэмшигчийн идэвхтэй ашиглаж буй нийт талбайн 50 хувиас хэтрэхгүй байх журамтай. (DS 29215, 165 дугаар зүйл).

17. Мориц, Марк, Флора Верн, болон Саверио Крэтти. 2025. "Бэлчээрийн мал аж ахуйн газрын эрхийг баталгаажуулах нь." Бодлогын зөвлөмж, ОУБМЖ-ийн Малчид ба газрын эрхийн асуудлаарх ажлын хэсэг. Цахим хаяг: <https://iyrp.info/sites/default/files/2025-07/Policy-brief-Securing-Land-Rights-for-Pastoralism-final-14.22.50.pdf>.

18. 1997 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн №97-007/MAG/EL тоот тогтоол.

19. Боливи улсад малчид уугуул иргэдийн эсвэл тариачдын нийгэмлэгт харьяалагддаг тул "Уугуул иргэдийн нутаг дэвсгэрийн тухай" болон "Хамтын өмчийн тухай" хуулиудын хүрээнд газрыг хамтран эзэмших эрх олж авах боломжтой. Танзани улсын тухайд, хилийн заагийг албан ёсоор тогтоож бүртгэлжүүлсэн, төлөвлөлт бүхий тосгоны газар нутагт газрын онцгой эрхийг баталгаажуулж болно. Балба улсад Газрын тухай болон Бэлчээрийн үндэсний өмчид авах тухай хуулиар газар өмчлөгчид, түүний дотор малчин өрхүүд уулархаг болон толгодлог бүсэд тогтоосон дээд хязгаар (8.75 акр буюу 3.54 гектар)-аас хэтрэхгүй хэмжээний газрыг хувиараа эзэмших эрхтэй бөгөөд уг хувийн өмчийн бэлчээртээ онцгой эрх эдэлдэг.

20. Үндсэн хуулийн 394 дүгээр зүйлийн III дахь заалт, 30 дугаар зүйл; Ерөнхийлөгчийн (Дээд) 29215 тоот тогтоол.

21. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хороо (CEDAW). 2022. Уугуул эмэгтэйчүүд болон охидын эрхийн тухай №39 (2022) Ерөнхий зөвлөмж. CEDAW/C/GC/39, 11 дэх догол мөр. Цахим хаяг: <https://www.ohchr.org/en/documents/general-comments-and-recommendations/general-recommendation-no39-2022-rights-indigenous>.

22. Аграрийн шинэчлэлийн үндэсний албаны тухай хууль.

23. Семпличи, Ж., болон М. Нори. 2020. Жонатан Хуус, Клэр Огали, Лидиа Слободян, Гуёо Роба, Разингрим Уэдраого нарын "Хил хязгаарыг давах нь: Хил дамнасан бэлчээрийн мал аж ахуйн эрх зүй, бодлогын зохицуулалт" бүтээлийн шүүмж. Pastoralism: Research, Policy and Practice 10(11). doi:10.1186/s13570-020-00168-z.

24. Майкл, С. болон бусад. 2018. Танзани улсын мал аж ахуйн мастер төлөвлөгөө. Олон улсын мал аж ахуйн судалгааны институт, Найроби. Цахим хаяг: <https://faolex.fao.org/docs/pdf/tan185023.pdf>.

25. Эрх, нөөцийн санаачилга. 2025. Амь бөх чанар ба Эсэргүүцэл: Уугуул, афро-залгамжлагч болон орон нутгийн эмэгтэйчүүдийн ойн нөөц эзэмших, ашиглах хуульчилсан эрх. Эрх, нөөцийн санаачилга, Вашингтон хот, 8. doi:10.53892/QST26441.

БАЛБА УЛС



Татварын дарамтын эсрэг отрын малчдын тэмцэл, Балба улс

Дил Раж Ханал¹, Пабиханг Рай², Анила Онта³ нар

Балба улсын бэлчээрийн мал аж ахуй нь босоо чиглэлийн отор нүүдэл хийдэг буюу зуны улиралд өндөр уулын бүс рүү, өвлийн улиралд нам дор газрын сэрүүн болон дулаан бүсийн бэлчээр рүү гэсэн чиглэл бүхий нүүдэл хөдөлгөөн хийдэг. Гималайн бүс нутагт түгээмэл ажиглагддаг энэхүү уламжлалт практик нь уулын экосистемийг хадгалах, орон нутгийн амьжиргаа, нийгэм-соёлын өвийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Отрын мал аж ахуйн тогтолцоо нь газар зүйн өндөрлөгийн өвөрмөц онцлогт дасан зохицсон улирлын чанартай нүүдлийн загвар бөгөөд голчлон сарлаг, чаури (сарлаг, үхрийн эрлийз хайнаг), хонь, уулын ямаа зэрэг олон төрлийн мал сүргийг хамардаг. Уг тогтолцоо нь гэр бүлийн, хамтын болон нийтийн эзэмшлийн бэлчээр ашиглалтын олон шатлалт бүтэц, зохицуулалтад суурилдаг. Малчдын нүүдэл эхлэх хугацаа, цаглавар нь эрт дээр үеэс өвөг дээдсээс уламжлагдан ирсэн соёл, шашны хэм хэмжээтэй гүнзгий холбогддог.

Уламжлалт институтийг төрийн захиргааны байгууллага болгон өөрчилсөн нь

Уламжлалт ёсоор отрын малчид тогтсон замнал, бэлчээр нутгийн хүрээнд улирлын чанартайгаар, тодорхой зан заншлын дагуу бэлчээр ашиглах эрх эдэлдэг байв. Тэд XV зуунаас хойш нүүдлийн мал аж ахуйн арвин мэдлэг, соёлын хэм хэмжээг өвлөн иржээ. Балба улс нэгдэхээс өмнө тосгоны уламжлалт удирдлагын "Мухия" системээр отрын мал аж ахуйг зохицуулдаг байв. Гэвч XVIII зуунд улс орноо нэгтгэсний дараа уг системийг татвар хураах, захиргааны албан ёсны механизм болгон өөрчилсөн нь өнөөгийн малчдад асар том сорилт болоод байна.



Малчин эмэгтэй Таплежунгийн бэлчээрт чаури (хайнаг) сааж байна.
Гэрэл зургийг: Дил Раж Ханал

1. Өмгөөлөгч, Байгалийн нөөц болон Дундын өмчийн эрх зүй
2. Ерөнхий нарийн бичгийн дарга, Балбын Сарлаг, Чаури малчдын холбоо
3. Өмгөөлөгч, Хүний эрхийн хууль (Байгалийн нөөцийн менежментийн хууль тогтоомж дахь Эмэгтэйчүүдийн эрх)

Бэлчээр, бэлчээр нутаг ашигласны хамжлагын татвар

Балба улс нэгдсэний дараа орон нутаг, бүс нутаг, төрийн уламжлалт удирдлагууд (Мухия, Жаминдар, Талукдар, Жагирдар зэрэг албан тушаалтнууд), буддын хийдүүдийг (Гумба) төрийн албан ёсны институтэд тооцох болжээ. Үүнийг дагаад эдгээр субъектүүд отрын малчдад сар, жилээр тогтмол татвар ногдуулах болсон бөгөөд хэмжээг нь ихэвчлэн албан бусаар тогтоодог байв. Малчид бэлчээр ашигласны төлөөх татвараа малын бүтээгдэхүүн, эд материал эсвэл биеийн хөдөлмөрөөр төлдөг байжээ. Тэд энэхүү тулгасан хүнд татварыг эсэргүүцэвч газар өмчлөх эрхгүй, бэлчээр болон нүүдлийн орон зай нь феодалын хатуу хяналтад байсан тул аргагүйн эрхэнд төлөхөөс өөр сонголтгүй байв. Түүнчлэн малчид тухайн үед улс төрийн хувьд бүрэн гадуурхагдсан байлаа.

Балбад Хувийн ойн санг нийгэмчлэх (1957), Биртаг устгах (1959), Газрыг (1964), Бэлчээрийг үндэсний өмч болгох (1974) хуулиудаар феодалын тогтолцоог халснаар бэлчээрийн малчид уламжлалт засаглалаараа дамжуулан бэлчээрээ ашиглах болжээ. Гэвч ХХ зууны төгсгөлд шинээр байгуулагдсан төрийн агентлагууд “зөвшөөрлийн тогтолцоо” нэрээр отрын малчдад асар өндөр татвар, хураамж тулгаж эхэлсэн байна.



Балба улсын Үндсэн хууль болон тус улсын соёрхон баталсан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) 169-р конвенцоор: өөрсдөд нь шууд нөлөөлөх хууль тогтоомжийг боловсруулахдаа холбогдох олон нийт, тэр дундаа малчидтай заавал зөвлөлдөхийг үүрэг болгосон. Гэвч бодит байдал дээр малчдын бэлчээр нутагтай холбоотой хууль тогтоомжийг батлахдаа тэдэнтэй хэзээ ч зөвлөлдөж байгаагүй бөгөөд бэлчээрийн татварыг ямар нэг хэлэлцүүлэггүйгээр, дур мэдэн ногдуулсаар иржээ.

Балба улсын Баглунг дүүрэг дэх бэлчээрийн зориулалтаар ашигладаг нутаг. Гэрэл зургийг: Мукеш Похрел

Төрийн байгууллагуудаас ногдуулж буй татвар, хураамж

Төрийн институтүүд отрын малчдад олон шатлалт татвар, хураамж ногдуулж байгаа нь тэдний нийгэм-эдийн засагт хүнд дарамт болж байна. Малын төрөл, хугацаанаас хамаарсан нэгдсэн стандарт байхгүйгээс төрийн агентлагууд дур зоргоороо хураамж авсаар байна. Тухайлбал, сард сарлаг, чаури тутамд 200–500 балба рупи (1.50–3.50 ам.доллар), хонь, уулын ямаа тутамд 200 хүртэлх рупи (1.50 ам.доллар) авдаг нь малчдын амьжиргаанд тэсвэрлэшгүй ачаалал үүсгэж байна.

Үндэсний парк, тусгай хамгаалалттай газар нутаг, дундын бүсэд нэвтрэх зөвшөөрлийн хураамж

Малчид улсын тусгай хамгаалалттай газар нутаг байгуулагдахаас ч өмнө өвөг дээдсийн үеэс бэлчээрийн мал аж ахуй эрхэлж, хашаа саравчаа барьж ирсэн түүхтэй. Балбын Гималайн бүсийн үндэсний паркууд болон тэдгээр орчмын бүсэд олон зуун малчны өвөлжөө, хот айл байрладаг. 1979 оны "Уулын үндэсний паркийн дүрэм"-ээр малчид эдгээр бүсэд мал бэлчээх, хашаа барих хууль ёсны эрхтэй болсон ч паркийн захиргаад хураамжийн хэмжээг харилцан адилгүй тогтоож, ялгавартай хурааж байна. Уг тэгш бус байдлаас үүдэн малчид төрөөс ижил хандлага шаардан, бэлчээр, хашааны хураамжийг цуцлах буюу бууруулахыг шаардсаар иржээ.

Тусгай хамгаалалттай газар нутаг байгуулагдсанаар малчдын уламжлалт бэлчээрлэх эрх зөрчигдсөн тул тэд паркийн захиргаанд санамж бичиг хүргүүлж, эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлэн, төрийн байгууллагуудтай хэлэлцээ хийж ирсэн. Үүний үр дүнд зарим паркийн захиргаа малчдыг хураамжаас бүрэн чөлөөлөх зэргээр уламжлалт эрхээ хэсэгчлэн сэргээж чадсан байна. Гэвч зарим бүсэд уламжлалт эрхийг үгүйсгэсэн хэвээр байгаа тул өвөг дээдсийн бэлчээрлэх эрхийг баталгаажуулахын тулд малчдын уламжлалт институтүүд нэгдсэн зохион байгуулалтад орох зайлшгүй шаардлага тулгарч байна.

Байгаль хамгааллын бүс дэх бэлчээрийн хураамж

Байгаль хамгааллын бүсэд менежментийн журмаар холбогдох зөвлөлүүд үйл ажиллагааны төлөвлөгөөнийхөө хүрээнд малчдаас бэлчээрийн хураамж авах эрхтэй. Гэвч эдгээр зөвлөлүүд малчдад асар өндөр хураамж ногдуулж байгаа нь тэдний амьжиргаанд том санхүүгийн дарамт болж байна. Үүнээс үүдэн малчид уг шударга бус зохицуулалтыг эсэргүүцэх болжээ.

Хамтын ойн санд нэвтрэх бэлчээрийн хураамж

Отрын малчид дундын ойн тогтолцоо бүрэлдэхээс ч өмнө тухайн ойн санг уламжлалт байдлаар ашиглаж ирсэн түүхтэй. Гэвч Олон нийтийн дундын ойн хэрэглэгчдийн бүлгүүд (ОНДОХБ) малчдад асар өндөр хураамж ногдуулж байгаа нь тэдний амьжиргаанд хүнд сорилт болж байна. Малчид уламжлалт ашиглагчийн хувьд ОНДОХБ-уудад бэлгэдлийн чанартай төлбөр төлөхийг зөвшөөрдөг бөгөөд үүнийг ил тод, олон нийтийн оролцоотой шийдвэр гаргах үйл явцаар тогтоох ёстой гэсэн байр суурьтай байдаг.

Таглежунг дүүрэг дэх сарлаг болон чаури (хайнаг)-ийн бэлчээр нутаг. Гэрэл зургийг: Сураж Ожха





Орон нутгийн захиргаанаас ногдуулж буй татвар

2017 оны "Орон нутгийн захиргааны үйл ажиллагааны тухай хууль"-иар нутгийн захиргаанд отрын малчдаас бэлчээрийн татвар авах эрх олгоогүй. Хэдий тийм ч нүүдлийн орон зай дагуух олон засаг захиргаа малчдад "мал аж ахуйн бизнес" нэрийн дор татвар ногдуулсаар байна. Малчид эдгээр хууль бус татвар төлөхөөс татгалзсанаар талуудын хооронд зөрчил мөргөлдөөн даамжрах болов. Түүнчлэн малчдын хүчтэй эсэргүүцлийн дүнд зарим орон нутгийн захиргаа татвараа цуцалсан жишээ ч бий.

“Бид ард түмнээс сонгогдсон учраас тэднийхээ дуу хоолойг сонсож, шаардлага хэрэгцээг нь шийдвэрлэх ёстой. Манай орон нутгийн захиргааны нутаг дэвсгэрт асар олон малчид амьдардаг бөгөөд малын хашаа саравч, хот айлууд олноор байдаг. Өмнө нь тэднээс малын татвар авдаг байсан бол одоо бид энэхүү татварыг авахаа больсон. Бусад орон нутгийн захиргаа ч ийм татвар ногдуулах нь зохимжгүй юм.”

— Нима Лама, Горкха аймгийн Цум Нубри хөдөөгийн орон нутгийн захиргаа

Улс төрийн нам, албан бус бүлэглэлүүдэд өгөх хандив, шахалт

Балбын Засгийн газар болон Маоистуудын хооронд өрнөсөн арван жилийн иргэний дайны (1996–2006) үеэр отрын малчид асар их хэмжээний мөнгөн хандивыг албадлагаар төлдөг байв. Өнөөдөр ч сонгуулийн үеэр болон бусад цаг үед малчдыг улс төрийн нам, албан бус бүлэглэлүүдэд бэлэн мөнгөний хандив өгөхийг шахдаг бөгөөд малчид энэхүү хууль бус практикийг тууштай эсэргүүцсээр иржээ.



Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ

Балбын отрын малчид уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэх эрмэлзэлтэй байгаа ч тэгш бус, олон давхар татварын тогтолцооны улмаас мал аж ахуйн салбар хумигдахад хүрч байна. Улс төрийн гадуурхал, нэгдсэн зохион байгуулалтгүй байдал нь уг сорилтыг улам даамжруулж байна. Цаашдын гарц нь хамтын, зохион байгуулалттай бодлогын нөлөөллийн аян өрнүүлэх явдал юм. Уг нөлөөллийн ажил нь татвар ногдуулж буй агентлагуудад чиглэх бөгөөд тэднийг төрийн байгууллага, орон нутгийн захиргаа, Олон нийтийн дундын ойн бүлгүүд (ОНДОХБ) болон малчидтай хамтран ажиллахыг шаардахад чиглэх ёстой. Үүний үр дүнд бэлчээр ашиглалтын нэгдсэн, уялдуулсан татварын тогтолцоог боловсруулах боломж бүрдэнэ.

МОНГОЛ УЛС



Уул уурхайд шахагдан бэлчээрээ алдсан нь: Малчин эмэгтэйн газрын эрхийн төлөөх тэмцэл, Монгол улс

Намсрайн Баярсайхан ("Хил хязгааргүй алхам" ТББ, Монгол), Айраг нутгийн хамгаалагчид (Монгол), Ариэл Ахэрн (Оксфордын их сургууль), П (нэрээ нууцалсан) нар

П-ийн¹ гэр бүл Монголын зүүн өмнөд бүс, Дорноговь аймгийн нутагт уламжлалт монгол гэрт амьдардаг. Түүний оршин суудаг сум (2025 оны байдлаар) 306 малчин өрхтэй бөгөөд говь цөлийн хуурай уур амьсгалтай. Эндхийн малчид олон зууны турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн бөгөөд мал сүрэг нь задгай бэлчээрт чөлөөтэй бэлчдэг. Тэд цаг агаар, бэлчээрийн нөхцөлөөс хамаарч нүүдэл хөдөлгөөнөө зохицуулдаг бөгөөд ган, зуд зэрэг байгалийн гамшгийн үед алсын отор нүүдэл хийдэг.

Монгол орны малчдын нүүдэл шилжилт нь тогтсон зурвас нутгаар бус, харин нутгийн засаг захиргаа болон бусад малчидтай зөвшилцөх, харилцан туслалцах уламжлалт хэм хэмжээгээр зохицуулагддаг. Энэ уламжлалт тогтолцоо нь хот сууринаас бусад Монгол улсын хөдөө орон нутгийг бүхэлд нь хамардаг. [Газрын тухай хуулийн](#) малчид өвөлжөө, хаваржааны газрыг 15–60 жилийн хугацаагаар эзэмших гэрчилгээ авах бөгөөд хугацааг нэг удаа 40 хүртэл жилээр сунгах боломжтой. П-ийн гэр бүлийн эзэмшлийн гэрчилгээ 2033 он хүртэл хүчинтэй. Гэвч нүүдлийн мал аж ахуйд бодитоор шаардлагатай газар нутаг хэдэн зуун километр үргэлжлэх бөгөөд энэ нь гэрчилгээжсэн талбайн хэмжээнээс хавьгүй их. П эцэг эхийнхээ барьж байгуулсан хоёр худаг ашигладаг ч эдгээр нь хуулиараа нийтийн өмчид тооцогддог.

Монгол улсад 2000-аад оны дунд үеэс уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, улсын төсвийн орлогын гол эх үүсвэр болсон. Төрөөс аж үйлдвэр, арилжааны чиглэл хөгжүүлэхээр газар албадан чөлөөлөх болсон нь малчдын уламжлалт нүүдлийн орон зайг хумьж байна. Тухайлбал, 2010 оноос хойш Засгийн газар П-ийн оршин суудаг сумын нутаг дэвсгэрт уул уурхайн тусгай зөвшөөрлүүдийг олгож эхэлсэн бөгөөд [2024 оны байдлаар идэвхтэй байсан](#) 39 зөвшөөрөл бүгд уламжлалт бэлчээр нутагт үйл ажиллагааг явуулж байв. Өдгөө П-ийн өвөлжөө, хаваржааны ойролцоо "МСТТ", "Дунфанлума", "Мөнх болор хүрээ", "Алтраг ахас", "Дугуй уул", "Алтанбарга", "Эклешиа" тэргүүтэй найман

1. Оролцогчдын хувийн нууцыг хамгаалах үүднээс энэхүү кэйс судалгааны хүрээнд хувь хүн болон гэр бүлийн нэрсийг нууцалсан бөгөөд хүн ам зүйн үзүүлэлт, малын тоо толгой зэрэг бусад өгөгдөл бодит баримт хэвээр болно. П бол насан туршдаа нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй Бор Өвгөн овгийн малчин эмэгтэй юм. Түүний гэр бүл урьд нь таван хошуу мал малладаг, 700 гаруй толгой малтай байсан ч өдгөө 350 орчим хонь, ямаатай үлджээ. Тэдний амьжиргаа уламжлалт дөрвөн улирлын нүүдлийн хэв маягт суурилдаг.

компани жоншны ил уурхайн олборлолт явуулж байна. Ил аргаар олборлох, ашигт малтмал тээвэрлэх, хаягдал ус зайлуулах зэрэг уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн усны эх үүсвэрийг асар хурдтай шавхдаг.

Гүний усыг задгай бэлчээр рүү ийнхүү шахан урсгаснаар П-ийн хаваржаандаа очих нүүдлийн орон зай хаагдахад хүржээ (Зураг 1).

Уул уурхайн нөлөөгөөр бэлчээр ашиглах эрх зөрчигдсөн нь

Уг кэйс нь амьдрал дээрх газар эзэмших эрхийн баталгаагүй байдлыг тодхон харуулж байна. Малчид өвөлжөө, хаваржааны газраа эзэмших албан ёсны гэрчилгээтэй байлаа ч төрөөс уул уурхайн зорилгоор бэлчээрийг албадан чөлөөлөхөд малчид нутгаасаа шахагдах эрсдэлд орж, тэдний хууль ёсны эрх үнэгүүддэг. Хэдийгээр хөдөө орон нутгийн газар нутаг төрийн өмчид тооцогддог ч бодит байдал дээр малчдын хамтран ашигладаг дундын баялаг билээ. Газарт онцгой эрх тогтоож хувьчлах нь монголчуудын уламжлалт нүүдлийн мал аж ахуйн зан заншил, газар ашиглалтын суурь үзэл баримтлалд харшилдаг. Малчдын албан ёсны эрх зөвхөн өвөлжөө, хаваржааны тогтсон жижиг талбайг л хамардаг тул холын нүүдэл, отор хөдөлгөөнд тулгуурласан газар ашиглалтын бодит хэрэгцээг бүрэн тусгаж чадахгүй байна.



Гэрэл зураг 1: Ойролцоох уул уурхайн найман компанийн хийсэн тэсэлгээний улмаас малчин П-ийн өвөлжөөний саравч нурж, мал оруулах боломжгүй болжээ. Гэрэл зургийг: П (нэрээ нууцалсан)

Малчдын бэлчээр ашиглах эрх нь уламжлалт хэв маяг, хамтын нүүдэл хөдөлгөөнд гүн шингэсэн байдаг. Албан ёсны гэрчилгээгүй ч өвөг дээдсээс уламжлагдсан бэлчээр, усны нөөцөө алдах нь гэрчилгээтэй газраа алдахаас дутахгүй ноцтой хохирол дагуулдаг. Тиймээс газрын засаглалын тогтолцоо малчдын бодит нөхцөлд нийцэж, тэдний шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрөх замаар уламжлалт болон нүүдлийн эзэмшлийг хуулиар баталгаажуулах шаардлагатай.

Газрыг уул уурхай, дэд бүтцийн зориулалтаар албадан чөлөөлөхөд бэлчээрийн бүрэн бүтэн байдал алдагдаж, малчид ус, бэлчээрээсээ таслагдан амьжиргааны суурь нь ганхдаг. Түүнчлэн малчдад уламжлалт бэлчээр нутагт нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохоос урьдчилан сэргийлэх эрх зүйн хөшүүрэг байхгүй бөгөөд зөвшөөрөл олгох, газрын ангилал өөрчлөх шийдвэрийн талаар урьдчилж мэдээлэл авч чадахгүй байх явдал түгээмэл байна.

П-ийн кэйсээс үзэхэд уул уурхайн компаниуд хэд хэдэн тэсэлгээг нэгэн зэрэг хийж газрыг хүчтэй доргиодог. Үүнээс үүдэн хөрс урагдаж, нягтрахын зэрэгцээ бэлчээр тоосонд дарагдаж, ургамал дахин ургах боломжгүй болдог. Гэвч уурхайн зүгээс ямар нэг нөхөн сэргээлт хийдэггүй. Түүнчлэн уурхайн орчимд хашаа хайс, анхааруулах тэмдэг, хязгаарлалтын бүс байхгүй бөгөөд хатуу хучилтгүй замаар зорчих хүнд даацын тээврийн хөдөлгөөн байгалийн ландшафтыг улам бүр доройтуулдаг аж. Үүний уршгаар биологийн олон янз байдал алдагдаж, зэрлэг амьтад дайжин, мал сүрэг хамгаалалтгүй орхисон ил уурхайн нүх рүү унах явдал байнга гарч байна (Зураг 2, 3).

2. П эцэг эхээсээ нэг өвөлжөө, нэг хаваржаа өвлөн авсан. Монголд өвлийн эрс тэс нөхцөл байдлын улмаас өвөлжөө нэн чухал байдаг.



Ил уурхайн олборлолтын явцад гүний ус малталтын ам руу шүүрдэг бөгөөд компаниуд уг усыг шахан гаргаж, задгай бэлчээр рүү урсгадаг. Үүнээс шалтгаалан говийн бүсийн ундны усны үндсэн эх үүсвэр болох гүний усны түвшин эрс доошилж байгаа бөгөөд энэхүү хямрал уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хур тунадас багасах үзэгдэлтэй хавсарч, байдал улам хүндэрч байна.

Үүнээс болж, П-ийн гэр бүл болон мал сүргийн ундны усны гол эх үүсвэр болсон худгийн түвшин эрс доошилжээ. Хаваржааны худаг нь уул уурхайн хөрсний овоолго, хаягдалд дарагдсаны улмаас П ундны усаа 25 километрийн алсаас зөөхөөс өөр сонголтгүй болсон байна.

Амьжиргааны доройтол ба жендэрийн үр нөлөө

Өнгөрсөн арван жилийн хугацаанд П-ийн өрх мал сүргээ гурван ч удаа бүрмөсөн сольсон (зарж, шинээр авсан). Уул уурхайн тоосжилт ихтэй бэлчээрээс шалтгаалан малын уушги, дотор эрхтэн хатуурах, өсөлт саатах, ойрхон өвчлөх, хээл хаях, сүүний гарц эрс багасах зэрэг эмгэг түгээмэл илрэх болжээ. Энэ гэр бүл өдгөө төл мал худалдан авч, өсгөн борлуулах замаар амьжиргаагаа залгуулж байгаа ч малын өвчлөл буурахгүй байгаа тул мал эмнэлгийн үйлчилгээнд асар их зардал гаргадаг. Түүнчлэн тухайн бүс нутагт үхэр, морь маллах боломж бүрмөсөн хаагджээ.

Уурхайн олборлолт эхлэхээс өмнө малын ашиг шим, өрхийн орлого өндөр, өвчлөлийн түвшин бага байснаас гадна урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авдаг байв. Тэгвэл өдгөө өрхийн орлогын 15 хувийг зөвхөн мал эмнэлгийн үйлчилгээ, эм тарианд зарцуулж байна. Үүнээс үүдэн санхүүгийн хохирол тасралтгүй үргэлжилж, өрхийн хүнсний аюулгүй байдал эрс мууджээ.

Бас өрхийн хөдөлмөрийн хуваарилалт, амьдралын хэв маяг өөрчлөгджээ. Урьд нь П мал маллагаа, гэр ахуйн ажил, цагаан идээ боловсруулахад анхаарч, нөхөр нь хурдан морь уяж цагаан сар, наадамд оролцон, сумын төв рүү албан ажил хөөцөлддөг байв. Харин өдгөө түүний нөхөр "Тэр амьдрал одоо нэгэнт үгүй болсон. Бид уул уурхайн эсрэг тэмцдэг малчид болж хувирлаа" хэмээн өгүүлж байна. П одоо өөрийн гэр бүл, нутгийн иргэд болон хойч үеийнхээ төлөө уул уурхайн компаниуд, төрийн албан тушаалтнуудтай нүүр тулан тэмцдэг бодлогын нөлөөлөгч болжээ.

Нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн хувьд малын эрүүл мэнд нь газар ашиглалтын баталгаат байдалтай салшгүй холбоотой. Мал сүргээ дараалан алдах нь зөвхөн эдийн засгийн хохирол амсаж буй хэрэг биш, давхар бэлчээрлэх эрхээ бүрмөсөн булаалгаж буй явдал юм. Бэлчээр экологийн хувьд ашиглагдах боломжгүй болж, ус, тэжээлийн систем доройтсоноор малчид

Зураг 2 (зүүн) болон 3 (баруун): Жонш олборлох явцад гүний усыг шавхан, бэлчээрт задгай урсгаж буй нь. Ингэснээр говийн усны түвшинг доошлуулаад зогсохгүй, мал сүрэг хордож өвчлөх гол шалтгаан болж байна. Зургийг авсан: П (нэрээ нууцалсан)

уламжлалт нутагтаа бэлчээр ашиглах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон. Байгаль орчны энэ доройтол нь тус гэр бүл амьдралаа урт хугацаанд төлөвлөх боломжгүй болгож, тэднийг зөвхөн өдөр хоногийг өнгөрөөх, аргацаасан амьдралын мухар тойрогт хашжээ. Нүүлгэн шилжүүлэх эсвэл нөхөн олговор олгох асуудал тодорхойгүй байгаа нь П-ийн гэр бүлийн гишүүдийн итгэлийг алдуулж, ирээдүйгээ бүрхэг харахад хүргэж байна.

Нүүдэл тасалдах, соёлын өв үрэгдэх, нийгмийн зөрчил үүсэх нь

П-ийн хувьд өвөг дээдсээс уламжлагдан ирсэн тогтвортой нүүдэлчин амьдрал нь өдгөө айдас, тодорхойгүй байдлаар солигджээ. Тэднийх үе удмаараа шүтэн тахиж ирсэн овоо хайрхныг нь тал талаас нь ухан малтсанаас өдгөө зөвхөн нутгийн олны босгосон овоо л үлдэж хоцорсон байна (Зураг 4). Энэ сүйтгэл нь малчдад сэтгэл зүйн гүн шарх үлдээж, тэдний шүтлэг бишрэлийг үгүй хийсэн. П-гийн гэр бүл нутгаасаа 120 километрийн алсад нүүх гэсэн оролдлого бүтэлгүйтсэн бөгөөд мал сүрэг нь дассан өвөлжөө, ус руугаа буцаж гүйн, адуу, үхэр шинэ нутагт тогтсонгүй. Ийнхүү тэд үе удмаараа амьдарч ирсэн Цагаан дэлийн агуй, тахилгат уулаа орхин явж зүрхэлсэнгүй.

Монгол Улсын **Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн** дагуу компаниуд төслийн үнэлгээгээ багийн хурлаар танилцуулдаг. Нутгийн иргэд төслийг цуцлахыг шаардсан ч компаниуд тухайн хуралд оролцогчдоор дэмжүүлэн уул уурхайн төслүүдээ батлуулж авчээ. П эдгээр хурлын товыг мэдэгддэггүй байснаас гадна хожуу түүнийг багийн албан ёсны цахим группээс хасаж, мэдээлэл авах эрхийг нь бүрмөсөн хаасныг мэдэж авчээ. П ялгаварлан гадуурхалт, дарамт шахалтад өртөж, компанийн төлөөлөгч түүнийг нутгийн иргэдийн өмнө илтэд гүтгэжээ. Үүний дараа тухайн ажилтныг ажлаас нь халснаас өөрөөр компанид хуулийн хариуцлага хүлээлгээгүй байна.

П өөрт тохиолдсон нөхцөл байдлыг эргэцүүлэн: "Уул уурхай миний мөрөөдөл, гэр орон, өмч хөрөнгө, гэр бүлийн минь ирээдүйг сүйрүүлсэн. Миний тэмцэлд одоо зогсох эрх байхгүй" хэмээн өгүүлэв. Тэрээр бэлчээр нутаг, амьжиргааны эх үүсвэрээ алдсан ч албан ёсны гомдол гаргах, бодлогын нөлөөлөл өрнүүлэх замаар уул уурхайн хууль бус үйлдлийн эсрэг тууштай тэмцсээр байна.

Гэрэл зураг 4: Малчин П нөхрийн хамт 2025 оны 7-р сард өөрсдийн тахилгат уулынхаа овоон дээр. Тус тахилгат уулыг жоншны олборлолтын улмаас тал талаас нь ухаж малтсан. Гэрэл зургийг: П (нэрээ нууцалсан)



Манлайлал ба нөлөөллийн ажил

Өнгөрсөн цаг хугацаанд П байгаль орчин, хүний эрхийн идэвхтэй хамгаалагч болжээ. Түүний тууштай тэмцлийн үр дүнд Цагаан дэлийн агуйг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын (2019) болон Засгийн газрын (2025) тогтоолууд тус тус батлагдсан байна. Тэрээр 2021 онд Мадрид хотноо болсон Олон улсын эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдын чуулганд оролцож, индэр дээрээс дуу хоолойгоо хүргэсэн юм. П байгаль орчин, хүний эрхийн хууль тогтоомжийн мэдлэгээ дээшлүүлэн малчин-паралегал (туслах хуульч) болж бэлтгэгдсэн бөгөөд "Айраг нутгийн эзэд" ТББ-ыг хамтран байгуулжээ.

Монгол Улсад уул уурхайн төслүүдийн нийгэм, соёлын нөлөөллийн үнэлгээний эрх зүйн зохицуулалт байхгүйгээс малчид соёлын далд хохиролдоо ямар нэгэн нөхөн олговор авч чаддаггүй. Газар албадан чөлөөлөх үйл ажиллагаа нь малчдын амьжиргааг хамгаалах суурь механизм бүрдүүлэхгүй хэрэгжсээр байна.

НИГЕР УЛС



Бажада дахь бэлчээрийн бүсэд бэлчээр ашиглах олон нийтийн менежмент, уламжлалт механизмууд, Нигери улс, Матанкара орон нутгийн захиргаа

Доктор Рабиу Амаду Шарифи, Доктор Абдулкадэр Афанэ нар

Нигер улсын Доссо мужийн Матанкари хөдөөгийн захиргаанд орших 1,598 га талбай бүхий Бажада бэлчээр нь хуулиар хамгаалагдсан дундын өмч юм (2018 оны №009/CR/MAT/DU тоот тушаал). Фулани, Туарег иргэд голлон нутагладаг тус газар нь хагас хуурай уур амьсгалтай, бэлчээрийн нөөцийн хэлбэлзэл ихтэйгээрээ онцлогтой. Өдгөө газрын хомсдол, газар тариалангийн тэлэлт, дэд бүтцийн хөгжлөөс болж малчин өрхүүдийн оршин тогтнох үндэс болсон нүүдлийн орон зай хумигдаж байна. Хэдийгээр Хөдөө орон нутгийн тухай хууль, 2010 оны 29 дүгээр тогтоолоор малчдын нүүдэллэх, хамтран ашиглах эрхийг баталгаажуулсан ч амьдрал дээр бэлчээр, усны хүртээмж уламжлалт дүрэм журмаар зохицуулагддаг. Чухам энэхүү уламжлалт зохицуулалт нь малчид, тариачдын хооронд зөрчил мөргөлдөөн үүсэхээс сэргийлдэг билээ.

“Хэрэв эцэг эхээс уламжлагдан ирсэн дүрэм журам байгаагүйсэн бол бидэнд хамтран ашиглах бэлчээр нутаг үлдэхгүй байх байсан.”

— Амаду Исса, Фулани бэлчээрийн малчин (2025)

Бэлчээр ашиглах уламжлалт механизм

Матанкари дахь уламжлалт зохицуулалтыг нүүдэлчдийн хувьд “бүлгийн ахлагч”, суурин иргэдийн хувьд “кантоны (засаг захиргааны нэгж) ахлагч” нар хариуцан хянадаг бөгөөд тэдэнд тосгоны удирдлага, уламжлалт зөвлөлүүд дэмжлэг үзүүлдэг. Эдгээр уламжлалт удирдагчид нь төрийн албан ёсны төлөөлөлд тооцогддог. Дээр дурдсан гол уламжлалт зохицуулалтууд бол:



Уламжлалт нутаг дэвсгэр: Бүх бэлчээрийн малчид 1997 оны №97-007/MAG/EL тогтоол болон өөрсдийн уламжлалаар баталгаажсан бэлчээр нутгаа ашиглах давуу эрхтэй байдаг бөгөөд тухайн олон нийтийн гишүүдэд бэлчээр ашиглалт үнэ төлбөргүй байдаг.



Отор нүүдлийн зам: Тусгайлан тэмдэглэж заагласан нүүдлийн орон зай нь малчдад улирлын чанартай ус, бэлчээр ашиглах боломжийг бүрдүүлдэг ба хэрэгжилтэд орон нутгийн “Отор нүүдлийн зөвлөлүүд” хяналт тавьдаг.



Сэлгэж ашиглах журам: Бэлчээр талхлагдахаас сэргийлж, малчид өөрсдийн дотоод дүрмийн дагуу бэлчээрийг сэлгэн ашигладаг. Үүссэн аливаа зөрчил, маргааныг нутгийн настан буурлууд зуучлан зохицуулдаг.



Усны зохицуулалт: Усны эх үүсвэрийг ашиглах эрх нь малын төрөл зүйл, уламжлалт нутаг дэвсгэртэйгээ хэр ойр байхаас хамаарна. Усны нөөцийг мөн уламжлалт механизмаар зохицуулдаг.

Хүн, малын нүүдэл хөдөлгөөнийг бэлчээр, усны нөөцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн нүүдлийн хуанлигаар зохицуулж байна.

Малчин эмэгтэйчүүдийн эрх, үүрэг

Бэлчээр болон мал аж ахуйн нөөц баялгийн хүртээмж нь эмзэг бүлгүүд, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд тулгамдсан асуудал хэвээр байна. Үндэсний хууль тогтоомжоор жендэрийн эрх тэгш байдлыг баталгаажуулсан ч малчин иргэдийн дундах эцгийн эрхт ёс эрчүүдийг өмчийн гол эзэмшигч болгодог. Гэтэл малчин эмэгтэйчүүд мал аж ахуйн тогтолцоонд амин чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Тэд бог мал маллагаа, уламжлалт аргаар малын эрүүл мэнд хамгаалах, ус бэлтгэх, хуурайшилтын улиралд малын тэжээл нөөцлөх, отор нүүдлийн бэлтгэл хангах зэрэг ажлыг гардан гүйцэтгэдэг. Энэ утгаараа малчин эмэгтэйчүүдийн гэр бүлдээ оруулж буй хувь нэмэр нь тухайн өрхийн тогтвортой амьжиргаанд шийдвэрлэх ач холбогдолтой байдаг.

"Хэдийгээр бид бэлчээр нутгийн асуудлаар шийдвэр гаргах эрхгүй ч отор нүүдэл зохион байгуулах, бог мал маллах, малын эрүүл мэндэд анхаарах, малын дайвар бүтээгдэхүүн боловсруулж өрхийн амьжиргаа дэмжих ажлыг хариуцдаг. Бид байхгүй бол мал сүрэг амьд үлдэхгүй байсан."

— Хаджара Ороджи, бэлчээрийн малчин эмэгтэй (2025)

Тулгамдаж буй сорилтууд:

- **Газрын дарамт ба суурин газрын тэлэлт:** Газар тариалангийн тэлэлт, бэлчээр түрж авах үйл явцаар тод илэрч байна.
- **Эрх зүйн баталгаагүй байдал:** Малчдын нүүдэл шилжилтийг хязгаарлаж, отор нүүдлийн гол замыг хааж байна.

- **Жендэрийн тэгш бус байдал:** Эмэгтэйчүүдийг бэлчээр ашиглах давуу эрх болон шийдвэр гаргах үйл явцаас шахан гадуурхаж байна.
- **Уур амьсгалын өөрчлөлт:** Таамаглашгүй олон ган гачиг тохиолдож, дасан зохицохыг шаардсаар байна.

"Мал сүргээ хэзээ, хаашаа нүүлгэхийг настнууд маань хамгийн сайн мэддэг тул бид тэднийг гүнээ хүндэтгэдэг. Энэ бол мал сүрэг бүрийг хангалттай бэлчээр, усаар хангах цорын ганц арга зам юм."

— Баки Дэли, Мада овгийн ахлагч (2025)




Доктор Рабиу Амаду Шарифи болон Доктор Абдулкадэр Афанэ


"Өнөөдөр бороо орсон ч бэлчээр нутаг маань цаашид оршин тогтнох эсэхийг бид мэдэхгүй байна."


— Иссуфу, отрын малчин (2024)


Олон нийтийн засаглал

Бажада дахь бэлчээрийн засаглал нь хүнд сорилт, бэрхшээлийг үл харгалзан олон нийтийн байгууллага хэр үр дүнтэй байж болохыг харуулж байна. Энэ тогтолцоо нь бэлчээр, усны эх үүсвэрийн уламжлалт дүрэм журамд суурилдаг бөгөөд 2018 оноос хойш орон нутгийн эрх баригчдад шат дараатай хүлээн зөвшөөрөгдөж, албажсан байна.

 **Настан буурлуудын зуучлал:** Зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, үүссэн асуудлыг эвлэрүүлэн зуучлах, хохиролгүй болгох аргаар шийдвэрлэхэд тусалдаг.

 **Улирлын чанартай бэлчээр сэлгэлт:** Бэлчээр талхлагдахаас сэргийлдэг (жил бүр настнууд зөвлөлдөж, шим тэжээлтэй боловч эмзэг нам доор газрын бэлчээр ашиглах товыг тогтоодог).


 **Усны эх үүсвэрийн тэгш зохицуулалт нь** малчдын дунд үүсэх үл ойлголцол, хурцадмал байдлыг бууруулдаг (оргил ачааллын үеэр эрчүүд мод малаа маллах үед эмэгтэйчүүд бог малаа усалдаг).


 **Эмэгтэйчүүдийн оролцоо нь** бэлчээрийн засаглалын тогтвортой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлдэг. Цаг төр тогтворгүй, аюултай үед хамгийн аюулгүй нүүдлийн орон зайг тодорхойлохын тулд эмэгтэйчүүдээс зөвлөгөө авдаг бөгөөд тэдний усны эх үүсвэр, отрын бэлчээрийн талаарх мэдлэгийг нутгийнхан өргөнөөр хүлээн зөвшөөрдөг.




Гэрэл зургийг: Доктор Рабиу Амаду Шарифи болон Доктор Абдулкадэр Афанэ

Эрх зүйн орчин ба орон нутгийн практик хоорондын зөрүү

 Хуулиар малчдын нүүдэл хөдөлгөөнийг хүлээн зөвшөөрдөг ч аюулгүй байдлын эрсдэл, отор нүүдлийн орон зай руу газар тариалан түрж орж буй нь хуулийн бодит хэрэгжилтийг сулруулж байна.

 Бичмэл баримт бичиг нь малчдын бэлчээрийн эрхийг баталгаажуулдаг ч практикт түүнийг хамгаалах асуудал малчдын сонор сэрэмж, нэгдмэл байдлаас хамаарч байна.

 Байгалийн нөөцийг удирдах төрийн зохицуулалт нь уян хатан, шуурхай хариу үйлдэл үзүүлдэг, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн уламжлалт механизмуудтай харьцуулахад үр ашиггүй хэвээр байна.

"Бид эцэг өвгөдийн үлдээсэн дүрэм журмын ачаар амьд үлдэж чадсан. Гэвч бидний охид бидэнтэй ижил эрх эдлэхийн тулд эдгээр журмыг эмэгтэйчүүдийн хэрэгцээ болон уур амьсгалын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх ёстой."

— Жүли Лаяа Самро, залуу малчин (2025)

ТАНЗАНИ УЛС



Нүүдэллэх баталгааг хангах нь: Малчин эмэгтэйчүүдийн инноваци ба газрын засаглал, Танзани улс

Нема Сэки болон Доктор Эммануэль Сулле нар

Танзани улсын малчдын амьдрал газар, ус, бэлчээрийн нөөцийг аюулгүй ашиглах эрхээс шууд хамааралтай бөгөөд отор нүүдэл нь тэдний амьжиргаа, соёлын ондоошил, экологийн тогтвортой байдлыг хангадаг. Бэлчээрийг улирлын чанартай сэлгэн нүүх нь хуурай болон хагас хуурай бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, малын ашиг шимийг тогтвортой хадгалах, газарт түшиглэсэн эдийн засгийг дэмжих ач холбогдолтой¹. Байгалийн баялаг ашиглах, нүүдэл хөдөлгөөн хийх ойлголт нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд бэлчээр ашиглах эрхгүйгээр отор нүүдэл хязгаарлагдаж, бэлчээр хуваагдах, эсвэл бүр хууль бусад тооцогдоход хүрдэг. Энэхүү кэйс судалгаагаар Танзани улсын малчдын газар ашиглалт, нүүдэл шилжилтийг баталгаажуулахад газрын засаглалын шинэчлэл, хамтын ажиллагаа болон эмэгтэйчүүдийн засаглалын инновац хэрхэн нөлөөлж буйг харуулав.

Стратегийн нүүдэл хөдөлгөөн ба экологийн хариуцлага

Бүс нутаг болон дэлхийд нийтийн дундын эзэмшил, нүүдлийн соёлыг хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгдэж байгаа ч Танзани улсын үндэсний бодлого суурин газар ашиглалт, хувийн өмчлөлийг илүүд үзсэн явцуу хүрээнд хязгаарлагдсаар байна². Тухайлбал, 2025–2026 оны санхүүгийн жилд Танзани Улс мал аж ахуйн салбарт 476.7 тэрбум Танзани шиллинг (193 сая ам.доллар) зарцуулахаар төлөвлөсөн ч, үүний дийлэнх хувийг хөгжлийн зардалд хуваарилжээ³. Төсвийн энэ тэлэлтийн дүнд бэлчээрийн талбай хумигдаж, малчдын отор нүүдэл хязгаарлагдах явдал улам нэмэгдсэн.

Уг санхүүжилтээр хэрэгжиж буй малын зах, сүү цуглуулах төвүүд, вакцинжуулалтын аян, уур амьсгалд дасан зохицсон сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг нь угтаа бэлчээр, усны нөөц болон нүүдлийн орон зайд аюулгүй нэвтрэх малчдын эрхтэй шууд холбоотой юм⁴. Отор нүүдлийг хамгаалж,

1. Хомвүүд, Кэтрин. (2008). Африкийн малчин нийгэмлэгүүдийн экологи. Жэймс Карри, Охио их сургуулийн хэвлэл, Афин

2. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ФАО). (2018). Африкийн хуурай бүс нутаг дахь мал аж ахуй: Эрсдэлийг бууруулах, эмзэг байдлыг шийдвэрлэх, тэсвэртэй байдлыг бэхжүүлэх. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Ром.

3. Танзани Нэгдсэн Улс (ТНУ). (2025). Мал аж ахуй, загасны аж ахуйн яамны төсвийн илтгэл. Мал аж ахуй, загасны аж ахуйн яам, Додома.

4. ТНУ. (2025)

дундын эзэмшлийг хамгаалсан газрын засаглалын тогтолцоогүйгээр хийсэн аливаа хөрөнгө оруулалт нь тэгш бус байдлыг даамжруулж, нөөцийн зөрчлийг хурцатган, мал аж ахуйн тогтолцооны урт хугацааны тогтвортой байдлыг үгүй хийх эрсдэл дагуулдаг.

Газар албажуулалт, эрх зүйн орчин, бодит байдал

Танзани улс 2000-аад оноос эхлэн газар эзэмшлийн баталгааг сайжруулж, газар ашиглалттай холбоотой зөрчлийг бууруулах зорилгоор тосгоны газар ашиглалтын төлөвлөлт, системчилсэн бүртгэл зэрэг шинэчлэлийн хэд хэдэн санаачилгыг хэрэгжүүлж ирсэн⁵. Гэвч малчид, анчин, байгалийн баялгийг түүж амьдардаг олон нийтэд эдгээр санаачилгын үр дүн харилцан адилгүй тусаж байна. Газар албажуулах үйл явц нь голдуу хувь хүний нэр дээр гэрчилгээ олгоход чиглэж байгаа нь дундын бэлчээр, малын нүүдлийн орон зай, усны эх үүсвэрийн улирлын чанартай хуваан хэрэглэдэг нүүдлийн амьжиргааны хэв маягтай нийцсэнгүй⁶.

Эрх зүйн хувьд Танзани улсын газрын засаглал нь тэгш байдал, үл ялгаварлах зарчимд суурилдаг. Тухайлбал, 1995 оны Үндэсний газрын бодлого (2023 онд шинэчлэгдсэн), 1999 оны Газрын тухай хууль, Тосгоны газрын тухай хуулиар газар ашиглах уламжлалт эзэмшлийг хүлээн зөвшөөрч, жендэрийн тэгш эрхийг баталгаажуулсан⁷. Гэвч практикт газрыг тосгоны, ерөнхий, тусгай хамгаалалттай гэж ангилсан нь чиг үүргийн давхардал, институтийн тодорхойгүй байдлыг үүсгэжээ. Улмаар зэрлэг амьтад, ойн санг зохицуулдаг салбарын хуулиуд нь малчдын урт хугацааны түүхэн эрхийг үл тоож, бэлчээр ашиглах уламжлалт хэв маягийг устгахад хүргэж байна. Удирдлагын төвлөрөл, хуулийн зохицуулалтын тодорхойгүй байдал нь газар булаах, баялгийн хүртээмж хаах нөхцөлийг бүрдүүлж, улмаар малчдын нүүдэл хөдөлгөөнийг хумьж байна⁸.

Малчин эмэгтэйчүүдийн зөвлөлийн үүсгэн байгуулагч гишүүдийн зураг. Гэрэл зургийг: Малчин эмэгтэйчүүдийн зөвлөл



5. Сулле, Эммануэль. (2017). *Нутгийн иргэд ба хөрөнгө оруулагчид: Танзани улс дахь газрын эрхийн бүтцийн динамик*. Данийн олон улсын судалгааны хүрээлэнгийн ажлын материал (DIIS Working Paper, №2017:10), Копенгаген.

6. Сулле, Эммануэль. (2021). *Танзани улс дахь тосгоны газар ашиглалтын төлөвлөлт болон бэлчээрийн засаглалын үнэлгээ*. Олон улсын мал аж ахуйн судалгааны хүрээлэнгийн (ILRI) үнэлгээний тайлан, Найроби.

7. Танзани Нэгдсэн Улс (ТНУ). (1999а). *Газрын тухай хууль* (1999 оны №4). Танзанийн Засгийн газар, Додома.

8. Танзани Нэгдсэн Улс (ТНУ). (1999б). *Тосгоны газрын тухай хууль* (1999 оны №5). Танзанийн Засгийн газар, Додома.

Малчдын газар ашиглалт нь засаг захиргааны тогтсон хил хязгаарт баригддаггүй буюу олон засаг захиргааны нэгж, зарим тохиолдолд улсын хилийг ч дамнах тохиолдол бий. Газар ашиглалтыг хөдөлгөөнгүй, явцуу тосгоны нэгжээр хязгаарлах нь дундын бэлчээрийг таслан хувааж, малчдын отор нүүдлийг шууд боомилдог. Үүнээс гадна, малчдын ашиг сонирхлыг орхигдуулсан улсын төсвийн хуваарилалт, гадаадын төслөөс хэт хамааралтай байдал нь мал аж ахуйн олон бүс нутгийг төлөвлөлтгүй, хамгаалалтгүй үлдээхэд хүргэжээ. Улмаар, бэлчээрийн газар ерөнхий эсвэл тусгай хамгаалалттай газрын ангилалд орж байгаль хамгаалал эсвэл арилжааны хөрөнгө оруулалтын зориулалтаар бусдад шилжих эрсдэлтэй, эмзэг хэвээр байна⁹.

Хамтын ажиллагаа ба эмэгтэйчүүдийн засаглалын инновац

Байнгын сорилт, бэрхшээлийг үл харгалзан малчид, ялангуяа Танзани улсын хойд бүсийн Маасай иргэд судалгааны байгууллага, төрийн агентлаг, иргэний нийгмийн дэмжлэгтэйгээр газрын хүртээмжийг баталгаажуулах, отор нүүдлийг тогтвортой хадгалах хамтын стратегийг хэрэгжүүлсээр ирсэн. Эдгээр стратегид тосгон хоорондын бэлчээрийн гэрээ, хуурайшилтын улиралд дундын нөөц нутаг, усыг зөвшилцөн зохицуулах, тосгоны хамтарсан газар ашиглалтын төлөвлөлт (ТХГАТ) зэрэг багтдаг. Тав гаруй дүүрэгт нэвтэрсэн энэ арга барил нь малчдад дундын бэлчээр, малын нүүдлийн зурвас, улирлын чанартай нөөц газруудыг тосгоны газрын ангиллаар албан ёсоор хамгаалалтад авах боломж олгожээ¹⁰.

Сүүлийн хорин жилд “Ужамаа хамт олны нөөцийн удирдлагын баг” (УХОНУБ) ТББ нь газар нутгийн залгамж чанар, хамтын өмчлөлийг чухалчилдаг “Ужамаа загвар”-аа улам боловсронгуй хөгжүүлж байна. 2024 он гэхэд тус ТББ нь 3.5 сая гаруй га талбайд иргэдийн оролцоотой газар ашиглалтын төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлж, уламжлалт эзэмших эрхийн гэрчилгээгээр дамжуулан 2 сая гаруй га бэлчээрийг малчдын хамтын өмч хэмээн баталгаажуулсан байна¹¹. Уг санаачилгыг өргөжүүлэн, Китэто дүүрэгт Олон улсын мал аж ахуйн судалгааны хүрээлэн Танзанийн Засгийн газар, орон нутгийн ТББ-уудтай хамтран дөрвөн тосгоны кластерийг хамарсан Тосгоны хамтарсан газар ашиглалтын төлөвлөлтийг хийжээ. Үүний үр дүнд, хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн малчдын холбоодын удирддаг 163,000 гаруй га дундын бэлчээрийг албажуулсны нэг жишээ нь гишүүн тосгонуудаа төлөөлж хамтын гэрчилгээ эзэмшдэг “ОЛЕНГАПА малчдын холбоо” юм¹².



Малчин эмэгтэйчүүдийн зөвлөл зураг авхуулахаар зогсож буй нь, Гэрэл зургийг: Малчин эмэгтэйчүүдийн зөвлөл

Танзани улсын Аруша хотын ойролцоох Нгоронгоро үндэсний паркт малынхаа дэргэд сууж буй Маасай эр. Гэрэл зургийг: Shutterstock

9. Шивжи, Исса Ж. 2006. Ард түмэн яриг: Неолиберализм руу чиглэсэн Танзани улсын замнал. CODESRIA ном хэвлэлийн систем, Дакар.
10. Сулле, Эммануэль. 2021; болон Ужамаа хамт олны баялгийн баг (УХОББ). 2024.
11. УХОББ. 2024.
12. Сулле, Эммануэль. 2021.

Газар эзэмшлийн баталгааг сайжруулахын зэрэгцээ, дээрх санаачилгууд малчин эмэгтэйчүүдийн засаглалын шинэ инновацыг мөн төрүүлж байна. УХОНУБ болон Бэлчээрийн малчин эмэгтэйчүүдийн зөвлөл (БМЭЗ)-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн эмэгтэйчүүдийн эрх, манлайллын хөтөлбөрийн хүрээнд 97 эмэгтэйчүүдийн эрх, 137 эмэгтэйчүүдийн манлайллын форумууд тус тус байгуулагджээ¹³. Эдгээр форумуудын хүрсэн түүхэн амжилт нь уламжлалт эзэмших эрхийн гэрчилгээ (УДОСЭГ) олгох замаар 1,197 эмэгтэйн газар өмчлөх эрхийг бодитоор баталгаажуулсан явдал байв. Үүнээс гадна 1,395 эмэгтэйн газрыг албан ёсны бүртгэлд оруулж албажуулжээ. БМЭЗ болон түнш байгууллагууд 2026 оны эцэс гэхэд эдгээр эмэгтэйчүүдэд УДОСЭГ-г бүрэн олгуулахаар идэвхтэй ажиллаж байна¹⁴.

Манлайллыг дэмжих эдгээр санаачилга нь 5,000 гаруй эмэгтэйд хүрч, улмаар 2025 он гэхэд тосгон, дүүргийн удирдлагад 748 эмэгтэй сонгогдох хөшүүрэг болжээ¹⁵. Танзани улсын хуулиар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн газрын тэгш эрхийг баталгаажуулдаг ч газар албажуулах практикт өрхийн тэргүүн болох эрчүүд давуу эрх эдлэх хандлага давамгайлж, эмэгтэйчүүдийн газар ашиглалт, шийдвэр гаргах эрх хязгаарлагдмал хэвээр байна¹⁶. Гэсэн ч малчин эмэгтэйчүүд засаглалын шийдвэрлэх тоглогч болж өрхийн амьжиргаа, аюулгүй байдлын суурь болсон усны эх үүсвэр, суурьшлын бүс, малын нүүдлийн зурвас хамгаалахын тулд эмэгтэйчүүдийн бүлэг, тосгоны зөвлөл, газрын хороодоор дамжуулан идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлж байна. Эмэгтэйчүүдийн оролцоо засаглалын ил тод байдлыг нэмэгдүүлж, зөрчил маргааныг шийдвэрлэх механизмыг бэхжүүлэхээс гадна газар ашиглалтын шийдвэрийн нийгмийн үр нөлөөг бас нэмэгдүүлдэг. Энэ бол бэлчээрийн тогтвортой засаглал, отор нүүдлийг хадгалахад жендэрийн мэдрэмжтэй арга барил туйлын чухал болохыг баталж буй хэрэг юм¹⁷.



Дүгнэлт

Танзани улсын малчдын отор нүүдлийг баталгаажуулах асуудал нь уламжлалт газрын эрхийг хуульчлахаас гадна хамтын өмчлөл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй шийдвэр гаргалтыг хамгаалсан засаглалын тогтолцоотой шууд холбоотой. Үүнд орон нутгийн институтийн чадавх, эмэгтэйчүүдийн манлайллын хослол шийдвэрлэх үүрэгтэй. Отор нүүдэл бол хууль ёсны газрын ашиглалтын хэлбэр гэж хүлээн зөвшөөрөх, эмэгтэйчүүдийг засаглалын голлох оролцогч болгох нь малчдын амьжиргааг тэтгэх, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх, улмаар бэлчээрийн экосистемийн бүтээмж, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд амин чухал ач холбогдолтой.

13. Бэлчээрийн малчин эмэгтэйчүүдийн зөвлөл (БМЭЗ). 2024. Жилийн нөлөөллийн тайлан. Малчин эмэгтэйчүүдийн зөвлөл, Аруша.

Эх сурвалж: Pastoral Women's Council Website

14. БМЭЗ, 2024

15. УХОНУБ, 2025

16. Стэн, Ховард, Маганга, Фаустин П., Одгаард, Ри, Аскью, Келли, болон Сэм Каннингем. 2016. Албан ёсны зааг: Зан заншлын эрх ба Танзани улсын хөдөө аж ахуйн зээлийн хуваарилалт. Хөгжил судлалын сэтгүүл, 52(9): 1306–1319.

17. Дансер, Хелен. 2015. Танзани улс дахь эмэгтэйчүүд, газар ба шударга ёс. Жэймс Карри, Охио их сургуулийн хэвлэл, Афин.

КЕНИ УЛС



Малчдын нүүдэллэх, газар ашиглах, эзэмших эрхэд тулгамдаж буй асуудал, Кени улс

Энн Самантэ, Майньоито малчдын нэгдсэн хөгжлийн байгууллага (ММНХБ)

Кени улсын хуурай болон хагас хуурай бүс нутагт мал аж ахуй нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн тэсвэртэй амьжиргааны хэлбэр байдаг¹. Энэ салбар сая сая хүнийг тэжээн тэтгэхийн зэрэгцээ улсынхаа хүнс, хөдөө аж ахуйн эдийн засаг, экосистемийн зохицуулалтад жинтэй хувь нэмэр оруулж байдаг. Кенийн нүүдлийн малчдад Маа, Борана, Сомали, Туркана, Покот зэрэг олон нийт багтах бөгөөд тэдний аж ахуйн тогтолцоо нь улирлын чанартай, уян хатан отор нүүдлээс шууд хамаардаг². Уг нүүдэл хөдөлгөөн нь дур зоргоороо бус, харин хуурайшилтын болон хур борооны улирлын бэлчээр, усны эх үүсвэр, хужир, малын нүүдлийн зурваст нэвтрэх эрхийг уламжлалт институтүүдээр дамжуулан нарийн зохицуулдгаараа онцлогтой.

Нүүдэл нь зөвхөн мал сүргийг хамгаалаад зогсохгүй соёлын өвөрмөц онцлог, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх, үе дамжсан мэдлэгийг өвлүүлэх, зөрчил маргааныг зохицуулах суурь хөшүүрэг болж байдаг. Настнуудын зөвлөл, насны бүлгийн тогтолцоо, уламжлалт харилцан ашигтай хэлцлүүд нь бэлчээр ашиглалтын орон зай, цаг хугацааг нарийн зааглаж, мал аж ахуйг цаг уурын эрс тэс, тогтворгүй нөхцөлд ч тогтвортой ажиллах боломжоор хангаж байдаг³. Түүхэн туршлагаас үзэхэд, энэ уян хатан байдал нь малчдад бэлчээр нутгаа доройтуулалгүйгээр ган гачиг, үер усны аюул болон байгалийн бусад гэнэтийн цочролд дасан зохицох үндэс болж иржээ.

Гэвч сүүлийн гучин жилд Кени улсын малчдын газрын эзэмшлийн тогтолцоо нь хувьчлал, хамтын фермийн хуваагдал, дэд бүтцийн тэлэлт, байгаль хамгаалал, арилжааны газар тариалан болон олборлох үйлдвэрлэлийн нөлөөгөөр хумигдсаар иржээ. Үүнээс гадна шударга шилжилт, нүүрстөрөгчийн зах зээл зэрэг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах шинэ санаачилгууд бэлчээрийн засаглалд томоохон дарамт болж эхлэв⁴. Эдгээр үйл явц нь дундын бэлчээрийн суурийг ганхуулж, урьд нь нэгдмэл цогц байсан нутаг дэвсгэрийг хашаалсан, зөрчилдөөнтэй орон зай болгон хувиргажээ.

1. Мохамед, Абди Али. 2024. "Уур амьсгалын өөрчлөлтийн Кени улсын малчдын амьжиргаанд үзүүлэх нөлөө". Олон улсын хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл, 5(10). Холбоос: <https://www.ijohss.org/index.php/ijohss/article/view/2>.

2. Ливенга, Е. Т. 2018. "Дорнод Африк дахь малчдын нүүдэл шилжилтийн техникийн болон нийгмийн мэдлэгийн систем". Дорнод Африк дахь мал аж ахуй ба уур амьсгалын өөрчлөлт: 107.

3. Фернандез-Гименез, Мариа Е., болон Соня Ле Фебре. 2006. "Мал аж ахуйн систем дэх нүүдэл шилжилт: Динамик түрэлт уу эсвэл уруудах хандлага уу?". Олон улсын тогтвортой хөгжил болон дэлхийн экологийн сэтгүүл, 13 (5): 341–62.

4. Вангү, Ж.М. 2014. "Кени улсын Мажи Мото дахь бэлчээрийн газрын хувьчлал болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хамт олны чадавх: Газрын эрхийн шинэчлэлийн боломж ба сөрөг үр дагаврууд". Утрехтийн их сургууль, Утрехт. Холбоос: <https://studenttheses.uu.nl/handle/20.500.12932/18385>.

Газрын эзэмшлийн баталгаагүй байдал ба уламжлалт засаглалын доройтол

Газрын удирдлагын хүрээ нь хувьчлал, хашаалсан бэлчээрийг урьтал болгон малчдын уламжлалт эзэмшлийн тогтолцоог улам бүр доройтуулж байна. Улсын түвшний орон зайн төлөвлөлт, хувьчлалын үйл явцын улмаас газар хуваарилах, маргаан шийдвэрлэх, нөөцийг зохицуулах малчдын засаглах эрх мэдэл хумигдах болов. Түүнчлэн, малчдын нүүдлийн зурвасыг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөөгүйгээс болж байгаль хамгаалал, дэд бүтэц, арилжааны зориулалтаар газар хураан авах үед малчид уламжлалт эрхээ хамгаалж чадахгүйд хүрчээ. Тухайлбал, Лайкипиа, Самбуру зэрэг бүс нутагт элитүүд газрыг хяналтдаа авснаар малчдыг шахан гаргаж, бэлчээрийн хүртээмжийг бууруулж, түүнээс үүдэлтэй малчид хоорондоо бэлчээрээ булаацалдан зөрчилдөх болжээ.

Мал аж ахуйн газрын эзэмшлийн тогтолцоо дахь малчин эмэгтэйчүүдийн эрх

Газрын баталгаагүй байдлын сөрөг үр дагаврыг малчин эмэгтэйчүүд хамгийн хүчтэй амсдаг. Тэд сүүгээр бүтээгдэхүүн хийж, бог мал маллаж, өрхийн эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэдэг ч мал аж ахуйн бүс нутагт газар өмчлөх албан ёсны эрхгүй байна. Ялангуяа бэлчээрийг хэсэгчлэн хувьчлах үед бэлэвсэн, гэр бүлээ цуцлуулсан, өрх толгойлсон эмэгтэй малчид газар нутгаасаа шахагдах өндөр эрсдэлтэй байдаг. Кажиадо мужид Олгулулуи, Эсэлэнкэй хамтын эзэмшлийн дундын газрыг хувьчилсны дараа эмэгтэйчүүд сүүний чиглэлээр адгуулж буй малын бэлчээрт нэвтрэх эрхээ алдсан. Кийконёкид малчдын газрыг булаан авч буйг эсэргүүцэн, нутгийн малчин эмэгтэйчүүд мужийн дэд комиссарт өргөх бичиг хүргүүлэхээр 20 гаруй километр газар явган алхжээ. Хэдийгээр Хамтын газрын тухай хуулиар (2016) эмэгтэйчүүдийн газар өмчлөх, засаглах салшгүй эрхийг хүлээн зөвшөөрсөн ч тэд уламжлалт болон албан ёсны засаглалд үр дүнтэй оролцож чадахгүй, гадуурхагдсаар байна. Үүнээс үзэхэд жендэрийн тэгш байдлыг хангасан газрын шинэчлэлийн ахиц дэвшил маш удаан, жигд бус байна.

Кени улс дахь малчдын бодит байдал

Кени улсад малчид хоорондоо харилцан хамаарал бүхий олон дарамт, шахалттай нүүр тулж байна. Энэ нь малчдын эрхийг хангалттай хамгаалаагүй үед хөгжлийн хөтөлбөрүүд, байгаль хамгааллын бодлого, уур амьсгалын арга хэмжээнүүд нүүдэл хөдөлгөөн, газрын баталгаат байдлыг хэрхэн сулруулдгийн тод жишээ юм.



Өмнөд бэлчээрийн бүс нутагт хамтын эзэмшлийг хэсэгчлэн хувьчилсан үйл явц, зэрлэг амьтны хамгаалалттай бүсийн тэлэлт, нүүрстөрөгчийн төслүүд олширсон нь уламжлалт бэлчээрлэлтийн тогтолцоог ноцтой алдагдуулжээ.



Эвуасо Кэдонг бүс нутаг (Дээрх зураг)
Эвуасо Кэдонг бүсээс Накуру чиглэлд нүүдэллэдэг малчдын отор нүүдлийн замыг хааж, Кэдонгийн эдлэнгийн дагуу босгосон хашаа.
Гэрэл зургийг: ММНХБ

Найваша дахь Стандарт царигийн төмөр замын бүтээн байгуулалт (дунд талын зураг). Найваша дахь Хуурай портод хүрэх стандарт царигийн төмөр замын барилгын ажил нь зэрлэг амьтад, мал сүргийн нүүдлийн замыг хаажээ. Гэрэл зургийг: ММНХБ

Кени улсын Мажи Мото хамтын эзэмшлийн бүлэг, Маасай эр малынхаа дэргэд зогсож буй нь. Гэрэл зургийг: ЭНС-д зориулж ТониВайлд авав.



Тухайлбал, Имбирикани, Олгулууи зэрэг хамтын эзэмшлийн малчид бэлчээрийнхээ 60 гаруй хувьд нэвтрэх эрхээ алдаж, улмаар мал сүргээ оторлох орон зай улам хумигджээ. Газар нутгийн энэ хомсдол нь 2022–2023 онд болсон хүнд ган гачгийн үеэр бэлчээрийн доройтол, малын хорогдлыг дагуулж, малчид хоорондын зөрчил мөргөлдөөнийг улам хурцатгахад хүргэсэн⁵.



Хойд Кени улсад хэрэгжиж буй нүүрстөрөгчийн томоохон төслүүд, тухайлбал "Хойд бэлчээрийн итгэлцэл" хөтөлбөр нь газрын эрхийн ноцтой зөрчил, тэмцлийг дагуулж байна⁶. Уламжлалт тогтолцооны дагуу газар эзэмшигч талуудтай бүрэн зөвшилцөөгүйгээс малчдын бэлчээрийг нүүрстөрөгчийн кредитийн зах зээлд зориулан тусгаарлах болов. Цаашлаад, зөвхөн бүртгэлтэй газар эзэмшигчид, хамгаалалтын бүсийн элитүүдэд давуу эрх олгосноор уламжлалт институтүүдийг шахан гаргаж, ашиг хуваарилалтаас эмэгтэйчүүдийг улам бүр гадуурхаж байна. Үүний улмаас малчид амин чухал бэлчээр, усны эх үүсвэр, нүүдлийн зурвасаа алдахад хүрчээ. Малчдын амьжиргааг үгүй хийж, хамтын эзэмшил, отор нүүдлийг үл тоомсорлон зах зээлийн зарчмаар хэрэгждэг уур амьсгалын шийдлүүд хэрхэн бүтэлгүйтэж байгааг эндээс харж болно.



Найваша дахь Олкариа газрын гүний дулааны цахилгаан станц нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээ нэртэй халхавч дор мал аж ахуйн тогтолцоог боомилж буй дэд бүтцийн төслийн бас нэг жишээ юм. Худаг, дамжуулах хоолой, зам харгуй барих энэ мега төсөл нь улирлын чанартай бэлчээрийн хүртээмжийг хязгаарлаад зогсохгүй, үржил шимтэй газарт хогийн ургамал тархан ургах нөхцөл бүрдүүлжээ. Түүнчлэн өндөр даралтын хоолойнууд эвдэрч сүйдэх үед малчид гал түймрийн аюулд өртөх, хүн бэртэх, мал хорогдох эрсдэлтэй тулжээ. Газрын гүний дулааны худгуудаас ялгарах хий, дуу чимээ, эвгүй үнэр нь ойр орчмын бэлчээрийг ашиглах боломжгүй болгосноор отор нүүдлийн орон зай улам хязгаарлаж, үлдсэн бага хэмжээний бэлчээрт ирэх ачааллыг эрс нэмэгдүүлсэн байна.



Исиоло болон Марсабит мужуудад хувийн хашаа, хамгаалалтын бүс хяналтгүй олширсон нь хуурайшилтын улиралд мал оторлох уламжлалт нүүдлийн орон зайг хаах болжээ. Отор нүүдлийн орон зайг хязгаарласан эдгээр хаалт нь гантай жилүүдэд малын хорогдлыг шууд нэмэгдүүлж, малчдын амьжиргааг шууд доройтуулдаг. Нүүдэл хөдөлгөөн хумигдсанаар өвс, усны төлөөх тэмцлийг өдөөж, малчид хоорондын зөрчил маргаан улам хурцдав.



Туркана, баруун Покот мужийн Түрквэл, Кэрио голын хөндий дагуух газар тариалан, суурьшлын бүс тэлснээр уламжлалт бэлчээр нутаг, голын савд малаа бэлчээдэг нөөц газруудыг түрэн эзэлж байна. Эдгээр өөрчлөлт нь малчдын байгалийн нөөцөөс хүртэх боломжийг хязгаарлан, малын хорогдлыг өсгөхийн зэрэгцээ нүүдлийн орон зай дагуух баялгийн хуваарилалтыг зохицуулж, зөрчил шийдвэрлэх уламжлалт механизмыг сулруулж байна.



Малчид (дээрх зураг) Малын аж ахуйн бүс нутагт дэд бүтцийн бүтээн байгуулалт явагдсанаас малаа хариулагчдын олноороо шилжин суурьшиж байна. Гэрэл зураг: MPIDO

Найвашагийн хуурай порт (Дунд талын зураг) Найвашагийн хуурай порт нь мал сүргийн нүүдлийн орон зай, бэлчээрлэлтийн амин чухал бүсийг хааж баригдсан байдал. Гэрэл зургийг: ММНХБ

Малчин эмэгтэйчүүд тэмцэж буй нь (Хамгийн доорх зураг) Кийконёки малчдын итгэмжлэгдсэн газрын малчин эмэгтэйчүүд өөрсдийн газрыг булаан авсны эсрэг баруун Кажидо мужийн дэд комиссарт эсэргүүцлийн өргөх бичиг барихаар 20 гаруй километр газар явган алхаж байгаа нь. Гэрэл зургийг: ММНХБ

5. Макена, Бетти. 2024. "Кени улсад ган гачиг, үер огцом ээлжлэн тохиолдох үйл явдалд хийсэн дүн шинжилгээ ба тэдгээрийн нөлөөлөл." Небраска Линкольны Их Сургууль. Үзэх: <https://digitalcommons.unl.edu/cgi/viewcontent.cgi?article=1395&context=natresdiss>.
6. Аннемиек Пас, Элизабет Э. Ватсон, Билал Батт. 2023. "Газар эзэмшилд гарч буй өөрчлөлт: Кени улсын хойд хэсэгт олон нийтийн байгаль хамгааллын жишээ." Улс төрийн газарзүй, 106. doi:10.1016/j.polgeo.2023.102950.



Найваша орчмын Кэдонг нутаг дэвсгэр дэх дэд бүтэц, аж үйлдвэрийн төсөл малчдын отор нүүдэлд хэрхэн давхар дарамт болдгийг бэлхнээ харуулж байна. Кэдонг нь түүхэндээ бэлчээрийг усны эх үүсвэр, хужир, мал гарамлах цэгүүдтэй холбодог улирлын чанартай нүүдлийн амин чухал зам байв. Гэвч 1,000 акр (ойролцоогоор 404 га) талбайг хамарсан Найвашагийн хуурай порт, 6,000 акр (ойролцоогоор 2428 га) талбай бүхий эдийн засгийн тусгай бүс, стандарт царигийн төмөр зам зэрэг мега төслүүд зэрэгцэн хэрэгжсэнээр газар нутгийг ихээр хашаалж, тусгаарласан. Эдгээр бүтээн байгуулалт малын уламжлалт нүүдлийн орон зайг хааж, нарийсгасан бөгөөд үүнээс болж малчид малаа бэлчээхдээ илүү урт, илүү эрсдэлтэй замаар явахаас өөр аргагүйд хүрсэн. Улмаар мал туйлдах, малын хорогдол нэмэгдэх, үлдсэн нээлттэй бэлчээрийн ачаалал хэтрэх, уламжлалт бэлчээрийн менежментийн тогтолцоо мөхөх зэрэг сөрөг үр дагавар гарч байна. Мөн хуурай порт, эдийн засгийн тусгай бүсийг дагасан суурьшил тэлж, амьжиргааны хэлбэрүүд төрөлжсөн нь Кэдонг дахь малчдын отор нүүдэл, газар ашиглалтын дүр төрхийг сууриар нь өөрчилж байна.



Малчид бэлчээрийн замаа эргүүлэн авч буй нь Засгийн газрын нөлөө бүхий эрхмүүдийн ухсан шуудууг малчид буцаан дүүргэж, уламжлалт малын бэлчээрээ эргүүлэн авч байна. Гэрэл зургийг: ММНХБ



ОУБМ-ын жилийн хүрээн дэх нөлөөллийн ач холбогдол, сургамж

Малчдын газрын баталгаат байдал нь отор нүүдэл, байгалийн нөөцийн хүртээмж болон жендэрийн тэгш байдалтай салшгүй холбоотой. Бэлчээр нутгийн хуваагдал нь мал сүргийн амьд үлдэх үндэс, хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал, газрын тогтвортой менежментэд шууд заналхийлж байна.

БОЛИВИ УЛС – АНДЫН НУРУУ



Бэлчээрийн хуваагдал ба мал аж ахуй тогтворгүй байдал: Айлью Кари Бажагийн кейс, Боливи улс

Арминда Веласко Торрез

Судалгаанд Боливи улсын Ла Пас мужийн төв өндөрлөг бүсэд, далайн түвшнээс дээш дунджаар 3,987 метрийн өндөрт орших Пакажес мужийн Какиавири засаг захиргааны нэгжийн уугуул иргэдийн "Кари Бажа" айлью хамрагдсан болно.

Андын нурууны экосистемийн байгалийн өвөрмөц тогтоц нь хонь, үхэр, тэмээний овгийн мал (лам, альпака) хослон бэлчих бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлсэн. Эдгээр өндөр уулын тал хээрт чиллихуа (Андын ботууль өвс), пажа брава (хатуу ботууль өвс) зэрэг олон наст өвслөг ургамал, чижиг өвс, түүнчлэн бофедалес (Андын өндөр уулын намгархаг, чийглэг нуга) зэрэг тэжээллэг өвс ургамал голлон ургадаг. Тус айльюгийн (олон нийт гэсэн кечуа үг) хувьд мал аж ахуй нь орлогын үндсэн эх үүсвэр төдийгүй уламжлалт ахуй, нийгэм-соёлын үнэт зүйлээ хадгалж, үе дамжуулан өвлүүлэх гол цөм нь болж байдаг.

Сүүлийн жилүүдэд "Кари Бажа" айльюгийн хамт олон бэлчээр нутгийн үе шаттай хуваагдалтай нүүр тулж байгаа бөгөөд шалтгаан нь өв залгамжлалын явцад газрыг хэсэгчлэн хувааж байгаатай холбоотой. Энэ үйл явц нь бэлчээрийн талбайг хумих, малын нүүдэл хөдөлгөөнийг хязгаарлах, тэжээлийн нөөцийн ашиглалтыг хэт нягтаршуулах зэргээр бэлчээрийн мал аж ахуйн тогтолцоонд сөрөг үр дагавар дагуулж байна.

Үүний улмаас өрхийн нийгэм, эдийн засгийн байдал тогтворгүй болж, залуучууд амьжиргааны илүү сайн боломжийг хайн хот суурин газар руу дайжихаас өөр аргагүйд хүрчээ.

Уг судалгааг олон нийтийн зурсан газрын зураг, гишүүдийн бүртгэл, түүхэн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, мөн орон нутгийн удирдлагууд, иргэд, малчидтай хийсэн ярилцлага зэрэг талбарын судалгааны ажилд суурилан гүйцэтгэлээ.



Боливи улс, Андын өндөрлөг бүс ба мал аж ахуй. Гэрэл зургийг: Арминда Веласко Торрез болон АУИБЗХ (Андын уугуул иргэдийн байгууллагуудын зохицуулах хороо)

Айлью Кари Бажа дахь нөхцөл байдал

Колоничлолын өмнөх үеэс уламжлалтай өвөг дээдсийн нутаг болох Кари Бажа айлью (уугуул олон нийт) нь Боливи улсын Үндсэн хуулийн 2, 30, 403 дугаар зүйл, 2019 оны Дээд шийдвэр (№428)-ийн дагуу албан ёсны статус нь хүлээн зөвшөөрөгдсөн, өөрийн "үндсэн дүрэм", "дотоод журам"-аар зохицуулагддаг бие даасан хуулийн этгээд юм.

Энэхүү кэйс судалгаанд 1952 оны Газрын шинэчлэлийн баримтыг түүхэн лавлагаа болгон авч ашиглалаа. Олон нийтийн удирдлагуудын тэмдэглэснээр, тухайн үед тус айлью нь уламжлалт газар эзэмших эрх бүхий 13 саяаньеро (уугуул малчин өрх)-оос бүрдэж байсан бөгөөд нэг өрхөд дунджаар 85 га газар ногдож байжээ. Энэ газар нутагт хонь, үхэр, лам гөрөөс адгуулах бэлчээрийн олон төрөлт аж ахуйн тогтолцоог эрхэлдэг байсан. Уг амьдралын хэв маяг нь уугуул малчин өрхүүд нийгэм, эдийн засаг, байгаль орчны уламжлалт зан заншлаа үе дамжуулан тогтвортой өвлүүлж ирсэн суурь нөхцөл болж байжээ.



Өдгөө, олон нийтийн гишүүнчлэлийн бүртгэл, Газрын шинэчлэлийн үндэсний хүрээлэнгийн баримтын дагуу, мөн үе дамжсан өв залгамжлалын үр дүнд нийт 50 өрхийн (60 хувь нь эрэгтэй, 40 хувь нь эмэгтэй) өмчлөх эрх баталгаажсан байна. Тодруулбал, нэг өрхөд дунджаар 21.97 га бэлчээр ногдож, айлью бүхэлдээ 1,098.49 га талбайг өмчилж буй хэрэг юм.

Боливи улс, Андын өндөрлөг бүс болон мал аж ахуй. Гэрэл зургийг: Арминда Веласко Торрез болон АУИБЗХ (Андын уугуул иргэдийн байгууллагуудын зохицуулах хороо)

Газрын гэрчилгээтэй 50 өрхөөс ердөө 15 нь л орон нутагтаа байнгын оршин сууж, уламжлалт мал аж ахуйгаа үргэлжлүүлэн эрхэлж байна. Үлдсэн хэсэг нь хот суурин газар луу шилжсэн бөгөөд зөвхөн газар өмчлөх эрхээ хамгаалах зорилгоор орон нутагтаа оршин суугаа олон нийттэйгээ албан байдлаар л холбогддог. Энэ олон нийтийн хот руу нүүх нүүдэл нь олон шалтгаантай байж болох юм.

Уламжлалт удирдагч (Мама Талла) Валериа Алварадо М. онцлохдоо, гэрчилгээжсэн газар нь өрхийн (цөм гэр бүл) хэрэгцээг төдийлөн хангадаггүй. Учир нь ихэнх тохиолдолд газрыг насанд хүрсэн хэд хэдэн ах дүүс дундаа хуваан эзэмшдэг бөгөөд энэ нь өрхийн гишүүд аж ахуйн эрхлэн бие даан

амьжиргаагаа тэтгэх боломжийг хаадаг. Газрын гэрчилгээний бүртгэлээс үзэхэд нэг гэрчилгээний ард дунджаар гурван хамтран эзэмшигч байгаа бөгөөд үүний улмаас нэг өрхөд ногдох бодит ашиглалтын талбай 7.3 га болтлоо буурчээ¹.

Газрын энэ хуваагдал туйлын ноцтой түвшинд хүрсэн. Нэг өрхөд ногдож буй 7.3 га талбайд жилд ердөө 18 хонь эсвэл 1.5 бод малыг л тэжээх боломжтой бөгөөд энэ нь өрхийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад хангалтгүй юм. Үүнээс үүдэн бэлчээр хуваагдаж, малчин өрхүүд хот суурин газар руу дайжих болжээ.

Хөдөөгийн малчид, тариачдын бүтээгдэхүүний үнэ олон жилийн турш хэт доогуур байсаар ирсэн нь дээрх хямралыг улам даамжруулж байна. Уугуул иргэдийн олон нийтийн удирдагч (Малку) Тата Валдо Копагийн тэмдэглэснээр, түүхэн хугацаанд хөдөө аж ахуйн салбар өөрийн бүтээгдэхүүнээ бодит үнээр нь зах зээлд гаргаж чадалгүй иржээ. Түүн дээр нэмээд, бэлчээр услах, ургац нэмэгдүүлэх, бэлчээрийн экосистемийн тэжээлийн чанарыг сайжруулах чиглэлээрх өрхийн амьжиргааг тэлэх төрийн зохицуулалт, хур борооны ус хуримтлуулах хөтөлбөрүүд дутагдаж байгаа нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна.

Нутагтаа үлдсэн 15 өрх дунджаар 36 хонь, 7 үхэр, 6 лам гөрөөс бүхий мал сүрэгтэй байна. Ийм тооны мал сүрэг адгуулах боломжтой болсон нь хур борооны улиралд бэлчээрийг бүрэн хааж амрах, усны түвшин багасах хуурайшилтын үед нэмэлт тэжээл болгох зорилгоор арвай тариалах, хот руу шилжин суурьшсан олон нийтийн бэлчээрийг түрээслэх зэрэг бэлчээрийн удирдлагын олон стратегийг зэрэгцүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм.

Кари Бажа айлью нь Үндсэн дүрэм болон Дотоод журмынхаа хүрээнд хүйсийн тэгш эрх, харилцан нөхөх уламжлалт зарчмыг засаглалдаа мөрддөг. Практикт аж ахуйн удирдлага, мал сүргийн өдөр тутмын маллагааг голдуу эмэгтэйчүүд хариуцдаг, харин малаас гаралтай бүтээгдэхүүн зарж борлуулах удирдах эрхийг эрчүүд хариуцдаг бөгөөд энэ ажлыг нутагтаа үлдсэн 15 өрхийн ердөө дөрвөн эрэгтэй л хийж байна. Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулах, бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой тогтолцоог хадгалахын тулд орон нутагтаа үлдсэн эмэгтэйчүүд хүүхдүүдийн боловсрол, чадавхжуулах сургалтыг нэн тэргүүнд дэмжих шаардлагатай байна.



Айлью олон нийтийн хурлын үеэрх хэлэлцүүлэг. Гэрэл зургийг: Арминда Веласко Торрез болон АУИБЗХ

Малчин эгч дүүсийн ярилцлага. Гэрэл зургийг: Арминда Веласко Торрез болон АУИБЗХ



1. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн газар эзэмшигчдийн ах дүүсийн хоорондын мэдээлэл солилцоо



Дүгнэлт

Боливи дахь Айлью хамт олонд нүүрлээд буй мал аж ахуйн нийгэм-эдийн засаг, байгаль орчны хямрал болон хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний гол шалтгаан нь өв залгамжлалаас үүдэлтэй бэлчээрийн газрын үе шаттай хуваагдал юм.

Газрын энэ хумигдал нь мал аж ахуйн тогтвортой байдлыг алдагдуулж, өрхийн амьжиргаанд ноцтой эрсдэл учруулсаар байна. Уг сорилтын өмнө эмэгтэйчүүд уламжлалт аж ахуйг тогтвортой авч үлдэхэд голлох үүрэг гүйцэтгэдэг боловч тэднийг орхигдуулах байдал нийтлэг байна.

БОЛИВИ УЛС – НАМ ДОР ГАЗАР



Гварани олон нийт дунд үүссэн усны нөөц, бэлчээрийн засаглал дахь жендэрийн ялгаа, Боливи улс

Лурдес Баигорриа Гузман

Энэхүү кэйс судалгааг Боливи улсын Санта Круз мужийн Шарагуа Иямбаэ Гварани өөрөө удирдах нутаг дэвсгэрийн Папитигуасу бүсэд орших Итатики, Сан Антонио дэл Парапети олон нийтийн дунд хийж гүйцэтгэлээ. Сан Антонио дэл Парапетид 360 өрх, Итатикид 41 өрх амьдардаг.

Эмэгтэйчүүдийн аж ахуйн ажил, шийдвэр гаргах түвшин дэх (хурал болон удирдах албан тушаал дахь) оролцооны зөрүү

Судалгаанд хамрагдсан олон нийтийн дунд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн уламжлалт үүрэг хариуцлагын тэнцвэргүй байдал хадгалагдсаар иржээ. Ярилцлагад хамрагдсан оролцогчид: эмэгтэйчүүд бог¹, эрчүүд бод² мал маллах үүрэгтэй гэж тодорхой заагласан. Бог мал маллахыг эмэгтэйчүүдийн гэр ахуйн ажлын үргэлжлэл гэж үзэх хандлага давамгайлдаг. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд ээж, эхнэр, охины хувиар хоол хийх, хувцас угаах, хүүхэд асрах зэрэг өдөр тутмын гэрийн ажлынхаа хажуугаар бог малаа бас малладаг байна.

Гварани олон нийтийн газар өмчлөл нь дундынх байдаг тул мал аж ахуйн хамтын төслүүдийг хөгжүүлэх шаардлагатай болгожээ. Эдгээр төслүүд нь хур борооны ус хуримтлуулах, усан сан байгуулах, бэлчээрийн ургамалжилтыг зохицуулах, ойн бэлчээрийн аж ахуйн тогтолцоог нэвтрүүлэх, мөн тэжээл бэлтгэж хадгалах зэрэг арга техникүүдийг хэрэгжүүлж байна. Итатикид мал аж ахуйн төсөл амжилттай хэрэгжсэн бол, Сан Антонио дель Парапетигийн төсөлд зарим хүндрэл тулгарсан ч өдгөө тэдгээрийг амжилттай шийдвэрлэн ажиллаж байна.

Хоёр төслийн үеэр малчдын дунд уулзалт, зөвлөгөөн, бүх нийтийн хурал, сургалт зохион байгуулж, санхүү болон техникийн туслалцаа үзүүлэхэд анхаарчээ. Хэдийгээр эмэгтэйчүүд эдгээр хурал, цуглаанд тогтмол оролцдог ч хэлэлцүүлэгт идэвхгүй сууж, санал бодлоо илэрхийлэх нь ховор байдгийг ярилцлагад оролцогчид тэмдэглэв. Энэ нь шийдвэр гаргах үйл явц дахь жендэрийн тэгш байдалд томоохон цоорхой байгааг илтгэж байна. Гэсэн ч засаглалын бүтцэд тодорхой ахиц дэвшил аажмаар гарч байна. Тухайлбал,

1. Бол малыг голчлон гэр бүлийн хэрэгцээнд зориулан малладаг бөгөөд зарим тохиолдолд бэлэн мөнгөний орлого олох зорилгоор ямаа, гахай, гэрийн тэжээвэр шувуу тэжээдэг.

2. Бод мал нь үндсэндээ үхрээс бүрдэнэ.

Сан Антонио дель Парапети олон нийтийн удирдах зөвлөлийн жендэрийн асуудал хариуцсан чиг үүргийг эмэгтэй хүн хашиж байгаа бөгөөд Итатики олон нийтийн нярвыг мөн эмэгтэй хүн хашиж байна.

Газар ашиглалт, дэд бүтэцтэй холбоотой шийдвэр гаргалтад эмэгтэйчүүд оролцоход тулгарч буй институцийн болоод соёлын саад

Гварани олон нийтийн хувьд газар, ой мод, усны эх үүсвэрийн ашиглалтыг өөрсдийн ертөнцийг үзэх уламжлалт үзлийн дагуу зохицуулдаг. Газар ашиглалт, мал аж ахуйн дэд бүтцийн байршлын талаарх шийдвэрийг бүх нийтийн хурлаар шийдвэрлэдэг.

Судалгаанд хамрагдсан хоёр олон нийтийн хувьд, үхэр өмчлөх эрхийг өрх гэрийн түвшинд (эрэгтэй өрхийн тэргүүнтэй айлд) олгодог. Мөн 18-аас дээш насны ганц бие эсвэл бэлэвсэн эмэгтэйчүүдэд үхэр өмчлөх эрх олгохыг өөрсдийн дотоодын дүрэмдээ зөвшөөрдөг. Малчид атар газар, ойн бүсэд мал хариулах эрхтэй. Харин газар ашиглалтын бүсчлэл, мал аж ахуйн дэд бүтцийн байршлыг тогтоох чухал шийдвэрүүдийг мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийн техникийн шалгуурт үндэслэн, бүх нийтийн хурлаар хэлэлцэж эцэслэн тогтоодог байна³.

Мал аж ахуйн төслийг хэрэгжүүлэх үйл явц нь: i) оролцоонд тулгуурласан төлөвлөлт, ii) үйл ажиллагааны хэрэгжилт, iii) өрхүүдийг сургаж чадавхжуулах, iv) удирдлага менежмент гэсэн дөрвөн үндсэн үе шаттай байдаг. Ярилцлагад оролцсон эмэгтэйчүүдийн хэлснээр, тэд оролцоонд тулгуурласан төлөвлөлтийн эхний шатанд биеэр оролцдог ч олонх нь хэлэлцүүлгийн явцад өөрсдийн дуу хоолой, санал бодлоо илэрхийлэхээс зайлсхийх хандлагатай байдаг. Хоёр дахь үе шатын үеэр эмэгтэйчүүд дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэж буй эрчүүдэд хоол хүнс бэлтгэх замаар уг үйл явцад зөвхөн туслах үүрэгтэйгээр оролцдог. Харин гурав болон дөрөв дэх үе шат болох сургалт, удирдлагын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд бараг оролцдоггүй бөгөөд үүнийг ерөнхийдөө эрэгтэйчүүдийн хариуцах ажил гэж үзэх уламжлалт хандлага давамгайлж байна. Энэ нөхцөл байдал нь эмэгтэйчүүдийг сургалт, үйл ажиллагаанд оролцохоор олон нийтийн дундаас гарах боломжийг хязгаарладаг соёлын саад бэрхшээл буюу жендэрийн хэвшмэл үүрэгтэй шууд холбоотой. Тухайлбал, зөвхөн нөхрөөсөө зөвшөөрөл авсан эмэгтэйчүүд, эсвэл тэдний чадавх, итгэл үнэмшлийг үгүйсгэдэг жендэрийн өрөөсгөл хандлагатай байнга нүүр тулдаг ганц бие эмэгтэйчүүд л сургалтад хамрагдах боломжтой байдаг. Эмэгтэй удирдагчдын оруулж буй хувь нэмрийг бүрэн хүлээн зөвшөөрч чадахгүй шүүмжлэх, дэмжихгүй байх явдал зөвхөн эрчүүдээс биш, харин олон нийтийн дундах бусад эмэгтэйчүүдийн зүгээс ч мөн гардаг байна.

Эмэгтэйчүүд өөрсдийн газар нутгийн хэмжээ, байгалийн онцлог, хил заагийн талаарх мэдээлэл дутмаг байна. Зарим эмэгтэйчүүд бичиг үсэг тайлагдаагүй тул төслийн удирдлагын үйл явцад оролцоход хүндрэл үүсдэг. Эмэгтэйчүүдэд мал аж ахуйн менежментийн төрөлжсөн сургалт дутагдаж байгаагаас гадна, гэрийн ажил, нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаасаа болж тэдний мал аж ахуйн төслүүдэд ажиллах боломж багасдаг байна.

3. Худаг, усан сан, бэлчээр, малын хашаа, үхэр хаших хашаа.

Өмчлөх эрхээ эдлэх нь: Мал өмчлөл ба бэлчээр ашиглах эрх

Судалгаанд хамрагдсан хоёр олон нийт нь газрын хамтын гэрчилгээ бүхий Парापитугуасугийн Уугуул иргэд-тариачдын нутаг дэвсгэрт (УИТНД) нүүдэллэн амьдардаг.

Эдгээр олон нийтийн эрэгтэй, эмэгтэй гишүүдийн аль аль нь нутаг дэвсгэр, газар, усны эх үүсвэр, ой модыг тогтвортой ашиглах ижил эрхтэй бөгөөд энэ нь тэдэнд бод, бог мал хавсран маллах боломжийг олгодог байна. Гэвч мал аж ахуйн төслүүдийн хүрээнд шийдвэр гаргах, удирдах албан тушаалыг голчлон эрчүүд хашиж байгаа нь жендэрийн ялгаа байсаар байгааг тод илтгэнэ. Мал аж ахуй нь хоёр олон нийтийн амьжиргааны гол тулгуур хэдий ч, эмэгтэйчүүд удирдах болон төлөөллийн түвшний шийдвэр гаргалтад оролцох боломж дутмаг хэвээр байна.

Судалгааны ярилцлагаас үзэхэд, мал аж ахуйн төслүүд нь олон нийтийн дотоод дүрэм, журмын хүрээнд хэрэгждэг аж. Хэдийгээр дүрэмд бичгээр тодорхой тусгаагүй ч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй ижил түвшинд мал өмчлөх, төслийн үр шимийг тэгш хүртэх эрхтэй гэж эдгээр төслүүд хүлээн зөвшөөрдөг. Улмаар 18 наснаас эхлэн гэрлэлтийн байдлаас үл хамааран эрэгтэй, эмэгтэй хүмүүс мал аж ахуйн төслийн өмчлөлд бие даан оролцох эрхтэй гэж олон нийт үздэг. Өөрөөр хэлбэл, олон нийт нь эмэгтэйчүүд өмчийн эрхээс гадуурхагддаггүй, тэднийг газар нутгаа нөхөн сэргээх, хамгаалах үйл явцын гол оролцогч хэмээн хүлээн зөвшөөрдөг аж.

Тус хоёр олон нийтийн хувьд тогтвортой мал аж ахуйг хөгжүүлсний үр шим илт тодорхой харагдаж байна. Уг үйл явц нь газар нутгийн засаглалыг бэхжүүлэх, нийгэм, эдийн засаг, байгаль орчны эрсдэлийг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах замаар өрхийн амьжиргаа, сайн сайхан байдлыг дээшлүүлж⁴, байна. Түүнчлэн мал аж ахуйн менежмент болон захиргааны үйл ажиллагаанд орон нутгаас бэлтгэгдсэн идэвхтнүүд оролцож байгаа нь тухайн олон нийтийн дотоод чадавх тогтвортой хөгжиж буйн тод илрэл юм.



Уугуул иргэд-тариачдын нутаг дэвсгэр дэх хүртээмжтэй засаглал бэхжүүлэх зөвлөмж



Шинэчлэгдэж буй мал аж ахуйн төслийн дүрэм, журамд эмэгтэйчүүдийг эрчүүдийн адил бүрэн эрхт үр шим хүртэгч хэмээн албан ёсоор тодорхой зааж, тэднийг шийдвэр гаргах болон удирдах түвшний албан тушаалд ажиллах эрхийг институтийн хувьд баталгаажуулах



Гварани эмэгтэйчүүдэд зориулсан: мал аж ахуйн менежментийн техник, төслийн удирдлага, захиргааны тухай сургалтын модулиуд боловсруулах. Ингэхдээ эдгээр хөтөлбөрийг эмэгтэйчүүдийн амьдралын бодит нөхцөл байдал, бичиг үсгийн тайлагдалтын түвшин, Гварани эх хэлний онцлогт тохируулахаас гадна тэдний хүүхэд асрах үүрэг хариуцлагад нийцүүлэх нь чухал байна.

4. Гэр бүлийн хэрэглээ, сургуулийн өглөөний цайнд зориулсан сүү, түүнчлэн мах, бяслаг, бусад дагалдах бүтээгдэхүүнүүд.

ПЕРУ УЛС



Паскогийн хөдөө, орон нутгийн засаглал: Малчин эмэгтэйчүүдийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээл, Перу улс

Луис Виттор болон нэрээ нууцалсан оролцогч

Перу улсад малчдын аж амьдралыг зохицуулдаг дотоод хэм хэмжээ, дүрэм журам нь малчин эмэгтэйчүүдийн байгалийн нөөц баялаг, түүний дотор бэлчээр нутагт нэвтрэх, ашиглах, хяналт тавих эрхийг хүлээн зөвшөөрч баталгаажуулах, эсвэл хязгаарлах, улмаар бүрмөсөн гадуурхан хасах эсэхийг тодорхойлдог. Тус судалгаагаар Паско мужид байрлах Сан Франциско де Асис де Ярусакан (2014), Сан Хуан де Янакачи (2015), Санта Ана де Туси (2021) хэмээх олон нийтийн дунд мөрдөгдөж буй дотоод дүрэм журамд жендэрийн харьцуулсан дүн шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

Хамтран өмчлөгчийн статус ба олон нийтийн бүртгэл дэх тэгш оролцоо

Хамтран өмчлөгчийн тодорхойлолт (эрэгтэй эсвэл эмэгтэй) нь хөдөөгийн фермер олон нийтийн дундах эрх зүйн харилцааг зохицуулах үндсэн механизм юм. Ярусакан болон Янакачуудын хувьд дотоодын дүрэм журамд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хамтран өмчлөгч гэж албан ёсоор хүлээн зөвшөөрдөг боловч практикт "өрхийн тэргүүн" гэх уламжлалт ойлголт эсвэл "нэг гэр бүлээс нэг л хамтран өмчлөгч бүртгэх" гэсэн хязгаарлалт байсаар байна. Тухайлбал, Ярусаканы дотоод дүрэмд хэрэв хамтран өмчлөгчид нь эхнэр, нөхөр байвал олон нийтийн бүртгэлд зөвхөн "өрхийн тэргүүн"-ийг бүртгэнэ гэж заасан байдаг (17 дугаар зүйл). Түүнчлэн Янакачийн дүрэмд эхнэр, нөхөр хоёулаа зэрэг хамтран өмчлөгч байхыг шууд хоригложээ (27 дугаар зүйлийн "д" заалт). Эдгээр бүтцийн хязгаарлалтын улмаас эмэгтэй хамтран өмчлөгчид албан ёсны бүртгэлийн гадна хоцорч, өөрсдийн хууль ёсны эрхээ эдлэх боломжгүй болдог. Харин Туси олон нийтийн хувьд эрэгтэй, эмэгтэй хамтран өмчлөгчдөд албан ёсны тэгш эрх олгосноор (10 дугаар зүйл) уг тогтолцоонд мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргажээ. Тус зохицуулалт нь дүрмийн заалтыг хоёрдмол утгаар тайлбарлах тодорхойгүй байдлыг бууруулаад зогсохгүй, эмэгтэйчүүд бие даасан эрхийн субъект болох хууль зүйн аюулгүй байдал, баталгааг эрс сайжруулж байгаа юм.



Перу улсын Паско мужид буй Кевин Олазо Паредес. Гэрэл зургийг: Луис Виттор, Нэрээ нууцалсан оролцогч, АУИБЗХ

Бэлчээр ашиглах эрх ба бэлчээрийн даац

Дотоод дүрэм, журмын хүрээнд бүх нийтийн хурал нь бэлчээрийн талбай, хэмжээ, малын тоо толгойн дээд хязгаар, бэлчээрийн байршил зэрэгт хяналт тавьдаг зохицуулалттай. Бэлчээрийн газрыг ашиглах, үр шимийг нь хүртэх эрх тухайн малчны "шаардлага хангасан хамтран өмчлөгч" эсэх статусаас шууд хамаардаг. Практик дээр энэ зохицуулалт нь хамтран өмчлөгчийн статус нь хүлээн зөвшөөрөгдөөгүй, эсвэл зөвхөн нөхрөөсөө хамааралтай байдаг эмэгтэйчүүдийг давхар гадуурхах нөхцөлийг бүрдүүлдэг аж. Ярусаякан (20 дугаар зүйл), Янакачи (31-ийн "а" заалт), Туси (75 дугаар зүйл) олон нийтийн дотоод дүрмийн дагуу зөвхөн албан ёсны бүртгэлд хамрагдсан өмчлөгчид л газар болон бэлчээрийн талбай ашиглах эрх эдэлдэг. Уг шалгуурын улмаас Ярусаякан болон Янакачи олон нийтийн дунд өдөр тутмын бэлчээрлэлтийг гардан удирддаг гэрлэсэн малчин эмэгтэйчүүд газар хуваарилах өргөдөл гаргах, шаардлага тавих эрхгүй хоцордог. Ингэснээр эмэгтэйчүүдийн хуримтлуулсан мэдлэг, гүйцэтгэх үүргийг системээр орхигдуулахад хүрч байна. Харин Туси олон нийтийн хувьд эмэгтэйчүүдийг хамтран өмчлөгчөөр албан ёсоор хүлээн зөвшөөрснөөр тэд эрчүүдтэй ижил тэгш эрх эдлэх боломжтой болжээ.



Перу улсын Паско мужийн Пукаяку олон нийт. Гэрэл зургийг: Ленин Милла Муныаки (АУИБЭХ)

Олон нийтийн засаглал ба оролцоо

Олон нийтийн удирдлагын албан тушаалд очиход тавигддаг уламжлалт шалгуурууд болох ажилласан жил, ахмад байх, өмнөх туршлага, бүртгэлд хамрагдсан байдал, хурлын ирц зэрэг нь малчин эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд шууд бус саад бэрхшээл болдог аж. Тухайлбал, Ярусаякан олон нийтийн дүрмийн 20 дугаар зүйлд: "бүртгэлтэй хамтран өмчлөгчид сонгох, сонгогдох эрхтэй" гэж заасан ч Ерөнхийлөгчид нэр дэвшихэд заавал "өрхийн тэргүүн" байх шаардлагыг тусгасан нь (63 дугаар зүйл) эмэгтэйчүүдийг далдаар гадуурхах нөхцөл болжээ. Үүнтэй ижил хандлага Янакачи олон нийтийн дунд ажиглагддаг бөгөөд тэдний дотоод дүрмийн дагуу эхнэрүүд нь албан ёсны баримт, зөвшөөрөлгүйгээр нөхрийнхөө өмнөөс хурал цуглаан, аливаа нийтийн ажилд оролцохыг хатуу хориглодог зохицуулалттай (145 дугаар зүйл). Харин Туси олон нийтийн хувьд шаардлага хангасан эмэгтэй, эрэгтэй бүх өмчлөгчид хуралд үг хэлэх, санал өгөх эрхийг ижил түвшинд олгосон (14 дүгээр зүйлийн "д" заалт) нь томоохон ахиц дэвшил болжээ. Тус олон нийтийн дүрэмд удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн төлөөлөл хамгийн багадаа 30 хувиас доошгүй байх квотыг албан ёсоор тогтоосон (30 дугаар зүйл). Уг заалт нь Паско мужийн олон нийтийн дүрмүүд дотор батлагдсан анхны бөгөөд цорын ганц жендэрийн квот бөгөөд Перу улсын үндэсний хууль тогтоомжтой (30982 тоот хууль) бүрэн нийцсэн.

Өв залгамжлах эрхийг шилжүүлэх нь

Бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувьд газар эзэмших эрхийн баталгаа нэн чухалд тооцогддог. Нэр дурдагдсан гурван олон нийтийн дүрэмд хамтран өмчлөгч нас барсны дараа газрын эрх, эзэмшлийг шилжүүлэх харилцааг тусгасан бөгөөд өрх гэр, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах үүднээс бэлэвсэн эхнэр, хүүхдүүдэд давуу эрх олгодог зохицуулалттай. Тухайлбал, Ярусаякан

олон нийтийн хувьд өв залгамжлал нь хүүхдүүдтэйгээ хамтран ашиглах нөхцөлтэйгөөр үлдсэн эхнэр, нөхөр эсвэл хамтран амьдрагчид шууд шилждэг (130 дугаар зүйл). Харин Янакачи олон нийтийн дүрэмд бэлэвсэн эхнэр болон хүүхдэд нь уг өмч шууд өвлөгдөхөөр заажээ (31 дүгээр зүйлийн "и" заалт). Туси олон нийтийн хувьд эзэмших эрхийг эхлээд эхнэр эсвэл нөхөрт нь, дараа нь хүүхдүүдэд шат дараатай олгохоор нарийвчлан зохицуулсан байна (82 дугаар зүйл). Хэдийгээр тус дүрмүүд бэлэвсэн эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулж байгаа ч тэдний аль нь ч өв залгамжлалын дараалал дахь охидын бие даасан эрхийг тодорхой дурдаагүй байна.



Перу улсын Паско мужийн Пукаяку олон нийт. Гэрэл зургийг: Ленин Милла Муныаки (АУИБЗХ)

Үүрэг хариуцлага ба Асран хамгаалах үүргийг хүлээн зөвшөөрөх нь

Албан ёсны бүртгэлтэй хамтран өмчлөгчид дүрмийн дагуу хурал цуглаанд суух, даалгасан ажлуудыг гүйцэтгэх үүрэг хүлээдэг. Гэвч эмэгтэйчүүд хүүхэд болон гэр бүлээ асран хамгаалах үндсэн ачаалалтай байлаа гээд уг албан үүргүүдээс чөлөөлөгдөх явдал практикт нэн ховор бөгөөд үүнээс чөлөөлөгдөх зохицуулалт туйлын хангалтгүй байдаг аж. Судлагдсан дүрмүүдээс зөвхөн Ярусакан (99 дүгээр зүйл) болон Туси (21 дүгээр зүйлийн "е" заалт) олон нийтийн баримт бичигт жирэмсний болон амаржсаны чөлөөг албан ёсоор олгохоор тогтоожээ. Туси олон нийтийн тухайд эмэгтэйчүүд жирэмсэн үедээ зөвхөн хуралд суух үүрэг хүлээдэг бол Ярусаканд төрөхөөс өмнө болон төрснөөс хойш 45 хоногийн хугацаанд тодорхой ажлуудыг гүйцэтгэх, хуралд суух үүргээс бүрэн чөлөөлдөг зохицуулалттай.

Жендэрт суурилсан хүчирхийлэл

Ярусакан болон Янакачи олон нийтийн дүрмүүдэд олон нийт эсвэл гэр бүл доторх жендэрт суурилсан хүчирхийллийг хэрхэн шийдвэрлэх талаар ямар нэгэн эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй. Зөвхөн Туси олон нийт жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах механизмыг институтчилж, хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүүхдүүдийг хамгаалах тогтолцоог бүрдүүлжээ (45 дугаар зүйлийн "д" заалт). Уг механизмын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өрхүүдэд зориулсан тусгайлсан сургалтын хөтөлбөр бий болгох, мөн тэдний сэтгэл зүйн зөвлөгөө, эмчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх зэрэг практик арга хэмжээнүүд тусгагджээ (45 дугаар зүйлийн "е" заалт).



Дүгнэлт

Андын нурууны өндөрлөг газар нутаг дахь мал аж ахуйн тогтолцооны тогтвортой байдал нь олон нийтийн засаглал дахь жендэрийн саад бэрхшээлийг арилгахыг шаардаж байна. Туси олон нийтийн жишээ нь олон нийтийн бие даасан байдлыг эмэгтэйчүүдийн эрхтэй уялдуулан зохицуулж, тэднийг гадуурхахгүйгээр дотоод засаглалаа үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн боломжтойг батлан харуулж байна.

Гурван олон нийтээс хоёр нь (Ярусьякан болон Янакачи) эмэгтэйчүүдийг албан ёсны бүртгэлээс хасдаг механизмтай байгаагаас эмэгтэйчүүдийн баялагт нэвтрэх, ашиглах эрх боомлогдож байна.

Бүртгэлээс хасагдах үйл явц нь малчин эмэгтэйчүүдийг системээс олон байдлаар гадуурхагдах "гинжин нөлөөллийг" үүсгэж байна. Хэрэв тэд албан ёсны бүртгэлд хамрагдаж чадахгүй бол бэлчээрийн талбай хуваарилах өргөдөл гаргах боломжгүй болоод зогсохгүй, олон нийтийн хурал дээр үг хэлэх, санал өгөх эрхээ алдаж, удирдах албан тушаалд сонгогдох боломжгүй болдог.

Дотоод дүрмийн шинэчлэл, инновацыг амжилттай нэвтрүүлсэн Туси олон нийт удирдах зөвлөлдөө эмэгтэйчүүдийн 30 хувийн квотыг институтчилж, жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэх албан ёсны механизмыг бүрдүүлжээ. Түүнчлэн хүн бүрийн оролцоог тэгш хангасан нэр томьёо, үг хэллэгийг журамдаа тусгаж, уламжлалт институтийн саадуудыг устгасан байна.



RIGHTS +
RESOURCES

